



ЖЕНДЭРИЙН
ҮНДЭСНИЙ ХОРОО



Japan
Fund for
Poverty
Reduction



From
the People of Japan

ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ЗАЛУУ МАЛЧДЫН АМЬДРАЛ АХУЙ ДАХЬ ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ



Улаанбаатар хот
2021 он



Japan
Fund for
Poverty
Reduction



*Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банк хамтран
Ядуурлыг бууруулах Япон сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй
"Иргэний нийгмийн оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь"
техникийн туслалцааны төслийн хүрээнд хэвлэв.*



ЖЕНДЭРИЙН
ҮНДЭСНИЙ ХОРОО



Japan
Fund for
Poverty
Reduction



From
the People of Japan

ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ЗАЛУУ МАЛЧДЫН АМЬДРАЛ АХУЙ ДАХЬ ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

© 2021

Монгол Улсын Засгийн газар
Жендэрийн үндэсний хороо

Судалгааны дүн шинжилгээг бичсэн:

Зөвлөх: С.Түмэндэлгэр, доктор, дэд проф
Ц.Одгэрэл, докторант
Т.Бүрэнжаргал доктор, проф

Судалгааны дүн шинжилгээг хянан тохиолдуулсан:

Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба:

Дарга	Т.Энхбаяр
Ахлах мэргэжилтэн	Х.Цэнджав Д.Энхжаргал

Азийн Хөгжлийн Банк:

Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газрын
Нийгмийн хөгжил, жендэрийн асуудал хариуцсан
ахлах ажилтан
Б.Цолмон

Хавтасны зургийг:

1. Б.Дорждагва	“Залуу гэр бүлийн хамтын хүч”
2. С.Чинбат	“Худаг дээр”
3. Т.Али	“Малчны хотон дахь жендэрийн тэгш байдал”

АГУУЛГА

Товчилсон үгсийн жагсаалт	4
Хүснэгт, зургийн жагсаалт	5
Хүснэгт.....	5
Зураг.....	6
Матриц.....	7
Удиртгал.....	9
Судалгааны арга зүй, аргачлал	11
Мэдээлэл цуглуулах аргачлал	11
Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт	13
Судалгааны хязгаарлагдмал тал	13
Судалгааны ёс зүй	14
Бүлэг 1. Судалгаанд оролцсон залуу малчдын ерөнхий мэдээлэл	15
Бүлэг 2. Залуу малчдын ажил мэргэжлийн сонголт, цаашдын төлөвлөлт	18
Бүлэг 3. Гэрлэлт, гэр бүлийн байдал	24
Бүлэг 4. Амьжиргаа, орлогын эх үүсвэр	35
Бүлэг 5. Нөөцийн өмчлөл, ашиглалт	52
Бүлэг 6. Өрхийн шийдвэр гаргалт	58
Бүлэг 7. Банкны үйлчилгээ авах байдал, даатгалд хамрагдалт	61
Бүлэг 8. Мал маллагаа, мал аж ахуйн хөдөлмөрийн хуваарилалт	65
8.1 Мал маллагаа	65
8.2 Мал аж ахуйн хөдөлмөрийн хуваарилалт	68
Бүлэг 9. Бэлчээр ашиглалт	74
Бүлэг 10. Малчдын бүлэг, нөхөрлөлийн гишүүнчлэл, нийгэм-хамт олны үйл ажиллагаан дахь оролцоо	82
Бүлэг 11. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамаарах асуудлууд	87
11.1 Эрүүл мэндийн асуудал	87
11.2 Нийгмийн хамгаалал, халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлууд	90
Бүлэг 12. Боловсрол, нийгэм-соёлын үйлчилгээнд хамаарах асуудлууд	94
Бүлэг 13. Залуу малчдыг бэлтгэх асуудалд	104
Дүгнэлт, зөвлөмж	112
Ном зүй	120

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗД	Аймгийн засаг дарга
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БАХ	Бэлчээр ашиглагчдын хэсэг
БЗХӨ	Бэлгийн замаар халдварлах өвчин
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан
ДОХ/ХДХВ	Дархлалын олдмол хомсдол/Хүний дархлал хомсдолын вирус
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖҮХАА	Жендэрийн үндэсний хорооны ажлын алба
ЖСАХ	Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МАА	Мал аж ахуй
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НҮБХАС	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан
НҮБХС	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан
НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
СЗД	Сумын засаг дарга
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТАХ	Төрийн албан хаагч
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
УИХ	Улсын Их Хурал
ХАА	Хөдөө аж ахуй
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ

- Хүснэгт 1.1 Судалгаанд хамрагдсан залуу малчдын мэдээлэл, байршлаар болон хувиар
- Хүснэгт 1.2 Судалгаанд хамрагдсан залуу малчдын нас, хүйс, хувиар
- Хүснэгт 1.3 Судалгаанд хамрагдсан залуу малчдын гэр бүлийн нийгэм хүн ам зүйн мэдээлэл (дундаж үзүүлэлтээр, n=841)
- Хүснэгт 2.1 Судлагдсан орон нутгийн 15-34 насны малчин залуучуудын тоо, хүйсээр болон онуудаар
- Хүснэгт 2.2 Ирээдүйд үр хүүхдээ малчин болгох талаарх залуу малчдын санал бодол, хүйсээр
- Хүснэгт 3.1 Судлагдсан орон нутгийн 15-34 насны малчин залуу гэр бүлийн тоо
- Хүснэгт 3.2 Сургуулийн хүүхдээ дагаж хоёр тусдаа амьдардаг 15-35 насны залуусын тоо, судлагдсан сумдаар
- Хүснэгт 3.3 Гэрлэлтээ бүртгүүлсэн болон цуцалсан 15-34 насны залуусын тоо
- Хүснэгт 3.4 Шилжин явсан 15-34 насны залуусын тоо
- Хүснэгт 3.5 Шилжин ирсэн 15-34 насны залуусын тоо
- Хүснэгт 3.6 18-34 насны гэрлээгүй залуучуудын тоо, хүйсээр
- Хүснэгт 3.7 Хүчирхийллийн дуудлага, зөрчлийн тоо, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тоо
- Хүснэгт 3.8 Мотоциклийн осолд өртсөн залуу малчдын тоо
- Хүснэгт 4.1 Өрхийн орлогын эх үүсвэрүүд, хүйсээр
- Хүснэгт 4.2 Судалгаанд хамрагдсан сумдын малын тоо, ҮСХ, 2020 он
- Хүснэгт 4.3 Мал аж ахуйн бус орлогын хэмжээ
- Хүснэгт 4.4 Залуу малчин өрхийн 1 хүнд ногдох орлогын хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинтэй харьцуулсан байдал, 2020 он, судлаачийн тооцооллоор
- Хүснэгт 5.1 15-34 насны залуу малчдын өвөлжөө, хаваржааны газар авах боломж, байршлаар болон хувиар
- Хүснэгт 6.1 Залуу малчдын өрхийн шийдвэр гаргалт дахь оролцоо, гэрлэлтийн байдлаар, хувиар
- Хүснэгт 7.1 Банк болон банк бус санхүүгийн байгууллагаас зээл авахад гардаг хүндрэл бэрхшээл, хувиар, хүйсээр
- Хүснэгт 8.1 15-34 насны залуу малчдын мал аж ахуй эрхэлж буй арга ажиллагаа, байршлаар болон хувиар
- Хүснэгт 8.2 Мал аж ахуйд ажиллаж буй өрхийн гишүүдийн дундаж тоо, байршлаар
- Хүснэгт 8.3 МАА эрхлэх болон гэрийн өдөр тутмын ажлыг ихэвчлэн хийдэг гэр бүлийн гишүүд, хүйсээр болон хувиар
- Хүснэгт 9.1 Малын тоо, төрлөөр, өсөлт, 1990-2020 онь мян. тол
- Хүснэгт 9.2 Нийт бэлчээр, доройтсон бэлчээр, бэлчээрийн даацын хэтрэлт, судлагдсан аймаг, сумдаар
- Хүснэгт 9.3 Өөр нутагт мал нь өвөлжиж, хаваржиж буй залуу малчдын тоо, хувиар, хүйсээр
- Хүснэгт 9.4 Өвөрхангай аймгийн отроор явж буй малчдын мэдээлэл, 2021 оны байдлаар
- Хүснэгт 9.5 Малчдын оторлож буй нутаг хүртэлх дундаж км-ээр, хүйсээр, аймгаар

Хүснэгт 10.1	Малчдын бүлэг, нөхөрлөл болон хоршоонд гишүүнчлэлтэй гэж хариулсан хувийн жингээр, хүйсээр
Хүснэгт 11.1	Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах байдал, мэдлэг, хариултын хувиар, хүйсээр
Хүснэгт 11.2	Осол гэмтэлд өртсөн, байгалийн гамшигт өртсөн нас баралтын тоо, судлагдсан аймаг, сумдаар, 2020 оны байдлаар
Хүснэгт 12.1	ЕБС-ийн сурагчид хаанаас сургуульдаа явж байна вэ, сумдаар, хувиар
Хүснэгт 12.2	ССургуулийн өмнөх боловсролд хамрагдсан малчдын хүүхдийн тоо, онуудаар
Хүснэгт 12.3	Нийгэм-соёлын үйлчилгээнд хамрагдалт, хувиар, хүйсээр

ЗУРАГ

Зураг 1.1	Судалгаанд хамрагдсан залуу малчдын боловсрол, хүйсээр, хувиар
Зураг 1.2	Судлагдсан залуу малчдын ам бүлийн тоо, хувиар
Зураг 1.3	Залуу малчдын сууцны төрөл, хувиар
Зураг 2.1	Малчин болоход нөлөөлсөн хүчин зүйлс, хүйсээр болон хувиар
Зураг 3.1	Судлагдсан залуу малчдын гэрлэлтийн байдал, хүйсээр
Зураг 3.2	Залуу малчны гэр бүлийн харилцаатай холбоотой асуудлууд, хүйсээр
Зураг 4.1.	МАА эрхлэхээс гадна давхар ажил эрхлэлт
Зураг 4.2	Давхар ажил эрхлэлт, хүйсээр
Зураг 4.3	МАА эрхлэхээс гадна давхар ажил эрхлэлт, байршлаар, хувиар
Зураг 4.4	2020 онд мал аж ахуйн бүтээгдэхүүнээс олсон өрхийн орлогын дундаж хэмжээ, хүйсээр
Зураг 4.5	Залуу малчин өрхийн 2020 онд МАА-н үйлдвэрлэлээс олсон орлого, ам бүлийн тоо, дунджаар, байршлаар
Зураг 4.6	Мал аж ахуйн бүтээгдэхүүнээс олсон орлогын дундаж хэмжээ
Зураг 4.7	МАА-н үйлдвэрлэлийн орлогын бүтэц, МАА-н бүтээгдэхүүнээр
Зураг 4.8	Судалгаанд хамрагдсан сумдын 5 хошуу малын төрөл, хувиар
Зураг 4.9	Судалгаанд хамрагдсан залуу малчдын малын тоо, хувиар
Зураг 4.10	Судалгаанд хамрагдсан сумдын амьжиргааны баталгаажих түвшнээс дээш орлоготой өрх, хувиар
Зураг 4.11	Судалгаанд хамрагдсан сумдын залуу малчдын мөнгөн орлого, төгрөгөөр
Зураг 4.12	Өрхийн орлогыг бүрдүүлэхэд гэр бүлийн гишүүдийн оролцоо, хүйсээр
Зураг 4.13	Сүүлийн 2 жилд МАА-н болон МАА-н бус орлогод гарсан өөрчлөлт, хүйсээр
Зураг 4.14	Айлын мал малладаг эсэх, хүйсээр
Зураг 4.15	Айлын мал малласны хариуд авч буй дэмжлэг, хүйсээр
Зураг 4.16	Сүүлийн 2 жилийн байдлаар хамгийн их өсөж буй зардлууд
Зураг 5.1	15-34 насны залуу малчдын хувьд малын өмчлөгч, хүйсээр болон хувиар (n=816)
Зураг 5.2	15-34 насны залуу малчдын хувьд малын өмчлөлийн байдал аймгуураар болон хувиар (n=816)
Зураг 5.3	15-34 насны малчдын өвөлжөө, хаваржааны газар авах боломж, хүйсээр болон хувиар (n=841)
Зураг 5.4	Өрх дэх эд хөрөнгийн өмчлөл, хувиар
Зураг 5.5	15-34 насны залуу малчдын өрхийн орлогоо хуваарилах, зарцуулах шийдвэр гаргах үйл ажиллагаа, хүйсээр (n=816)

Зураг 6.1	Залуу малчдын өрхийн шийдвэр гаргалт дахь оролцоо, хүйсээр
Зураг 6.2	Өрхийн мал хөрөнгөө хувааж хуваарилахад залуу малчдын оролцоо, насаар, хувиар
Зураг 7.1	Залуу малчдын зээл авсан байдал, хувиар, хүйсээр
Зураг 7.2	Банкинд карт, хадгаламжтай гэж хариулсан залуу малчдын эзлэх хувийн жин, хүйсээр
Зураг 7.3	Даатгалд хамрагдсан байдал, хувиар
Зураг 8.1	15-34 насны залуу малчдын мал аж ахуй эрхэлж буй арга ажиллагаа, хүйсээр болон хувиар
Зураг 8.2	Малчин өрхөд дараах эд зүйлс байдаг гэж хариулсан хувийн жингээр
Зураг 9.1	Бэлчээрийн даац хэтэрсэн эсэх, оролцогчдын хариулт, хүйсээр, аймгаар
Зураг 9.2	Оторлож буй нутаг ба малын тоо
Зураг 9.3	Усны гачаалтай гэж хариулсан оролцогчид, хүйсээр
Зураг 9.4	Худаг, усан сан, уст цэгийн тоо, улсын хэмжээнд, ҮСХ, 2018 он
Зураг 10.1	Малчдын бүлэг, нөхөрлөл, хоршооны үйл ажиллагааны үр өгөөж, гишүүнчлэлтэй малчдын эзлэх хувийн жингээр, хүйсээр
Зураг 10.2	Малчдын ашиг сонирхлын асуудлаар шийдвэр гаргахдаа залуу малчдын оролцоог хангаж буй байдал, хүйсээр болон хувиар
Зураг 11.1	Эмнэлгийн үйлчилгээ авсан байдал, хүйсээр
Зураг 11.2	Шүд цоорох өвчин, улс, бүсээр, 10000 хүнд ногдох, НЭМҮТ, 2019
Зураг 11.3	Шаардлагатай нийгмийн халамжийн үйлчилгээ, дэмжлэгт хамрагдаж буй байдал, хариултын хувиар
Зураг 12.1	Судалгаанд хамрагдсан залуу малчдын боловсрол, хүйсээр (сумдаар, хувиар)
Зураг 12.2	Залуу малчдын эхнэр/нөхрийн боловсролын түвшин, хувиар
Зураг 12.3	Залуу малчдын боловсролын үйлчилгээ авахад тулгардаг бэрхшээл, гэрлэлтээр
Зураг 12.4	Залуу малчдын нийгэм-соёлын үйлчилгээнд хамрагдалт, хувиар
Зураг 12.5	Утас, интернетийн хэрэглээ, хувиар

МАТРИЦ

Матриц 2.1	Гэрлэсэн болон гэрлээгүй эрэгтэй, эмэгтэй малчдын ажил мэргэжлийн талаарх төлөвлөгөө
Матриц 3.1	Залуу малчин гэр бүл хүүхдээ сургуульд сургах шалтгаанаар хоёр тусдаа амьдарснаас бий болж буй үр дагавар
Матриц 3.2	Хөдөөд гэрлэх насны эмэгтэйчүүд багасч байгаагийн шалтгаан
Матриц 10.1	Малчдыг бүлэг, нөхөрлөл, хоршооны үйл ажиллагаа
Матриц 11.1	Эрүүл мэндийн чиглэлийн сургалтад хамрагдсан байдал
Матриц 11.2	Малжуулах хөтөлбөрийн давуу болон сул тал
Матриц 13.1	Малчин болоход нөлөөлж буй хүчин зүйлс, малчдын хариултаар
Матриц 13.2	Мал маллах арга ухаан, малын эрүүл мэндийг хамгаалах, бэлчээр ашиглах, ашиг орлогоо нэмэгдүүлэх мэдлэгт суралцаж буй байдал
Матриц 13.3	Чадавхжуулах арга хэмжээ, хэрэгжүүлдэг эсэх, санал
Матриц 13.4	Залуу малчдад зориулан хэрэгжүүлж буй арга хэмжээ



ӨМНӨХ ҮГ

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011 он)-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрт “Залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн нөхцөл байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийх” талаар тусгагдсан.

Энэ хүрээнд Жендэрийн үндэсний хороо Азийн Хөгжлийн Банктай хамтран “Иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь” техник туслалцааны төслийн хүрээнд “Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ” хийх судалгааны ажлыг 2021 оны 3-7 дугаар сарын хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Дүн шинжилгээ нь бэлчээрийн болон хагас бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг 15-34 насны эрэгтэй, эмэгтэй малчдын хөдөлмөрийн хуваарь, амьжиргаа, хэрэгцээ, мал болон бусад нөөцийн өмчлөл, эзэмшил, ашиглалт дахь жендэрийн ялгааг тодруулах, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээ авахад үүсэж буй хүндрэл бэрхшээл болон цаашид залуу малчдыг бэлтгэх асуудлыг тодорхойлж, гарсан үр дүнг бодлого төлөвлөлтөд тусгуулан хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Судалгаанд Ховд, Увс, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Дорнод зэрэг 6 аймгийн 24 сумын 15-34 насны 841 эмэгтэй, эрэгтэй малчныг асуулга, 30 залуу малчныг гүнзгийрүүлсэн ярилцлагад, орон нутгийн МАА-н 60 мэргэжилтнийг түлхүүр мэдээлэгчдийн ярилцлагад нийт 924 хүн амыг хамруулав.

Энэхүү дүн шинжилгээний ажлыг хийхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан төслийн жендэрийн зөвлөх баг, судалгааг зохион байгуулахад идэвх санаачилга гарган дэмжиж ажилласан Ховд, Увс, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Дорнод аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтсийн жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Бямбасүрэн, Р.Дэлгэрмаа, Г.Ган-эрдэнэ, Р.Наранцэцэг, Ц.Мягмарцэнд, Н.Алтанцэцэг нар болон дээрх 6 аймгийн холбогдох 24 сум, 87 багийн ЗДТГ, холбогдох газар, хэлтсийн албан тушаалтан, мэргэжилтнүүд болон АХБ-ны хамт олонд талархал илэрхийлье.

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖЛЫН АЛБА

УДИРТГАЛ

Үндэслэл. Нүүдлийн мал аж ахуй, малчидгүйгээр Монголын нийгмийг төсөөлөх аргагүй. Монголын мал аж ахуй, малчдын амьдрал ХХ зуунаас өмнөх үед хэдэн мянган жилийн тэртээгээс ирсэн соёл, уламжлалаа хадгалж ирсэн буюу харьцангуй өөрчлөлт багатай, түүхэн урт удаан хугацаанд нэгэн хэвийн байдлаа хадгалж ирсэн онцлогтой. Монгол орны гол онцлог, хүн ардын амьжиргаанд зонхилох байр суурь бүхий нэгэн салбар бол яах аргагүй бэлчээрийн мал аж ахуй мөн. Учир нь, манай улсын нийт хүн амын 19.4 хувь буюу тавны нэг нь малчин өрхөд амьдарч, ажиллах хүчний 26.7 (дөрөвний нэг) хувийг малчид бүрдүүлж, нийт өрхийн 25.8 хувийг малтай өрх, үүний 73.5 хувийг малчин өрх эзэлж байна¹.

Нүүдэлчин малчид маань дөрвөн улирлын туршид хатуу ширүүн уур амьсгал, байгалийн нөхцөл байдалдаа дасан зохицож, бэлчээрийн нөхцөл байдлыг дагалдан нүүдэллэн амьдарсаар ирсэн. Иймээс тэдний ахуй амьдрал амьжиргаанд байгаль, цаг уурын нөхцөл ихээхэн нөлөөтэй. Монгол орны агаарын температурын жилийн дундаж ХХI зууны дунд үе гэхэд дунджаар 2.1-3.0 °С, зууны сүүлээр 3.1-5.0 °С-аар дулаарч ХХ зууны дулааралтын эрчээс ойролцоогоор 2-3 дахин илүү байх, хур тунадас 2030 оноос хойш 6-15 хувь нэмэгдэх, харин өвлийн улиралд 2050 он хүртэл 7-15 хувь, түүнээс хойших хугацаанд ойролцоогоор 50 хувь өсөх урьдчилсан тооцоо гарч байна (УИХ-ын 2011 оны 2 дугаар тогтоолын хавсралт). Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн талхлагдалт, бэлчээрийн хомсдлын нөлөө малчдын ахуй амьдрал, амьжиргаанд олон талт үр дагаврыг бий болгоод байна.

Мөн малчдын дунд бэлчээр ашиглах уламжлалт арга ухааны доголдол бий болж, малын чанар, үр шимийг нэмэгдүүлэх, МАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах малчдын чадамж дутмаг, нэгдсэн зохион байгуулалтад орж, аж ахуйгаа хөгжүүлэх, нэгдмэл ашиг сонирхол бүхий сүлжээнд нэгдэх, түүнийг өргөтгөх мэдлэг, чадвар, хандлагын дутмаг байдал нь үйлдвэрлэлийн үр ашгаа нэмэгдүүлэх боломжийг хязгаарласнаас эдийн засгийн чадавхаа дээшлүүлж чадахгүй байна. Энэ нь залуу малчдын дунд илүүтэй ажиглагдаж байгааг ОУХБ-аас хэрэгжүүлсэн төслийн үр дүнгийн тайланд дурджээ. Тэдний олонх нь хангалттай орлого олоход хүрэлцэхээргүй цөөн малтайн зэрэгцээ цаг уурын хүнд нөхцөл, гэнэтийн эрсдэлийг даван туулах туршлага, малч арга ухаанаар дутагдаж байна². Түүнчлэн, бүхий л аймгуудад малчдын залуу халааг бэлтгэх, мал аж ахуйд залуучуудыг татах асуудлыг дэвшүүлэх боллоо.

Малчдыг хөгжүүлэх, малчин өрхийн ашиг, орлогыг нэмэгдүүлэх, амьдралын түвшинг дээшлүүлэх “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг 2009-2020 онд хэрэгжүүлсэн байна. Энэхүү бодлогын залгамж болгон МУЗГ-аас “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг 2020 онд батлан хэрэгжүүлж эхлээд байна. Тус хөтөлбөрийн зорилго нь малчдыг мэдээллээр хангах, хөгжүүлэх, орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, бүтээмж, орлого, ашгийг нь өсгөх, тэдгээрийг чадавхжуулахад чиглэгдсэн. Тус хөтөлбөрт “малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх, малчдын

1 МУЗГ. 2020. Монгол малчин үндэсний хөтөлбөр. Улаанбаатар

2 ОУХБ. 2016. Баянхонгор, Өвөрхангай аймгийн залуучуудын орлогын баталгааг сайжруулах туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан. Улаанбаатар

залуу халааг бэлтгэх” зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д “нийгмийн хөгжил, дэвшилд жендэрийн тэгш оролцоог хангах замаар нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчныг бүрдүүлэх” зорилт нь “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн хүрээнд жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг үндэсний, салбарын, орон нутгийн, байгууллагын түвшинд хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүй, бодлогын орчин үндэсний уламжлалт өв соёл, байгаль орчин ба нийгэм эдийн засгийн шинэ нөхцөл байдалд зохицон, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаар тасралтгүй хөгжиж байгаагийн илрэл нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг дэмжин, бодлого, үйл ажиллагаандаа нэвтрүүлж буй явдал юм.

ХХААХҮ-ийн салбарын тогтвортой хөгжлийг жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаагаар дэмжих зорилго бүхий ХХААХҮ-ийн жендэрийн бодлогыг 2018 онд баталж хэрэгжүүлж эхэлсэн. Тус бодлогын баримт бичигт “малчдын хүйсийн харьцаа алдагдан, залуу малчдын эзлэх хувийн жин буурч байгаа”-г онцолжээ. Хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮ-ийн салбарын бодлого төлөвлөлтөд жендэрийн дүн шинжилгээ, үнэлгээ, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх, салбарын хүний нөөцийг бэлтгэх бодлогын тогтолцоог жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, малчин гэр бүлийн хөгжил, залгамж халааг бэлтгэх, нийгэм, соёл, эдийн засгийн цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, ХАА-н зохистой дадлыг малчин, тариаланч эмэгтэй, эрэгтэйчүүдийн жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн эзэмшүүлж, нийгмийн хариуцлагыг нь нэмэгдүүлэх, хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах, залуу малчдын манлайлах чадавхыг дээшлүүлэх зэрэг эрэгтэй, эмэгтэй, залуу малчдад хамаарах зорилт, арга хэмжээг 2025 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр тусгажээ. Энэ хүрээнд “Малчин залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн нөхцөл байдалд жендэрийн шинжилгээ хийж, үр дүнг үндэсний хэмжээнд хэлэлцүүлэх” ажлыг 2018-2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын дунд, тэр дундаа охид бүсгүйчүүдийн хувийн жин буурч байгаа нь хөдөөгийн нийгэм, соёл, эдийн засгийн орчин нөхцөл, мал аж ахуйн салбарын хөдөлмөрийн нөхцөл байдал шалтгаалж байна. Иймээс залуу малчдын жендэрийн бодит дүр төрх, жендэрийн ялгаатай хэрэгцээг тодруулж, тулгарч буй бэрхшээлийг илрүүлж, гарц шийдлийг ХХААХҮ-ийн салбарын бодлогод тусгуулан хэрэгжилтийг дэмжих шаардлагатай байна.

Жендэрийн дүн шинжилгээний зорилго, зорилтууд

Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын ахуй, амьдрал үйл ажиллагаан дахь жендэрийн дүн шинжилгээ нь өрхийн хөдөлмөрийн хуваарь, мал болон бусад нөөцийн эзэмшил, өмчлөл, ашиглалт дахь жендэрийн ялгааг тодруулах, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёл, банк санхүүгийн болон бусад төрлийн үйлчилгээ авахад үүсэж буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийг дэмжихэд чиглэсэн санал зөвлөмжийг боловсруулах зорилготой.

Энэ хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Өрхийн хөдөлмөрийн хуваарь, мал болон бусад нөөцийн эзэмшил, өмчлөл, ашиглалт дахь жендэрийн ялгааг тодруулах;

2. Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёл, банк санхүүгийн үйлчилгээ болон бусад төрлийн үйлчилгээ авахад үүсэж буй хүндрэл бэрхшээл, учир шалтгааныг тодорхойлох;
3. Салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийг дэмжихэд чиглэсэн санал зөвлөмжийг боловсруулж, холбогдох талуудад танилцуулж, хэлэлцүүлэх.

Судалгааны арга зүй, аргачлал

Жендэрийн дүн шинжилгээгээр бэлчээрийн болон хагас бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг 15-34 насны малчдын мэргэжил сонголт, эдийн засаг, амьжиргаа, мал маллагаа, өрхийн хөдөлмөрийн хуваарь, эдийн засгийн эрх мэдэл дэх жендэрийн ялгааг тодруулж, нийгмийн үйлчилгээ авах болон залуу малчдыг бэлтгэх хүрээнд дэвшигдэж буй асуудлыг тодорхойлохдоо нийгмийн судалгааны тоон болон чанарын судалгааны арга зүйг хослуулан хэрэглэсэн болно.

Жендэрийн дүн шинжилгээний Харвард, Мозер, Жендэрийн дүн шинжилгээний матриц зэрэг загваруудад жендэрийн харилцааны бодит нөхцөл байдлыг тодорхойлохдоо 1) хөдөлмөрийн хуваарь 2) шийдвэр гаргах, хянах эрх мэдэл 3) нөөцийн өмчлөл, эзэмшил, ашиглалт дахь жендэрийн ялгааг юуны түрүүнд тодруулдаг. Энэхүү аргачлалын дагуу залуу малчдын жендэрийн харилцааны өнөөгийн төлөв байдлыг тодруулж, нийгмийн үйлчилгээнд хамрагдах байдал, оролцоог хангах, малчдыг бэлтгэх чадавхжуулах хүрээнд гарч буй хүндрэл бэрхшээлийг хүйсээр задлан шинжилсний зэрэгцээ нас, байршил, эдийн засаг, гэрлэлтийн байдал зэрэг нийгэм эдийн засгийн статусаар салбар дундын (cross-sectional) шинжилгээ хийн, нарийвчлан тодорхойлов.

Өмнө хийгдсэн холбогдох бүтээлийн судалгааны үр дүнд тулгуурлан малчдын амьдрал ахуйн хэв маягийг уламжлалт нүүдэлчин, хагас суурьшмал малчид гэсэн хоёр хэв маягт хуваан, Ховд, Увс, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Дорнод аймгуудыг тал хээр, говь хээр, хангай, өндөр уулын гэсэн экосистем болон баруун, төв, зүүн бүсийн газар зүйн байршлыг харгалзан судалгаанд хамруулсан болно.

Мэдээлэл цуглуулах аргачлал

Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьжиргааны жендэрийн дүн шинжилгээнд мэдээлэл цуглуулах дараах аргыг хэрэглэв. Үүнд:

А. Статистикийн мэдээллийн холбогдох бүтээлийн судалгаа. Статистик мэдээллийн шинжилгээгээр аймгийн болон сумдын мэдээлэлд тулгуурлан судалсан. Судалгаанд хамруулахаар сонгон авсан аймгийн жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Статистикийн хэлтэс, Хүнс хөдөө аж ахуйн газар, сумдын төрийн сангийн төлөөлөгч (статистик хариуцсан), МАА-н мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар 15-34 насны залуу эрэгтэй, эмэгтэй малчдын нийгэм хүн ам зүй, эрүүл мэнд, оролцооны болон малын тоо, хур тунадасны хэмжээ, бэлчээрийн даацад хамаарах статистикийн мэдээлэл, өгөгдлүүдийг цуглуулан, асуудлыг тодорхойлох, нотолгоог баталгаажуулах, харьцуулах хүрээнд ашиглалаа.

- 15-34 насны залуу малчдын нийгэм хүн ам зүйн үзүүлэлтүүд, гэрлэлт, цуцлалт, шилжих хөдөлгөөн болон гэр бүлийн хүчирхийлэл, төрөлт, нас баралт, осол гэмтэл,

байгалийн гамшигт өртсөн байдлын динамик мэдээлэл

- Малчдын бүлэг, хоршооны тоо, малчдын гишүүнчлэл болон 15-34 насны залуучуудын улс төрийн оролцооны динамик мэдээлэл
- Аймаг болон сумдын малын тоо болон бэлчээрийн талбай, бэлчээрийн даац, худаг ус, хур тунадасны хэмжээний динамик мэдээлэл

Б. Стандартчилагдсан ярилцлага (асуулга). Бэлчээрийн болон хагас суурин мал аж ахуй эрхэлдэг 15-34 насны малчин эрэгтэй, эмэгтэйчүүдийг хамруулан эрэгтэй, эмэгтэй малчдын амьжиргаанд жендэрийн дүн шинжилгээ хийхэд шаардлагатай тоон болон чанарлаг мэдээллийг утсаар цуглуулсан болно.

- 15-34 насны залуу малчдын нийгэм хүн ам зүйн үзүүлэлтүүд
- Мэргэжил сонголт, цаашдын хандлага
- Гэрлэлт, гэр бүлийн харилцаа
- Эдийн засаг, амьжиргаа
- Өмчлөл, нөөцийн ашиглалт болон шийдвэр гаргалт
- Мал маллагаа, мал аж ахуйн хөдөлмөр хуваарилалт
- Бэлчээр ашиглалт
- Малчдын бүлэг, нөхөрлөл дэх гишүүнчлэл, нийгэм-хамт олны үйл ажиллагаан дахь оролцоо
- Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ
- Боловсрол, нийгэм-соёлын үйлчилгээ
- Залуу малчныг бэлтгэх асуудал

В. Гүнзгийрүүлсэн ярилцлага. Залуу малчдад тулгамдаж буй асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэвэл зохих талаар санал зөвлөмж, санаа бодлыг тодруулах зорилгоор 15-34 насны гэрлэсэн болон гэрлээгүй эрэгтэй, эмэгтэй малчин гэсэн категориор ялган зохион байгууллаа. Гүнзгийрүүлсэн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулахдаа гар утас ашиглалаа.

- Нийгэм хүн ам зүйн мэдээлэл
- Залуу малчдын хүсэл мөрөөдөл, чөлөөт цаг
- Залуу малчдын гэрлэлттэй холбоотой асуудал
- Залуу малчин эрэгтэй, эмэгтэйчүүдэд тулгамддаг асуудал
- Орон нутагт залуу малчныг дэмжсэн хөтөлбөр, арга хэмжээ болон хэрэгцээ шаардлага
- Шийдвэр гаргалтад залуучуудын оролцооны байдал
- Мал маллах арга ухаан, бэлчээр, байгаль хамгаалахад үлгэр дуурайлал
- Мэдээллийн суваг, эх сурвалж
- Залуу малчныг бэлтгэх асуудал

Г. Түлхүүр мэдээлэгчдийн ярилцлага. Аймаг, сумдын мал аж ахуйн асуудал хариуцсан удирдах албан тушаалтан болон холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан орон нутаг дахь МАА-н үйлдвэрлэл, бэлчээрийн төлөв байдал, орон нутгийн залуу малчдад тулгамдаж буй асуудал, залуу малчдад хамаарах жендэрийн асуудал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, шийдвэрлэвэл зохих асуудлын талаар санал зөвлөмж, санаа бодлыг тодруулах хүрээнд ярилцав.

Цар тахлын хөл хорионы нөхцөл байдлын улмаас мэдээлэл цуглуулах арга техникийг өөрчилж, орон нутгийн холбогдох албан тушаалтан, судалгаанд оролцогчдоос утсаар мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгууллаа.

Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт

Түүврийн төлөвлөлтийг экосистем, нүүдлийн болон хагас нүүдлийн бэлчээрийн МАА-н эрхлэх хэлбэр, амьдралын хэв маяг, зэрэг түүврийн параметрийг харгалзан түүврийн хүрээг тогтоов. Увс, Ховд, Өвөрхангай аймгийг тал хээр, өндөр уул, ойт хээрийн хангайн экосистемд хамаарах уламжлалт нүүдэлчин, Сэлэнгэ аймгийг хангайн экосистемд хамаарах хагас суурьшмал, Дорнод аймгийг тал хээрийн экосистемд хамаарах холимог, Өмнөговь аймгийг говийн экосистемд хамаарах нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг хэв шинжээр судалгаанд хамрууллаа.

Дүн шинжилгээний нэгж бол хувь хүн. Дараах шалгуурыг харгалзан судалгааны нэгжийг сонгов.

- 15-34 насны эрэгтэй, эмэгтэй малчин
- Сонгогдсон орон нутагт оршин суудаг
- Судалгаанд оролцохоор зөвшөөрсөн.

Түүврийн үндсэн нэгж нь 15-34 насны малчин эрэгтэй, эмэгтэйчүүд тул зорилтот түүврийн аргыг хэрэглэсэн бөгөөд энгийн санамсаргүй түүврийн арга болон квотын аргыг хослуулан дараах алхамтайгаар нэгжийг сонгосон.

1. Сонгогдсон аймгийн сумдыг холын болон ойрын, экосистем гэсэн хоёр бүлэгт хуваан, тэднээс санамсаргүйгээр тус бүр хоёр сумыг сонгов.
2. Сонгогдсон сумдын малчдын талаарх жендэр, насны бүлгээр ангилсан статистик мэдээллийн жагсаалтад үндэслэн судлагдах эрэгтэй, эмэгтэй малчдын хүйсийн харьцааг тогтоосон.
3. Тус харьцаанд үндэслэн судалгааны түүвэр дэх квотыг тогтоов.
4. Стандартчилагдсан ярилцлага (асуулга) оролцох 15-34 насны малчин эрэгтэй, эмэгтэйчүүдийг санамсаргүйгээр сонголоо.
6. Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцох 15-34 насны малчдыг гэрлэсэн болон гэрлээгүй гэсэн категорид хувааж, сөөлжих арга техникийн дагуу судалгаанд хамруулав.
7. Түлхүүр мэдээлэгчдийн ярилцлагад оролцох мэргэжилтнүүдийг судалгаанд шаардлагатай мэдээлэл өгөх боломжийг нь харгалзан зорилттойгоор сонгосон болно.

Судалгаанд 6 аймгийн 24 сумыг хамруулсан ба асуулгад 15-34 насны эмэгтэй, эрэгтэй малчин-841, гүнзгийрүүлсэн ярилцлагад-30, түлхүүр мэдээлэгчдийн ярилцлагад орон нутгийн холбогдох мэргэжилтний төлөөлөл 60 хүн хамрагдсан бөгөөд нийт 924 хүн амыг судалгаанд хамруулав.

Судалгааны хязгаарлагдмал тал

Мэдээлэл цуглуулалтын шатанд орон нутгаас холбогдох статистик мэдээлэл авах болон 15-34 насны залуу малчдаас утсаар мэдээлэл цуглуулахтай холбоотой бэрхшээл гарсныг тэмдэглэж байна. Тухайлбал түүврийн жагсаалт дахь малчдын гар утас холбогдох

боломжгүй, утасны дугаараа шилжүүлсэн, шилжсэн зэрэг тохиолдол цөөн бус тохиолдож байлаа. Үүнд:

1. 15-34 насны эрэгтэй, эмэгтэй малчны түүврийн жагсаалтаас энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгогдсон малчны утас холбогдох боломжгүй эсвэл явц дунд орхих зэрэг тохиолдолд өөр малчныг дахин сонгож хамруулах;
2. Аймаг, орон нутгийн статистик мэдээллийн тогтолцоонд МАА-н салбарын нэгдсэн мэдээллийн системийн бүрдүүлэлтийн өнөөгийн байдал болон асуудал хариуцсан мэргэжилтний хариуцлагаас хамаарч бүрэн бус мэдээлэл цуглуулах;
3. Аймаг, орон нутгийн зарим статистик мэдээлэл хариуцдаг байгууллагын зүгээс МАА-н салбарын статистик мэдээллээр хангах, ялангуяа судлагдаж буй 15-34 насны малчин эрэгтэй, эмэгтэйчүүдийн нийгэм, хүн ам зүй, шилжих хөдөлгөөн, гэрлэлт, гэр бүлийн хүчирхийлэл, төрөлт нас баралт, осол гэмтэл, байгалийн гамшигт өртсөн байдал, малчдын бүлэг хоршооны гишүүнчлэл, улс төрийн оролцооны насны бүлэг, хүйсээр ангилсан мэдээлэл болон бэлчээрийн талбай, бэлчээрийн даац, худаг ус, жилийн хур тунадасны хэмжээний динамик мэдээллийн ангийн бүрдэлт тааруу байсны улмаас зорьсон хэмжээнд шаардлагатай мэдээллийг цуглуулж чадаагүй. Мөн баг, сумын Засаг дарга тэтгэвэрт гарсан, ажлаа өөрчилсөн шалтгаанаар статистик мэдээллийн бүрдэлт тогтолцооны хувьд сул хөгжсөн байгаа тул цуглуулахад хүндрэлтэй байв.

Судалгааны ёс зүй

Дэлхийн социологичдын холбооноос баталсан Нийгэм судлаачдын ёс зүйн хэм хэмжээ, Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн байгууллагаас баталсан Монгол Улсын стандарт MNS ISO 20252: 2019-ийг баримтлан ажиллав. Судалгаанд оролцсон эрэгтэй, эмэгтэй залуу малчид болон аймаг, сум, багийн холбогдох удирдах ажилтан, мэргэжилтнүүдийн өгсөн мэдээллийг Хувь хүний нууцлалыг хангах тухай Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хадгалж, зөвхөн судалгааны зориулалтаар ашиглахыг урьдчилан танилцуулж, судалгаанд оролцох зөвшөөрлийг авч ажиллалаа. Тодруулбал:

- Хувь хүний нууцлалыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хадгалах, хамгаалах үүргийг хүлээх,
- Малчин өөрөө зөвшөөрсөн тохиолдолд судалгаанд хамруулах,
- Оролцогчийн нэр хүнд, эрхийг хамгаалах, ажил, амьдралын аюулгүй байдлыг хангах
- Нотолгоог үнэн зөвөөр бүрдүүлэх, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхэд чанарыг эрхэмлэх,
- Судалгаагаар илэрсэн баримтыг гуйвуулахгүйгээр бодит байдлыг тайлбарлахад ашиглах зэрэг болно.

Бүлэг 1.

СУДАЛГААНД ОРОЛЦСОН ЗАЛУУ МАЛЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Ховд, Увс зэрэг 6 аймгийн 24 сумын 87 багийн нийт 841 залуу малчид хамрагдсан байна.

Хүснэгт 1.1 Судалгаанд хамрагдсан залуу малчдын мэдээлэл,
байршлаар болон хувиар

Аймаг	Судалгаанд оролцогчдын тоо	Хувь	Сум	Тоо	Хувь
Дорнод	137	16.3	Баяндун	35	4.2
			Булган	34	4
			Матад	34	4
			Цагаан-Овоо	35	4.2
Өвөрхангай	140	16.6	Бат-Өлзий	35	4.2
			Богд	35	4.2
			Сант	35	4.2
			Уянга	35	4.2
Өмнөговь	140	16.6	Гурвантэс	35	4.2
			Мандал-Овоо	35	4.2
			Номгон	35	4.2
			Хүрмэн	35	4.2
Сэлэнгэ	139	16.5	Зүүнбүрэн	35	4.2
			Мандал	35	4.2
			Орхонтуул	35	4.2
			Цагааннуур	31	4
Ховд	143	17.0	Булган	36	4.3
			Дэргөн	35	4.2
			Мөнххайрхан	35	4.2
			Мянгад	36	4.3
Увс	142	16.9	Зүүнхангай	36	4.3
			Наранбулаг	36	4.3
			Тариалан	35	4.2
			Тэс	35	4.2
Нийт	841	100.0		841	100


Судлагдсан залуу малчдын 60 хувь нь эрэгтэй, 40 хувь нь эмэгтэй, насны бүлгээр харвал 3.7 хувь 15-19, 15 хувь 20-24, 31.2 хувь 25-29, 50.1 хувь 30-34 насны малчид хамрагдсан байна. Залуу малчдын дундаж нас 28.7 байна.

Хүснэгт 1.2 Судалгаанд хамрагдсан залуу малчдын нас, хүйс, хувиар.

Нас	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
15-19	83.9	16.1	100
20-24	62.7	37.3	100
25-29	58.4	41.6	100
30-34	58.4	41.6	100

Судалгаанд 1.8 хувь нь боловсролгүй, 8.8 хувь нь бага, 16 хувь нь бүрэн бус дунд, 58.9 хувь нь бүрэн дунд, 2.7 хувь нь тусгай дунд, 11.8 хувь нь дээд боловсролтой залуу малчид оролцсон байна. Судлагдсан залуу малчдын боловсролыг дундаж үзүүлэлтээр аваад үзвэл бүрэн дунд боловсролтой байна.


Зураг 1.1 Судалгаанд хамрагдсан залуу малчдын боловсрол, хүйсээр, хувиар.



Залуу малчдын 79.7 хувь (n=670) малчин мэргэжилтэй бол 20.3 хувь (n=171) нь ямар нэгэн төрлийн (66 төрлийн) мэргэжил эзэмшсэн боловч үндсэн ажлаа мал маллах гэж үзжээ.

Судалгаанд хамрагдсан залуу малчдын 56 хувь нь 4-5 ам бүлтэй гэж хариулсан ба ам бүлийн дундаж үзүүлэлт 4.38 байна.

Зураг 1.2 Судлагдсан залуу малчдын ам бүлийн тоо, хувиар.




Судалгаанд хамрагдсан залуу малчдын ам бүлийн 5 хувьд тэтгэвэрт гарсан аав, 7.7 хувьд тэтгэвэрт гарсан ээж, 0.9 хувьд хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй, 0.5 хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй гишүүнтэй амьдарч байна. Мөн залуу малчдын 75 хувь нь 0-5 насны, 54.2 хувь нь сургуулийн насны хүүхэдтэйгээ амьдарч байна.

Хүснэгт 1.2 Судалгаанд хамрагдсан залуу малчдын гэр бүлийн нийгэм хүн ам зүйн мэдээлэл (дундаж үзүүлэлтээр, n=841).

Үзүүлэлт	Дундаж	Хамгийн цөөн	Хамгийн олон
Ам бүлийн тоо	4.38	1	9
Өндөр насны тэтгэвэрт гарсан эрэгтэй	1	1	1
Өндөр насны тэтгэвэрт гарсан эмэгтэй	1.02	1	2
Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй	1	1	1
Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй	1	1	1
0-5 насны хүүхэд	1.53	0	5
Сургуулийн насны хүүхэд	1.68	0	5
Насанд хүрсэн эрэгтэй	1.19	0	4
Насанд хүрсэн эмэгтэй	1.1	0	3

Судлагдсан нийт залуу малчдын 91.1 хувь нь монгол гэрт, 5.7 хувь нь өвлийн байшинд, 2.6 хувь нь отрын гэр, вагончикт амьдарч байна. Ховд аймгийн залуу малчдын 11.6 хувь, Сэлэнгэ аймгийн залуу малчдын 16.5 хувь нь өвлийн байшинд, харин Өмнөговь аймгийн залуу малчдын 10 хувь нь отрын гэр, вагончикт амьдарч байна.

Зураг 1.3 Залуу малчдын сууцны төрөл, хувиар.



Судалгаанд хамрагдагсдын 87.6 хувь нь нутгийн уугуул иргэд бол 12.4 хувь нь шилжин ирж суурьшсан малчид байна. Шилжин ирж суурьшсан залуу малчид 1993-2020 онуудад шилжилт хөдөлгөөн хийсэн бөгөөд эцэг эхтэйгээ хамт амьдарч байхдаа шилжилт хөдөлгөөнд орсныг хамруулан авч үзсэнийг тэмдэглэх нь зүйтэй. 2010 он нь залуу малчдын шилжих хөдөлгөөнд оролцсон дундаж үзүүлэлт болж байна.

Бүлэг 2.

ЗАЛУУ МАЛЧДЫН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СОНГОЛТ, ЦААШДЫН ТӨЛӨВЛӨЛТ

ХХААХҮ-ийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2018-2025)-д малчдын хүйсийн харьцаа алдагдан залуу малчдын эзлэх хувийн жин буурсан, салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд малчин гэр бүлийн хөгжлийг дэмжих, залгамж халааг бэлтгэх нийгэм соёл, эдийн засгийн цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхээр тусгажээ.

2019 онд Хүний эрхийн Үндэсний Комиссын “Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн хэрэгжилт”-ийн судалгааны тайланд 2019 оны байдлаар 285,482 малчин бүртгэгдсэний 58.3 хувь эрэгтэй, 41.7 хувь эмэгтэйчүүд эзэлж, хүйсийн хувьд эрэгтэйчүүд давамгайлж байна гэж дүгнэжээ³. Уг судалгаагаар залуу, дунд үеийн малчдын тоо буурч, хүйсийн харьцааны зөрүү нэмэгдэж, малчдын залгамж халаа дутагдалтай байгааг тэмдэглэсэн. ҮСХ-ны мал тооллогын 2020 оны дүнгээр 15-34 насны малчид 30 хувийг эзэлж байна⁴. ХЭҮК-ын хийсэн дээрх судалгааны тайланд дурдсанаар, нийт малчдын 33.3 хувийг эрэгтэй, 27.8 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. ҮСХ-ны 2000-2019 онуудын статистик мэдээллээр, нийт малчдад 15-34 насны малчдын эзлэх хувийн жин тасралтгүй буурч ирсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал ҮСХ-ноос гаргадаг “Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2019”-д сүүлийн жилүүдэд 15-34 насны залуу малчдын эзлэх хувийн жин буурч байгааг тэмдэглээд 1995 онд нийт 390.5 мянган малчдын дотор 15-34 насны малчид 225.2 мянга буюу 57.7 хувь, 2018 онд нийт 288.7 мянган малчдын дотор 96.0 мянга буюу 33.3 хувийг эзэлж байсан бол 2019 онд нийт 285.5 мянган малчдын 88.5 мянга буюу 31.0 хувь болж, 1995 оныхоос 26.7 пунктээр, 2018 оныхоос 2.3 пунктээр буурсан байна гэжээ⁵.

Судлагдсан 24 сумын статистик хариуцсан мэргэжилтнүүдийн өгсөн статистикийн гурван оноор харуулсан мэдээллээр, Увс, Сэлэнгэ, Дорнод аймгийн түвшинд 15-34 насны залуу малчдын тоо буурах хандлага ажиглагдаж байна. Эндээс харахад ҮСХ, ХЭҮК-ын судалгааны үр дүнг давхар баталгаажуулах төлөвтэй үр дүн үзүүлж байна (Хүснэгт 2.1).

Хүснэгт 2.1 Судлагдсан орон нутгийн 15-34 насны малчин залуучуудын тоо, хүйсээр болон онуудаар.

Байршил	Эмэгтэй			Эрэгтэй			Нийт		
	2010	2015	2020	2010	2015	2020	2010	2015	2020
Аймаг									
Дорнод		1348	1295		1348	1295		2696	2590
Өвөрхангай	1278	1132	1441	1637	1662	1471	2915	2794	2912
Өмнөговь									

3 Хүний эрхийн Үндэсний Комисс. 2019. Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн хэрэгжилт. Улаанбаатар

4 ҮСХ. 2020. Мал тооллогын дүн. Улаанбаатар

5 ҮСХ. 2020 Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга. Улаанбаатар


Сэлэнгэ	1311	1341	979	1227	1222	1243	2538	2563	2222
Ховд									
Увс	3400	2600	2300	4900	3400	3100	8300	6000	5400
Сум									
Баяндун		102	119		101	120		203	239
Булган (Дорнод)		98	111		98	110		196	221
Матад		96	94		95	94		191	188
Цагаан-Овоо		100	110		100	111		200	221
Зүүнбүрэн	123	101	97	75	76	56	198	177	153
Мандал	312	356	349	323	408	384	635	408	733
Орхонтуул	74	85	108	124	101	98	198	186	206
Цагааннуур	121	108	110	180	177	160	301	285	270
Булган (Ховд)	153	326	100	203	471	139	356	797	239
Дөргөн	202	186	190	193	145	164	395	331	354
Мөнххайрхан	102	36	29	154	47	46	256	83	75
Зүүнхангай	74	70	65	111	110	107	185	180	172
Наранбулаг	185	220	260	275	280	278	460	500	538
Тариалан	211	225	224	248	245	277	459	470	501
Тэс	241	218	182	361	367	329	602	585	511
Бат-Өлзий	370	233	358	453	545	411	823	778	769
Богд	460	529	459	435	434	388	895	963	847
Сант	211	176	128	274	264	188	485	440	316
Уянга	237	194	496	475	419	484	712	613	980
Гурван тэс	98	131	150	145	167	211	243	298	361
Мандал-Овоо	83	61	32	107	104	132	190	165	164
Номгон	141	125	79	140	165	214	281	290	293
Хүрмэн	72	67	75	130	130	126	202	197	201

Эх сурвалж: Сумын статистикийн мэдээлэл

Аймаг, сумдын ХХААГ-ын удирдах ажилтан болон мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн өгсөн ярилцлагаар, жилээс жилд залуу малчдын тоо цөөрч байгааг тэмдэглэсэн. Цөөн тохиолдолд буюу зарим нэг сумын мэргэжилтнүүд залуу малчид нэмэгдэх хандлагатай ч удам дагаж бага наснаасаа мал маллаж ирсэн эсвэл эцэг эх нь өндөр настай болсноор мал маллахаар малчин болдог гэж тайлбарлалаа. Асуулгын дүнгээр, 15-34 насны малчин залуучуудын 91.6 хувь үүнээс эмэгтэйчүүдийн 89.6, эрэгтэйчүүдийн 92.9 хувь аав ээж малчин гэсэн хариултыг өгчээ. Судлагдсан залуу эрэгтэй, эмэгтэй малчдаас яагаад малчин болсныг асуухад 61 хувь аав ээж малчин хүмүүс, удам дагасан малчин гэж хариулсан нь тэргүүлэх эрэмбийн хариулт болсноос үзвэл малчин болоход эцэг эхийн малч удам нөлөөтэй хүчин зүйл байгааг харж болно. Яагаад мал маллах болсныг тодруулахад олдсон ажил гэж хариулагчдын хувьд хүйсийн ялгаа илрээгүй ч боловсролын түвшин тодорхой хэмжээгээр нөлөөлөх хандлага ажиглагдсан. Тухайлбал нийт малчдын 4.8 хувь (n=39) олдсон ажил гэж хариулснаас

дээд боловсролтой малчид 44.7 хувь (n=99) эзэлсэн нь бусад боловсролын түвшинтэй малчидтай харьцуулахад хамгийн өндөр хувьтай үзүүлэлт болж байна. Эмэгтэй малчдын хувьд гэрлэсний дараа эсвэл нөхрөө дагаж малчин болсон нь 4.3 хувийг (n=23) эзэлж байна. Гэрлэсэн эмэгтэй малчдын өгсөн ярилцлагын дүн энэхүү үр дүнг давхар баталгаажуулах юм.

Зураг 2.1 Залуу малчдын малчин болоход нөлөөлсөн хүчин зүйлс, хүйсээр болон хувиар.



Нийт дүнд бага хувийг эзэлж байгаа ч цэцэрлэг сургуулийн насны хүүхдээ дагаад төв суурин газар нүүн, цаашид тогтмол цалин хөлстэй ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй залуу эрэгтэй, эмэгтэй малчид (n=13 эмэгтэй, n=3 эрэгтэй) байгааг асуулгын үр дүн харуулж байна. Ганцаарчилсан ярилцлагын мэдээлэл асуулгын судалгааны дүнг давхар баталж байна.

ШИГТГЭЭ 2.1 Малчин болоход нөлөөлсөн хүчин зүйлс

Тавдугаар ангиа төгсөөд шууд мал маллаж эхэлсэн. Нэг их сурах хүсэлгүй байсан учраас аав ээжийгээ дагаад бас сонирхлоороо малчин болсон.

Ховд аймаг, гэрлээгүй, 24 настай эрэгтэй.

Аав ээж малаа маллахад хүн хүч дутаад би сургуулиа орхиод гэртээ ирсэн. Жил гаран мал маллаж байна. Улаанбаатар хотод Сувилагчийн сургуульд сурч байсан.

Увс аймаг, гэрлээгүй, 22 настай эмэгтэй.

Гуравдугаар ангид байхад аав өөд болсон, гэрийн аж ахуй тэр тусмаа мал аж ахуйд туслах хүнгүйгээс сургуулиа орхиж мал маллаж эхэлсэн.

Дорнод аймаг, гэрлэсэн, 25 настай эрэгтэй.

2009 онд гэрлээд л мал малласан. Нөхөр бид хоёр хоёулаа малчин айлын хүүхдүүд.

Өвөрхангай аймаг, гэрлэсэн, 31 настай эмэгтэй.

Арван жилээ төгсөөд үргэлжлүүлээд сурах сонирхолтой байсан ч мал дээр гарсан. Би айлын том хүүхэд. Аав ээж хоёр мал малладаг. Сургуульд сурах санхүү эдийн засгийн хувьд боломжгүй байсан. Хоёр дүү маань сургуульд сурах тул би зэрэг оюутан болбол сургалтын төлбөр төлөхөд хүндрэлтэй.

Сэлэнгэ аймаг, гэрлэсэн, 34 настай эрэгтэй.

Түүнчлэн байгаль цаг уурын эрс тэс нөхцөлд мал маллахаас бэрхшээдэг, хот суурин газарт сурч, ажиллаж амьдрахыг илүүд үздэг явдал залуу малчдын тоо буурахад нөлөөлж байна хэмээн төрийн албан хаагчид дүгнэж байна. Увс, Сэлэнгэ, Өмнөговь, Өвөрхангай аймгийн ХХААГ-ын мэргэжилтнүүд залуу малчин цөөрсөн, харин Дорнод аймгийн хувьд сүүлийн жилүүдэд мал маллах сонирхолтой залуусын тоо нэмэгдэж байгааг дурдсан билээ. МАА-н мэргэжилтнүүдийн ярилцлагаар, эцэг эхчүүдийн зүгээс хүүгээ удам залган мал маллаж, эцэг эхдээ тус дэм болохыг, эмэгтэй хүүхэд боловсрол эзэмших ёстой гэх жендэрийн хэвшмэл үзлийн улмаас залуу малчдын хүйсийн тэнцвэр алдагдаж, цаашлаад гэрлээгүй, ганц бие эрэгтэй малчин залуус олшроход хүргэж байна гэжээ.

Эмэгтэй, эрэгтэй залуу малчдын 81.4 хувь нь (эрэгтэй 82.5 хувь, эмэгтэй 80.4 хувь) малаа маллана гэсэн хариултыг өгсөн ба хүйсийн хувьд онцгойлох ялгаа ажиглагдсангүй. Харин 5.6 хувь нь хүүхэд цэцэрлэг, сургуулийн насанд хүрэхээр төв суурин газар нүүхээр төлөвлөж байна. Өмнөговь аймгийн залуу малчдын хувьд малаа маллана гэсэн хариултын эзлэх хувь бусад аймгуудтай харьцуулахад хамгийн бага, Дорнод аймагт өөр мэргэжилтэй болно, тогтмол, ахиу хөлстэй ажил хийнэ гэж хариулсан малчдын эзлэх хувь хамгийн өндөр байна.

Залуу малчидтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын дүнгээр, гэрлэсэн эрэгтэй болон эмэгтэй малчид малаа өсгөж үр хүүхдээ боловсролтой болгох, хүүхдийн сургалтын төлбөрийг хуримтлуулахын тулд малаа сайн маллана гэжээ. Гэрлэсэн болон гэрлээгүй эрэгтэй малчдын хувьд улсын сайн малчин, аймгийн аварга малчин, мянгат малчин болох, малын тоог өсгөх, эмэгтэй малчдын хувьд эрүүл байх, малаа сайн маллах, мал маллангаа давхар ажил (оёдол, эсгүүр) хийх, чанартай цөөн мал өсгөх зэрэг хүсэл мөрөөдлөө илэрхийлжээ. Чанарын судалгааны үр дүнд тулгуурлан дүгнэхэд, залуу эмэгтэй малчдын хувьд малаа чанаржуулах, залуу эрэгтэй малчдын хувьд малын тоог өсгөх, нэр төртэй сайн малчин болох хүсэл эрмэлзэл давуутай илэрч байгаа юм.

Матриц 2.1 Гэрлэсэн болон гэрлээгүй эрэгтэй, эмэгтэй малчдын ажил мэргэжлийн төлөвлөгөө.

<p>Мянгат малчин болно. Мянгат малчин, улсын сайн малчин руу зүтгэх л зорилготой байна. Эхлээд өмчөө тасдаж аваад малаа сайхан өсгөөд явна гэж бодоод байна. Ямаагаа голлоод өсгөнө. Өмнөговь аймаг, гэрлэсэн эрэгтэй малчин</p>	<p>Малаа чанаржуулна. Одоохондоо малаа өсгөнө гэсэн бодолтой байна. Чанартай цөөн малтай болохыг зорьж байна. Өмнө нь ямаа их бараг 500-д ямаатай байсан. Ямаагаа цөөлөөд цагийн нөхцөл байдал, бэлчээрээ бодоод малаа төрөлжүүлж адуугаа түлхүү өсгөх бодолтой байгаа. Өвөрхангай аймаг, гэрлэсэн эмэгтэй малчин</p>
<p>Аймгийн аварга малчин болно. Аав шигээ “Аймгийн аварга малчин” болно гэж мөрөөддөг. Малаа сайн маллаж, малын тоог өсгөх хэрэгтэй. Ховд аймаг, гэрлээгүй эрэгтэй малчин</p>	<p>Мянгат малчин болоход тусална. Малаа сайн маллаж гэр бүлдээ сайн тусалж аавыгаа мянгат малчин болгох. Гэр бүл зохиож нөхөр хүүхэдтэй болохыг хүсдэг. Би мэргэжил боловсролтой ажил хийдэг хүнтэй суухыг хүсдэг. Ховд аймаг, гэрлээгүй эмэгтэй малчин</p>

Судлагдсан 10 малчин тутмын ес нь аав ээж малчин хүмүүс, удам дагасан малчин хэмээн хариулсан байдаг. Удам дагасан залуу малчдын хувьд үр хүүхдээ малчин болгох тал дээр эргэлзсэн, малчин болгохгүй гэх байр суурь давамгайлж буй дүн гарчээ. Эрэгтэй малчдын хувьд хүүхдээ малчин болгоно гэсэн хариултын хувийн жин малчин болгохгүй гэж хариулсан эрэгтэйчүүдтэй харьцуулахад 2.7 пунктээр давуутай илэрсэн. Эмэгтэйчүүдийн хувьд хүүхдээ малчин болгохгүй гэж хариулсан хувийн жинг малчин болгоно гэж хариулсан эмэгтэйчүүдтэй харьцуулахад даруй 3.5 пунктээр илүүрсэн дүр зураг ажиглагдлаа.

Хүснэгт 2.2 Ирээдүйд үр хүүхдээ малчин болгох талаарх залуу малчдын санал бодол, хүйсээр болон хувиар.

	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
Хүүхдээ малчин болгох эсэх			
Малчин болгоно	17.2	21.1	18.8
Малчин болгохгүй	14.5	25.6	18.9
Одоогоор хэлж мэдэхгүй	45.7	48.2	46.7
Хүүхэдгүй, гэр бүлгүй	22.6	5.1	15.6
Хүйсийн хувьд			
Хүү	20.2	26.3	22.7
Охин	0.3	0.9	0.5
Хүйс хамаагүй	24.8	23.2	24.1
Одоогоор хэлж мэдэхгүй	54.7	49.6	52.6
Нийт	100.0	100.0	100.0

Судалгаанд оролцсон малчин залуусын 22.7 хувь нь хүүгээ, 0.5 хувь нь охиноо малчин болгоно гэжээ. Ялангуяа залуу эмэгтэй малчдын 26.3 хувь хүүгээ малчин болгоно гэж хариулсан нь эмэгтэйчүүдийн өгсөн хариултуудын дотор өндөр хувьтай үзүүлэлт болж

байна. Эцэг, эхчүүдийн дунд жендэрийн хэвшмэл ойлголтын нөлөөгөөр хүү, охины боловсрол эзэмших сонголтод нөлөөлөх хандлага илэрч байна.

ДҮГНЭЛТ

- Статистикийн мэдээлэл, бусад судалгааны дүн болон эрэгтэй, эмэгтэй малчдын амьжиргааны жендэрийн дүн шинжилгээнд хамрагдсан 6 аймгийн 24 сумын 3 оны статистик мэдээллээр 15-34 насны залуу малчдын, тэр дундаа эмэгтэй малчдын тоо буурч байна.
- Ихэнх залуу малчдын хувьд багаасаа мал малласан аав ээж нь малчин учраас удам дагаж, нөгөө талаас хүн бүл цөөнтэй, аав ээждээ туслах зорилгоор малчин болох сонголтыг хийснийг тоон болон чанарын баримтууд харуулж байна.
- Гэрлэсэн болон гэрлээгүй залуу эрэгтэй малчид мянгат малчин, улсын сайн малчин, аймгийн сайн малчин болохыг мөрөөддөг бол гэрлэсэн залуу эмэгтэй малчид үр хүүхдээ боловсролтой болгох, малаа чанаржуулах хүсэл эрмэлзэлтэйгээ илэрхийлсэн ялгаа ажиглагдаж байна.
- Судалгаанд хамрагдсан залуу малчид үр хүүхдээ удам дагасан малчин болгох бодолгүй, одоогоор тодорхойлж хэлж мэдэхгүй байгаа дүр зураг ажиглагдаж байна. Үр хүүхдээ удам залгах малчин болгох тохиолдолд хүйс хамаагүй гэж дийлэнх нь үзсэн ч хүүгээ малчин болгох сонголтыг хийх төлөвтэй байна.
- Залуу малчин эцэг, эхчүүдийн дунд санамсаргүйгээр хүйсээр ялгамжтай хандах, жендэрийн хэвшмэл ойлголтын нөлөөгөөр хүү, охины боловсрол эзэмших сонголтод нөлөөлж буйг нотлох баримт бол залуу эмэгтэй малчдын 26.3 хувь хүүгээ малчин болгоно гэсэн нь нийт дүнд өндөр хувьтай үзүүлэлтээр илэрснээр тайлбарлагдана.

ЗӨВЛӨМЖ

1. Залуу эрэгтэй, эмэгтэй малчдыг дэмжих бодлогыг боловсруулахдаа малчдын нийгэм хүн ам зүй, эдийн засаг, амьжиргааны статистикийн мэдээлэл, үзүүлэлт, тэдгээрийн үр дүнд суурилсан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх,
2. Малчин мэргэжлийг сурталчлах, өндөр ашиг шимтэй мал маллаж, амжилтад хүрч байгаа эрэгтэй, эмэгтэй залуу малчдыг нийгэмд таниулах, МАА-ын бизнес эрхлээд амжилтад хүрсэн сайн жишээг подкаст, шторк, стори хэлбэрээр нийгэмд хүргэх, таниулах
3. МСҮТ болон насан туршийн боловсролын төвийг түшиглэн, богино хугацааны, тэтгэлэгтэй сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, малчин залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийг хамруулж, мэргэжилтэй, ур чадвартай малчин бэлтгэх
4. Залуу малчин эрэгтэй, эмэгтэйчүүдэд зориулсан МАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэх, улмаар экспортлох зорилго бүхий ЖДҮ эрхэлж амьжиргаагаа сайжруулахыг дэмжсэн хамтрах, хорших хэлбэрээр өрхөд суурилсан бодлого, арга хэмжээ хэрэгжүүлэх
5. Жендэрийн хэвшмэл соёл нь залуусын мэргэжил сонголт улмаар гэрлэлтийн харилцаанд нөлөөлж эхэлсэн тул эцэг эх, залуу эрэгтэй, эмэгтэйчүүдэд жендэрийн боловсрол олгох соён гэгээрүүлэх арга хэмжээг тусгайлсан сургалтын хөтөлбөрөөр бэлтгэж, төлөвлөж, төсөвлөн зохион байгуулах.

Бүлэг 3.

ГЭРЛЭЛТ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

ХХААХҮ-ийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2018-2025)-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2-р зорилтын 4 дэх үйл ажиллагааны чиглэлд малчин гэр бүлийн хөгжлийг дэмжих, залгамж халааг бэлтгэх нийгэм соёл, эдийн засгийн цогц арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх гэж тусгасан байна. Мөн Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод (2016-2025) гэр бүлийн амьдралын таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах” чиглэлээр гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, үүрэг, хариуцлага, оролцоог хангах, гэр бүлийн харилцааны тогтвортой байдлыг дэмжих, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, гэм буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх зорилтыг хэрэгжүүлэхээр зорьжээ.

ҮСХ-ны тооллогоор 2020 оны дүнгээр нийт 181.050 малчин өрх байгаагийн 15-34 насны малчид 30 хувийг эзэлж байна⁶. Судлагдсан зургаан аймгийн 24 сумын статистик тоон мэдээллээр сүүлийн 5 жилд залуу малчин өрхийн тоо 12 хувиар өссөн байна. Харин Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Уянга, Увс аймгийн Наранбулаг, Зүүнхангай, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Ховд аймгийн Булган, Мөнххайрхан, Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Дорнод аймгийн Баяндун сумдын 15-34 насны малчин залуу гэр бүлийн тоо буурах хандлагатай бөгөөд бусад сумдын хувьд өсөх төлөв ажиглагдаж байна (Хүснэгт 3.1).

Судалгаанд хамрагдсан 24 сумын статистик тоо баримтыг цуглуулах явцад малчдын нийгмийн үзүүлэлтүүдтэй холбоотой тоон мэдээллийг гаргах боломж хангалтгүй байгаа бөгөөд зарим сумдын мэдээлэл дутуу, зөвхөн ирүүлсэн тоон мэдээлэл дээр тулгуурлан дүн шинжилгээ хийсэн болно. Тиймээс ирүүлсэн сумдын тоон мэдээллээс харахад сүүлийн 10 жилийн хугацаанд эмэгтэй тэргүүнтэй залуу малчин өрхийн тоо 15.2 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь эрэгтэйчүүдийн осол гэмтэл, нас баралт, гэр бүл цуцлалт зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

Хүснэгт 3.1 Судлагдсан 15-34 насны залуу малчин гэр бүлийн тоо.


Аймаг	Сум	Малчин залуу гэр бүлийн тоо			Үүнээс эмэгтэй тэргүүнтэй		
		2010	2015	2020	2010	2015	2020
Дорнод	Баяндун	270	270	440	7	7	11
	Булган	240	310	530	6	8	13
	Матад	320	390	450	9	7	11
	Цагаан-Овоо	270	420	460	7	7	11
Өвөрхангай	Бат-Өлзий	499	478	416	15	13	10
	Богд	129	206	233	8	7	9
	Сант	215	210	174	12	10	8
	Уянга	472	514	431	24	14	21
Увс	Наранбулаг	71	69	66			
	Тариалан	230	250	269	0	0	0
	Тэс	187	200	267	3	3	1
	Зүүнхангай	235	228	219			
Өмнөговь	Гурвантэс	20	25	48	1	2	3
	Мандал-Овоо	68	60	59	7	7	6
	Номгон	58	64	68	7	5	-
	Хүрмэн	93	81	97	4	19	16
Сэлэнгэ	Зүүнбүрэн	74	72	66	2	1	9
	Мандал	493	449	733	23	26	40
	Орхонтуул	107	106	137	35	34	10
	Цагааннуур	386	384	413	8	20	26
Ховд	Булган	98	124	105	7	6	5
	Дөргөн	236	244	260	17	15	11
	Мөнххайрхан		39	35		0	0
	Мянгад	181	192	252	2	6	10
Нийт		4109	7194	8189	169	187	197

Эх сурвалж: Сумын статистикийн мэдээлэл

Судалгаанд хамрагдсан залуу малчдын гэрлэлт, гэр бүлийн асуудлыг тодруулахад 21 хувь нь гэрлээгүй, 63.4 хувь нь гэрлэсэн, 13.9 хувь нь гэрлэлтээ бүртгүүлээгүй ч хамтран амьдардаг, 1.1 хувь нь бэлэвсэн, 0.6 хувь нь гэрлэлтээ цуцалжээ. Харин гэрлэлтийн байдлыг хүйсээр аваад үзвэл 4 эмэгтэй залуу малчдын гурав нь гэрлэсэн байхад эрэгтэйчүүдийн тал нь гэрлэлтээ батлуулсан байна. Гэрлэлтээ бүртгүүлээгүй хамтран амьдарч байгаа залуу малчдын 15 орчим хувь нь эрэгтэйчүүд, 12.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Харин судлагдсан залуу эрэгтэй малчдын 30 орчим хувь, эмэгтэй залуу малчдын 8.6 хувь нь гэрлээгүй байна. ҮСХ-ны тоон мэдээллээр 15-34 насны малчдын 65.3 хувь нь огт гэрлээгүй, 34.5 хувь нь гэрлэсэн, 0.1 хувь нь цуцалсан, 0.1 хувь нь бэлэвсэн, харин 25-34 насны малчдын 17.2 хувь нь огт гэрлээгүй, 81.6 хувь нь гэрлэсэн, 0.4 хувь нь цуцалсан, 0.4 хувь нь бэлэвсэн байна⁷.


⁷ www.1212.mn. ҮСХ, 2020. Хөдөө аж ахуйн салбарын 2019 оны танилцуулга. Улаанбаатар

Зураг 3.1 Судлагдсан залуу малчдын гэрлэлтийн байдал, хүйсээр.



Залуу малчин гэр бүлд гэр бүлийн харилцаатай холбоотой асуудлуудаас 15.8 хувь нь гэр бүлийн маргаан зөрчил, үл ойлголцол, 10 хувь нь хоёр тусдаа амьдрах, 7.3 хувь нь хардалт, 5.1 хувь нь хадмуудын оролцоо, 3.6 хувь нь архидалт, 1.8 хувь нь салалт, 1.6 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл гэж хариулжээ. Харин 52.2 хувь нь гэр бүлийн харилцаатай холбоотой ямар нэгэн асуудал байхгүй гэж хариулжээ. Дээрх гэр бүлийн харилцаатай холбоотой ихэнх асуудлуудын хувьд эрэгтэй, эмэгтэй залуу малчдын үзэл санаанд онцын ялгаа харагдахгүй байна. Гэхдээ залуу эмэгтэй малчин хүүхдээ сургуульд сургах зорилгоор хоёр тусдаа амьдарч байгаагаа гэр бүлийн харилцаанд гарч байгаа том асуудал гэж үзэх нь эрэгтэй залуу малчнаас даруй 2.6 хувиар илүү байна.

Зураг 3.2 Залуу малчны гэр бүлийн харилцаатай холбоотой асуудлууд, хүйсээр.



Аймаг, сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаар залуу малчин гэр бүл үр хүүхдүүдээ сургуульд суулгахаар ээж нь төв суурин газарт, аав нь хөдөө малаа маллаад амьдарч байна. Ингэснээр залуу малчин ээжүүд мал аж ахуйгаасаа хөндийрөх хандлага ихсэж байгаагаас гадна үүнтэй холбоотойгоор гэр бүлийн зөрчил, үл ойлголцол бий болж гэр бүл салалтыг нэмэгдүүлэх эрсдэлийг дагуулж байна. Мөн эмэгтэйчүүд мал аж ахуйгаа эрхлэх нь багассаны улмаас нэгж малаас авах бүтээгдэхүүн үйлдвэрлэл төдий хэмжээгээр буурч байна. Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийг бодвол ямар нэгэн боловсрол эзэмших байдал илүү байдаг бөгөөд үүнээс шалтгаалан мал маллан амьдрах эмэгтэйчүүдийн тоо цөөрч байна.

Хүснэгт 3.2 Сургуулийн хүүхдээ дагаж хоёр тусдаа амьдардаг 15-34 насны залуусын тоо, судлагдсан сумдаар болон онуудаар.

Аймаг	Сум	2010	2015	2020
Дорнод	Баяндун	9	6	12
	Булган	6	4	3
	Матад	22	65	113
	Цагаан-Овоо	6	4	3
Өвөрхангай	Бат-Өлзий	51	54	67
	Богд	20	50	30
	Сант	49	36	34
	Уянга	63	63	47
Өмнөговь	Хүрмэн	10	17	15
	Гурвантэс	10	20	0
	Номгон	36	33	14
	Мандал-Овоо	0	0	0
Сэлэнгэ	Зүүнбүрэн	30	28	34
	Мандал	74	62	81
	Орхонтуул	37	51	70
	Цагааннуур	39	54	68
Ховд	Булган	42	45	60
	Дөргөн	48	43	44
	Мөнххайрхан	7	5	4
	Мянгад	128	143	150
Увс	Наранбулаг	12	6	8
	Тариалан	0	0	0
	Тэс	2	1	1
	Зүүнхангай	15	16	12
Нийт		543	716	882

Эх сурвалж: Сумын статистикийн мэдээлэл

Судлагдсан сумдаас ирүүлсэн статистик тоон мэдээллээс харахад сүүлийн 10 жилийн хугацаанд сургуулийн хүүхдээ дагаж хоёр тусдаа амьдардаг залуу малчдын тоо 40 орчим хувиар нэмэгдсэн байна. Үүнд тухайн сумын залуу малчдын амьдардаг байршил, амьдралын боломж бололцоо, сургуулийн дотуур байрны үйлчилгээний чанар хүртээмж зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Залуу малчин гэр бүл хүүхдээ сургуульд сургахдаа хоёр тусдаа амьдрахаас гадна аймаг, сумын төвд байгаа эмээ өвөө, ах дүү, төрөл садан, сургуулийн дотуур байранд амьдруулдаг байна. Тухайлбал, Увс аймгийн Тариалан сумын хувьд тусдаа амьдарч байгаа залуучууд байхгүй байгаа нь сургуулийн хүүхдээ эмээ өвөө болон дотуур байр, хамаатан садныдаа түр хугацаагаар суулгаж байгаатай холбоотой.

Матриц 3.1 Залуу малчин гэр бүл хүүхдээ сургуульд сургах шалтгаанаар хоёр тусдаа амьдарснаас бий болж буй үр дагавар.

Давуу тал	Сөрөг үр дагавар
<ul style="list-style-type: none"> - Хүүхдэдээ боловсрол эзэмшүүлэх - Хүүхэд хамгаалал хангагдах - Хараа хяналтгүй хүүхдийн тоо багасах - Хүүхдийн нийгэм- сэтгэл зүйн таатай орчин бүрэлдэх, нийгмийн харилцаанд оролцох чадавх бүрдэх, - Бие даан амьдрах чадвар нэмэгдэх - Сурах идэвх, чармайлт, хяналт сайжрах 	<ul style="list-style-type: none"> - Хоёр тусдаа амьдрах - Гэр бүл салалт нэмэгдэх - Зарим тохиолдолд айлд суулгах /амьдруулах/ сууж байгаа хүүхдүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртөх - Залуу малчин гэр бүлийн харилцаанд үйл ойлголцол, хардалт ихсэх - Гэр бүлийн үнэнч байдал үгүй болох - Сургуулийн дотуур байрны үйлчилгээ, эрүүл аюулгүй орчин тааруу - Залуу малчин эмэгтэйчүүдийн тоо буурах - Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж буурах - Аймаг, сумын төвд зохиомол өрх үүсэх - Өрхөд зарцуулах төсөв нэмэгдэх - Малаа маллаж үлдсэн эрэгтэйчүүдэд өрхийн аж ахуйн ажлын ачаалал ихсэх, үүнээс үүдэн эрүүл мэндийн асуудал тулгарах

Эх сурвалж: Малчид, сум, аймгийн мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас.

Залуу малчин гэр бүл хүүхдээ сургуульд суулгах зорилгоор хоёр тусдаа амьдарснаар аав нь хөдөө малаа маллан үндсэн өрх дээрээ, ээж нь хүүхдүүдтэйгээ аймаг эсвэл сумын төвд өрх үүсгэснээр зохиомол өрхийг бий болгож байгаа нь залуу малчин өрхийн статистик тоог нэмэгдүүлэх хандлагатай байна. Үүнээс гадна хоёр тусдаа амьдарч өрх үүсгэснээр гэр бүлийн төсөв нэмэгдэх, орлого буурч тэдний амьжиргаа, амьдралын чанарт нөлөөлж байгааг залуу малчид ганцаарчилсан ярилцлагаар илэрхийлж байв. Тиймээс залуу малчдын гэр бүлтэй холбоотой энэ асуудал аймаг, суманд түгээмэл байгаатай холбоотой статистикийн тоо мэдээллийг нарийвчлан гаргаж, төр засгийн бодлого, шийдвэрт тусгаж шийдвэрлэх шаардлага тулгарч байгааг анхаарах хэрэгтэй байна.

ШИГТГЭЭ 3.1

Зургаан настнууд ээжтэйгээ сумын төвд, аав нь малаа маллаад тусдаа амьдардаг. 6 насандаа сургуульд сургах нь малчдын залгамж халаа байхгүй болж байна. Багаасаа мал дагасан нь байгаа, нэмж малчин болох нь бага.

Сэлэнгэ аймаг, ХХААГ-ын мэргэжилтэн, эрэгтэй.

Нэг хүүхэд маань 5-р анги, дунд маань энэ жил 1-р ангид орох юм. Манай эхнэр багш мэргэжилтэй. Хүүхдүүдтэйгээ төв дээр байдаг. Би хоёр гэрийн хооронд л явж байна даа. Манай хөдөө бол эхнэрүүд хүүхдээ харна, эрчүүд малаа маллана гэсэн амьдралтай л байна. Ихэнх нь хоёр тусдаа л байна.

Өвөрхангай аймаг, гэрлэсэн залуу эрэгтэй малчин.

Нийгмийн харилцаанд 6 настнууд бие дааж орж чаддаггүй тул сумын төвд ээжтэйгээ хамт орж ирдэг. Сумын төвийн айлуудад хөдөөнөөс ирсэн 6 настнууд олон. Үүнээс болж гэр бүл сална, ээж нь хүнтэй суугаад явчих асуудал хүртэл байна. Өрх хоёр тасарч хөрөнгө мөнгөний асуудал үүсдэг.

Сэлэнгэ аймаг, сумын ХХААГ-ын мэргэжилтэн, эрэгтэй.

Хүүхдүүд нь сургууль, цэцэрлэгт ороход эхнэр нь аймагт очоод суудаг, нөхөр нь малаа хараад үлддэг асуудал сүүлийн жилүүдэд ихсэж байна.

Өмнөговь аймаг, ХХААГ-ын мэргэжилтэн, эмэгтэй.

Залуу малчин гэр бүлтэй холбоотой дараагийн чухал асуудал бол гэрлэлт, цуцлалтын асуудал болж байна. Статистик мэдээллээ ирүүлсэн сумдын тоон мэдээллээс харахад гэрлэлтээ бүртгүүлсэн хосын тоо сүүлийн 10 жилийн хугацаанд 50 гаруй хувиар нэмэгдсэн бол гэр бүл цуцлалтын тоо 2010-2015 онд 30 хувиар өсөж байснаа сүүлийн 5 жилд харьцангуй тогтворжих хандлагатай байна. Гэрлэсэн залуу малчдын дундаж нас 28 байна.

Хүснэгт 3.3 Гэрлэлтээ бүртгүүлсэн болон цуцалсан 15-34 насны залуусын тоо.

Аймаг	Сум	Гэрлэлтээ бүртгүүлсэн залуусын тоо			Гэрлэлтээ цуцлуулсан залуусын тоо		
		2010	2015	2020	2010	2015	2020
Дорнод	Баяндун	9	19	22	2	1	0
	Булган	5	36	44	0	0	0
	Матад	8	24	8		1	
	Цагаан-Овоо	5	36	44	1	2	0
Өвөрхангай	Бат-Өлзий	29	39	11	0	4	5
	Богд	20	22	13	1	0	2
	Сант	12	12	18	0	1	0
	Уянга	60	74	22	0	2	3
Увс	Наранбулаг	30	20	14	9	12	8
	Тариалан				0	1	2
	Тэс	4	34	40	1	2	0
	Зүүнхангай	11	16	21	2	1	0
Өмнөговь	Гурвантэс	12	14	15			
	Мандал-Овоо	4	1	2	2	1	2
	Номгон	6	4	5	4	4	2
	Хүрмэн			4	3	0	0
Сэлэнгэ	Зүүнбүрэн	7	6	18	1	3	2
	Мандал	81	112	135	17	44	35
	Орхонтуул	6	11		0	2	
	Цагааннуур	21	26	22	5	3	2
Ховд	Булган		69	69	6	8	5
	Дөргөн	16	18	20	0	0	0
	Мөнххайрхан		4	0		3	0
	Мянгад	24	22	22	1	1	0
Нийт		259	564	593	60	93	63

Эх сурвалж: Сумын статистикийн мэдээлэл.

Залуу малчин эрэгтэйчүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаар ээж аав нар охидуудаа хот суурин газарт сургуульд сургахаар явуулдаг бөгөөд эргэж ирэх нь ховордож, охидууд сургуулиа төгсөөд ирэхээрээ малчин залуучуудыг тоохоо больж, мэргэжлээрээ ажиллах зорилгоор аймаг, сумын төвд суурьшдаг гэжээ. Мөн залуу эрэгтэй малчид эртхэн гэрлэж, үр хүүхэдтэй болох, гэрлээд малаа маллаж сайхан амьдрах, аав ээждээ туслах

хүсэл сонирхолтой байдаг аж. Гэрлэх насны залуу эмэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд түлхүү орсноор малчин эрэгтэй залуучуудын гэрлэх боломж хумигдаж, аажимдаа залуу малчин эрэгтэйчүүдийн гэрлэх нас хожуусах хандлагатай болж байна.

Аймаг, сумын мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаар эрэгтэйчүүдийн ялангуяа залуу эрэгтэй малчдын эрхийг хөндөх, хөвгүүдийн боловсролд анхаарах, эмэгтэй залуу малчдыг бэлтгэхэд анхаарах, эцэг эхчүүдэд зөв мэдлэг хандлагыг олгох шаардлагатайг илэрхийлж байна.

Матриц 3.2 Хөдөөд гэрлэх насны эмэгтэйчүүд багасч байгаагийн шалтгаан.

Аав ээжийн сонирхол	Охидын сонирхол
<ul style="list-style-type: none"> - Охидоо сургуульд явуулах - Малчин болгох хүсэлгүй 	<ul style="list-style-type: none"> - Их дээд сургууль сурах - Хөдөөд буцаж ирэхгүй - Хөдөө байвал хоцрогдоно гэж үзэх - Малчин залуутай гэрлэхгүй - Мэргэжлээрээ ажиллах - Хот суурин газар ажиллаж амьдрах

Эх сурвалж: Малчид, сум, аймгийн мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас.

ШИГТГЭЭ 3.2

Цөөн тооны л байдаг. Манай хөдөө бол охидууд байдаггүй. Хот хүрээ гээд ихэнх яваад өгдөг.

Өвөрхангай аймаг, гэрлээгүй залуу малчин, эрэгтэй.

Хоёр жилийн дотор эхнэр авч, үр хүүхэдтэй болж, малаа сайн маллаж юугаар ч дутаахгүй сайхан амьдармаар байна.

Дорнод аймаг, гэрлээгүй залуу малчин, эрэгтэй.

Хөдөө эмэгтэй хүүхэд ховор, бүжиг болохоор 1-2 айлын эхнэр дээр залуучууд бөөгнөрдөг. Гэрлэх насны залуучууд байгаад байдаг, тийм насны эмэгтэйчүүд дутагдалтай. Мал маллаж байгаа охид эмэгтэйчүүд ховор. Төвийн охид хөдөөний малчин залууг тоодоггүй.

Увс аймаг, сумын МАА-н тасгийн мэргэжилтэн, эрэгтэй.

Эхнэргүй 30 гарсан малчин залуус олон байна. Эмэгтэйчүүд хөдөө амьдрах, мал маллах сонирхолгүй, хот газар ажиллах сонирхолтой. Хөдөө явна гэхээр хоцрогдоно, нэгнээсээ дор орохгүй гэдэг ойлголттой. Залуучууд аав ээждээ туслах, мал гэдэг хөрөнгийг нь харж хандахын тулд мал маллаж байна.


Сэлэнгэ аймаг, сумын МАА-н тасгийн мэргэжилтэн.

Эхнэр хүүхэд байхгүй, хорь гарсан гуч хүрэх гэж байгаа залуучууд бол байна шүү дээ. Зарим нь бол амьжиргааны хувьд дунд хэмжээний залуучууд байна, зарим нь боломжийн хөрөнгөтэй, эхнэргүй гуч гарсан, мал хөрөнгө нь хангалттай болсон хүн байна.


Өмнөговь аймаг, ХХААГ-ын мэргэжилтэн, эрэгтэй.

Шилжин явсан болон ирсэн статистик тоон мэдээллээс харахад шилжин явсан залуу эмэгтэйчүүдийн тоо залуу эрэгтэйчүүдээс даруй 1-5 хувиар илүү байгаа бол шилжин ирсэн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийн тооноос 80 гаруй хувиар бага байна. Өөрөөр хэлбэл, шилжин явсан эмэгтэйчүүдийн дөнгөж 20 орчим хувь нь эргэж нутагтаа ирж байна. Иймээс залуу эрэгтэй малчдад гэрлэлтийн асуудал тулгамдаж байгааг статистикийн тоон мэдээлэл болон залуу эрэгтэй малчидтай хийсэн ярилцлагаас харагдаж байна.

Хүснэгт 3.4 Шилжин явсан
15-34 насны залуусын тоо.

Сум	2015	Үүнээс эмэгтэй	2020	Үүнээс эмэгтэй
Матад	46	25	33	27
Баяндун	11	5	6	4
Булган	5	3	4	8
Цагаан-Овоо	13	7	8	5
Бат-Өлзий	672	353	139	71
Богд	283	172	46	32
Сант	350	183	34	21
Уянга	812	455	63	40
Тариалан	97	35	69	30
Тэс	11	5	6	4
Мандал-Овоо	4	2	5	4
Номгон	5	4	7	3
Мандал	547	254	524	241
Дөргөн	6	4	8	3
Мянгад	61	32	78	30
Нийт	2923	1539	1030	523
				

Хүснэгт 3.5 Шилжин ирсэн
15-34 насны залуусын тоо.

Сум	2015	Үүнээс эмэгтэй	2020	Үүнээс эмэгтэй
Матад	17	11	122	53
Баяндун	13	7	8	5
Булган	9	6	10	3
Цагаан-Овоо	7	7	5	5
Бат-Өлзий	324	181	65	33
Богд	145	93	28	22
Сант	131	66	15	11
Уянга	399	187	37	25
Тариалан	127	55	15	6
Тэс	13	7	8	5
Мандал-Овоо	2	0	2	1
Номгон	6	3	6	3
Мандал	351	171	310	162
Дөргөн	9	5	6	3
Мянгад	44	19	152	67
Нийт	3612	818	2809	404
				

Эх сурвалж: Сумын статистикийн мэдээлэл.

Сумдын статистик тоон мэдээллээс харахад сүүлийн 10 жилийн хугацаанд гэрлээгүй эрэгтэй залуучуудын тоо гэрлээгүй эмэгтэйчүүдийн тооноос 10-13 хувиар өндөр байна. Энэ нь мөн л гэрлэх насны залуу эмэгтэйчүүд сургуульд сурах, мэргэжил боловсролоо дээшлүүлэх, ажил хийх зорилгоор шилжих хөдөлгөөнд идэвхтэй оролцож, хөдөөд залуу эмэгтэйчүүдийн тоо буурч байгаа ерөнхий хандлагыг илэрхийлж байна.

Хүснэгт 3.6 Гэрлээгүй 15-34 насны залуучуудын тоо.

Сум	2010			2015			2020		
	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт
Баяндун	50	14	64	53	8	61	47	2	49
Булган	44	14	58	48	10	58	38	2	40
Цагаан-Овоо	50	14	64	49	10	59	45	2	47
Матад	93	77	170	106	95	201	127	113	240
Хүрмэн	113	80	193	90	68	158	88	76	164
Гурвантэс	192	161	353	202	220	422	231	256	487
Мандал-Овоо	30	24	54	27	18	45	22	24	46
Зүүнбүрэн	150	110	260	205	116	321	231	225	456
Мандал	208	195	403	226	243	469	241	246	487

Булган	438	324	762	571	392	963	527	456	983
Дөргөн	91	67	158	38	49	87	45	49	94
Мянгад	99	87	186	113	118	231	139	147	286
Наранбулаг	246	254	500	281	222	503	361	251	612
Тариалан	228	172	400	346	207	553	390	274	664
Тэс	50	14	64	49	10	59	45	2	47
Зүүнхангай	414	370	784	399	391	790	419	314	733
Нийт	2496	1977	4473	2803	2177	4980	2996	2439	5435
	+11.6%			+12.6%			+10.2%		

Эх сурвалж: Сумын статистикийн мэдээлэл.

Малчин эмэгтэйчүүдээс “хүчирхийлэл”-ийн талаарх ойлголттой эсэхийг тодруулахад 75.6 хувь нь мэддэг, 24.4 хувь нь мэддэггүй, мөн малчин эмэгтэйчүүдээс ямар нэгэн хүчирхийлэлд өртөж байсан эсэхийг асуухад 75.7 хувь нь өртдөггүй, 24.4 хувь нь хүчирхийлэлд өртсөн буюу өртдөг талаар дурджээ. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 34.2 хувь нь бие махбодийн, 46.4 хувь нь сэтгэл санааны, 9.7 хувь нь эдийн засгийн, 9.7 хувь бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаараа илэрхийлжээ⁸.

Судалгаанд хамрагдсан сумдаас ирүүлсэн статистик мэдээллээс харахад сүүлийн 5 жилд хүчирхийллийн дуудлага, зөрчлийн тоо, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тоо буурах төлөвтэй байгаа нь нэг талаас сум орон нутагт нэг нэгийгээ мэддэгээс малчид ичиж зовох, нэр төрөө бодох, эргээд хүчирхийлэл дарамтад өртөхөөс эмээх зэргээс хамааран мэдээлэхгүй байгаа нь ганцаарчилсан ярилцлагад оролцсон залуу малчид илэрхийлж байна.

Иймээс гэр бүлийн хүчирхийллийн илрүүлгийг сайжруулах, хохирогчийг хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх, хөдөө, орон нутагт амьдарч байгаа залуу малчдад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай хуулийг сурталчлан таниулах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Хүснэгт 3.7 Хүчирхийллийн дуудлага, зөрчлийн тоо, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тоо, сумдаар

Сум	Хүчирхийллийн дуудлага		Зөрчлийн тоо		Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг		Эрүүлжүүлэх байраар үйлчлүүлсэн залуу малчдын тоо	
	2015	2020	2015	2020	2015	2020	2015	2020
Наранбулаг	1	3	45	67	0	1		
Зүүнхангай	1	3	15	20	0	0		
Тэс	6	3	4	2	0	0		
Тариалан	5	1	12	10	2	2	11	0
Зүүнбүрэн	6	13	68	61	5	0	12	23
Цагааннуур	4	5	207	116		1		3
Орхонтуул	0	3	78	53	0	0	17	4

⁸ ХЭҮК. 2019. Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн хэрэгжилт: хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн зарим асуудал. Улаанбаатар

Мандал	137	26	4746	3993	26	12	1106	688
Гурвантэс	5	4	3	2	0	0	40	0
Номгон	1	3	1	3	0	0	1	2
Мандал-Овоо	1	1	2	1	0	0	4	4
Булган\Ховд	3	2	0	24	4	9		207
Дөргөн	1	3	3	4	0	1		2
Мөнххайрхан	1	2	0	2	1	0		
Матад	1	3	1	2	1	2	2	4
Цагаан-Овоо	7	6	4	4	1	0		
Уянга	0	10	60	56	9	10	25	
Нийт	180	91	5249	4420	49	38	1218	944
Үүнээс эмэгтэй							55	46

Эх сурвалж: Сумын статистикийн мэдээлэл (сумдаас эрүүлжүүлэх байраар үйлчлүүлсэн залуу малчдын тоог хүйсээр ангилсан байдлаар ирүүлсэн бөгөөд бусад үзүүлэлтийн хувьд хүйсээр гардаггүй байна)

Судлагдсан залуу малчдын 31.8 хувь нь мотоциклоор малаа хариулдаг ба сумдаас ирүүлсэн статистик мэдээллээс харахад мотоциклийн осолд өртсөн залуу малчдын тоо сүүлийн 10 жилд өсөх хандлагатай байна. Үнэ хямд, хятад мотоциклоор малаа хариулах практик малчдын дунд өргөн дэлгэрсэн, мотоцикл унах хамгаалалтын хэрэгслийг малчид хэрэглэдэггүй, энэ талаарх ойлголт мэдлэг муу байгаагаас осол гэмтэлд өртөх эрсдэл нэмэгдэж буйг анхаарч мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, урьдчилсан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах талаар бодлого шийдвэр зайлшгүй шаардлагатай байна.

Хүснэгт 3.8 Мотоциклийн осолд өртсөн залуу малчдын тоо.

Сум	2010	2015	2020
Наранбулаг	0	0	0
Зүүнхангай	0	0	1
Тэс	0	0	0
Тариалан	0	0	0
Зүүнбүрэн	0	0	0
Цагааннуур	0	2	0
Орхонтуул	0	0	0
Мандал	2	7	0
Гурвантэс	0	1	2
Мандал-Овоо	0	1	0
Булган\Ховд	0	6	2
Дөргөн	1	1	2
Мөнххайрхан	0	0	0
Мянгад	6	4	5
Баяндун	0	0	6
Матад	0	1	0
Уянга	7	3	5
Нийт	16	26	24

Эх сурвалж: Сумын статистикийн мэдээлэл

ДҮГНЭЛТ

- Залуу малчин гэр бүл хүүхдээ сургуульд сургах зорилгоор хоёр тусдаа, ээж нь төв суурин газарт хүүхдүүдтэйгээ, аав нь хөдөө малаа маллаад амьдрах явдал сүүлийн 10 жилийн хугацаанд 40 хувиар нэмэгдсэн байна. Ингэснээр залуу малчин ээжүүд мал аж ахуйгаасаа хөндийрөх, мал аж ахуйн хөдөлмөрийн бүтээмж буурах, гэр бүлийн зөрчил, үл ойлголцол бий болох, гэр бүл тогтворгүй болох нөхцөлийг бүрдүүлж байна.
- Залуу малчин гэр бүл хоёр тусдаа амьдарснаар аав нь хөдөө малаа маллан үндсэн өрх дээрээ, ээж нь хүүхдүүдтэйгээ аймаг эсвэл сумын төвд өрх үүсгэснээр зохиомол өрхийг бий болгож байна.
- Малчдын охид хот суурин газарт сургуульд сурах зорилгоор шилжиж, буцаж ирэлгүйгээр суурьшсанаар хөдөөд гэрлэх насны залуу эмэгтэйчүүдийн тоо буурч залуу малчин эрэгтэйчүүдийн гэрлэх боломж хумигдаж, аажимдаа малчин залуучуудын гэрлэх нас хойшилж, улмаар малчин хүн ам буурах төлөв харагдаж байна.

ЗӨВЛӨМЖ


1. Залуу малчдын гэр бүл, нийгмийн асуудалд холбогдох статистикийн тоон мэдээлэл хөндсөн тоог нас, хүйс, байршлаар нарийвчлан гаргаж ашиглах;
2. Залуу малчин гэр бүл хүүхдээ сургуульд сургах зорилгоор хоёр тусдаа амьдарч байгаа залуу малчдын асуудалд анхаарал хандуулан, хүүхдээ сургуульд сургахад таатай орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
3. Залуу малчдад гэр бүлийн үнэ цэн, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг оролцоо, хариуцлагын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх;
4. Бага боловсролд хамрагдаж буй малчин өрхийн хүүхдийг сургуулийн орчинд дасан зохицох орчныг бүрдүүлэх (Увс аймгийн Бөхмөрөн сумын ЕБС дээр хэрэгжүүлж буй сайн туршлагыг нэвтрүүлэх);
5. Залуу эмэгтэйчүүдийг малчин болгоход тодорхой урамшууллын хөшүүргийг нэвтрүүлэх, жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх зөв үзэл хандлагыг төлөвшүүлэх талаар чиглэсэн арга хэмжээ явуулах.

Бүлэг 4.

АМЬЖИРГАА, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР


Үндэсний статистикийн хорооноос гаргаж буй хүн амын амьжиргааны доод түвшинг харвал байршлаас хамаарсан тодорхой ялгаа ажиглагддаг. Ялангуяа хөдөөгийн хүн амын амьжиргааны доод түвшин хот суурин буюу Нийслэлээс тогтмол доогуур түвшинд байж ирсэн. Эндээс орон нутагт амьдарч, ажиллаж буй малчин өрхийн амьжиргаа төдийлөн хангалттай түвшинд хүрэхгүй байна гэж үзэж болох юм. Энэ бүлэгт залуу малчдын өрхийн амьжиргаа, орлогын эх үүсвэр, МАА-н үйлдвэрлэлийн орлого болон МАА-н бус үйл ажиллагааны орлого, зарлагын талаар авч үзэх болно.

Зураг 4.1 МАА эрхлэхээс гадна давхар ажил эрхлэлт.




Зураг 4.1-ийг харвал судалгаанд хамрагдсан залуу малчдын 82.6 хувь нь зөвхөн мал аж ахуй эрхэлдэг бол 17.4 хувь нь давхар ажил эрхэлдэг байна. Давхар ажил эрхэлдэг гэж хариулсан малчдын 24.7 хувь нь төрийн албанд, 19.2 хувь нь улирлын чанартай ажил, 13.7 хувь нь ачаа тээврийн жолооч, 13 хувь нь хувийн хэвшил, 8.2 хувь нь үйлчилгээний бизнес эрхэлдэг, 7.5 хувь нь туслах аж ахуй тус тус эрхэлдэг байна. Мөн бусад төрлийн ажил эрхэлдэг гэж 13 хувь нь хариулсан ба үүнд оёдолчин, хувиараа, галч, дархан зэрэг ажлууд багтаж байна. Эндээс үзвэл залуу малчдын дийлэнх нь зөвхөн мал аж ахуй эрхэлж амьдардаг ба мал аж ахуй орлогын гол эх үүсвэр болж байна.

Зураг 4.2 Давхар ажил эрхлэлт, хүйсээр.



Мал аж ахуйгаас гадна давхар ажил эрхлэлтийг хүйсээр авч үзэхэд өөр ажил эрхлэх байдал эрэгтэй малчдын хувьд эмэгтэй малчидтай харьцуулахад 3.6 хувиар өндөр буюу 18.9 хувь байна. Ялангуяа улирлын чанартай ажил, ачаа тээврийн жолооч хийх, хувийн хэвшлийн байгууллагад ажиллах байдал эрэгтэй малчдын дунд илүү өндөр хувьтай байна. Харин эмэгтэй малчдын хувьд төрийн алба, үйлчилгээний бизнес эрхэлдэг, туслах аж ахуй эрхэлдэг гэж хариулсан байдал эрэгтэй малчдаас өндөр хувьтай байна. Эмэгтэй залуу малчдын бусад гэж хариулсан ажлын төрөлд оёдолчин, газар тариалан, сувилагч, теллер, оюутан, хувиараа ажил эрхлэлт багтаж байна. Эрэгтэй залуу малчдын хувьд дээрхээс бусад төрлийн ажилд галч, дархан, мужаан, БНСУ руу явж ажилладаг, хадлан, төмөр зам дээр, хувиараа зэрэг хариултууд багтсан.

Зураг 4.3 МАА эрхлэхээс гадна давхар ажил эрхлэлт, байршлаар, хувиар.



Судалгаанд хамрагдсан залуу малчид мал аж ахуй эрхлэхээс гадна давхар ажил эрхэлж буй байдлыг байршлаар харьцуулан авч үзэхэд тухайн орон нутгийн онцлог ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал Сэлэнгэ аймгийн залуу малчид зөгийн аж ахуй, гахайн аж ахуй, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, самар, жимс түүх, мод бэлтгэх зэрэг ажлыг давхар эрхэлж буй бол Өмнөговь аймгийн залуу малчдын хувьд жолооч болон улирлын чанартай ажил түлхүү хийж байна. Увс, Ховд аймгийн залуу малчдын хувьд төрийн албанд давхар ажил эрхлэх нь бусад аймагтай харьцуулахад өндөр байна. Чанарын судалгааны дүнгээс үзвэл, Өмнөговь аймгаас оролцсон залуу эрэгтэй малчдын хувьд уурхайд улирлын чанартайгаар ажиллах, ачаа тээврийн жолооч хийх явдал өндөр харин Сэлэнгэ аймгаас хамрагдсан залуу эмэгтэй малчдын хувьд туслах аж ахуй буюу өөрийн эзэмшлийн газартаа хүнсний ногоо тарих зэргээр МАА эрхлэхээс гадна давхар ажил эрхэлж, өрхийн амьжиргаагаа дэмжиж байгаа талаар онцолжээ.

Хүснэгт 4.1. Өрхийн орлогын эх үүсвэрүүд, хүйсээр, хувиар.

Орлогын эх үүсвэр	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Мал аж ахуй	98.7	98.4	99.1
Хүүхдийн мөнгө	76.5	68.9	87.8

Нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмж, шилжүүлэг (групийн тэтгэмж, тэжээгчээ алдсаны тэтгэмж, хүнсний талон г.м)	16.5	12.5	22.6
Цалин (улирлын чанартай, түр зуурын ажил хөдөлмөр)	16.3	19.2	11.9
Өндөр насны тэтгэвэр	5.5	7.1	3
Газар тариалан, хүнсний ногоо, жимсгэнэ зэрэг өрхийн аж ахуйн орлого	1.9	1	3.3
Айлын мал малласан хөлс	1.7	2.2	0.9
Дугуй засвар, мухлаг, дэлгүүр, цайны газар, аялал жуулчлал зэрэг жижиг бизнес эрхэлсэн	0.6	0.2	1.2
Хурдны морь уяж, уралдуулснаас олох орлого	0.6	0.8	0.3
Бусад	0.6	0.8	0.3
Оёдол, үйлийн хөлс	0.5	0.2	0.9
Хадлан, бордоо хадаж зарж борлуулснаас	0.4	0.6	0
Ан агнасан, жимс, самар, мөөг, эмийн ургамал түүж борлуулсан	0.2	0.4	0

Судалгаанд хамрагдсан залуу малчдын 98.7 хувьд нь мал аж ахуйн, 76.5 хувьд нь хүүхдийн мөнгө, 16.5 хувьд нь нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмж, шилжүүлэг, мөн 16.5 хувьд нь цалингийн орлогууд орлогын гол эх үүсвэр болж байна. Залуу малчдын хувьд дунджаар 2 төрлийн эх үүсвэрээс орлого олдог байна. Энэ нь дийлэнх тохиолдолд мал аж ахуй болон хүүхдийн мөнгө болохыг дээрх хүснэгтээс харж болно. Өрхийн орлогын эх үүсвэрийг хүйсээр авч үзэхэд эрэгтэй малчдын хувьд цалингийн орлого олж буй байдал эмэгтэй малчидтай харьцуулахад 7.3 хувиар, өндөр насны тэтгэврээс олж буй орлого 4.1 хувиар, айлын мал маллаж олж буй орлого 1.3 хувиар тус тус илүү байна. Харин эмэгтэй малчдын хувьд хүүхдийн мөнгөнөөс орлого олж буй байдал 18.9 хувиар, нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмжээс орлого олж буй байдал 10.1 хувиар, газар тариалан, хүнсний ногоо, жимсгэнэ зэрэг өрхийн аж ахуйн орлого олж буй байдал 2.3 хувиар эрэгтэй малчидтай харьцуулахад өндөр байна.

ШИГТГЭЭ 4.1

Малчдын ноос, ноолуур тушаах үед гологдол гаргаж, түүнийг авахгүй хаягдаж байгаа нь хэцүү санагддаг. Ашиглаж чадахгүй хаяж байгаа. Бараа их үнэтэй болсон. Малчдын бэлтгэсэн малын ноос, ноолуур үнэ бага /үнэгүй/ болоод байгаа. Авахгүй хаягдаад байгаа ноос, ноолуурыг төр, засгаас дэмжлэг үзүүлээд малчдаас худалдаад авчихдаг бол эдийн засгийн хувьд нэмэртэй байна.


Увс аймаг, гэрлэсэн эмэгтэй, 31 настай.

Малын түүхий эд, цагаан идээгээ боловсруулах, хэрхэн борлуулж ашиг орлогоо нэмэгдүүлэх вэ гэдэг дээр бэрхшээл гардаг. Манай орон нутагт ажлын байр байхгүй учраас манай гэр бүл мал дээр гарах гол шалтгаан болсон. Эхнэрийн ажлын байр гэхэд суманд ганцхан байдаг. Бас цалин багатай. Иймээс амьдрахын эрхээр мал дагаж байна.

Увс аймаг, гэрлэсэн эрэгтэй, 32 настай.


Ганцаарчилсан ярилцлагын дүнгээр, мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ буурч, бусад төрлийн бараа бүтээгдэхүүний үнэ өсч байгаа нь малчдын хувьд дарамт болдог байна. Мөн мал аж ахуйгаас гадна давхар ажил эрхлэх боломж хомс тул цор ганц орлогын эх үүсвэрээс хамааралтай болгожээ. Нүүдлийн мал аж ахуй эрхэлж байгаа, эрс тэс жилийн 4 улиралд ган, зуд зэрэг байгалийн хүчин зүйлээс хамаарал ихтэй зэрэг шалтгаанаар малчдын амьжиргаа эрсдэлтэй байна. Түүнчлэн малын түүхий эд, цагаан идээг бэлтгэж боловсруулсны дараа хэрхэн борлуулж ашиг орлогоо нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгаас сургалт зохион байгуулах, дэмжлэг шаардлагатай гэжээ.

Зураг 4.4 2020 онд мал аж ахуйн бүтээгдэхүүнээс олсон өрхийн орлогын дундаж хэмжээ, хүйсээр.




2020 оны байдлаар судалгаанд хамрагдсан залуу малчин өрхийн мал аж ахуйн бүтээгдэхүүнээс олж буй жилийн орлогын хэмжээг авч үзэхэд 5 хувь нь 500,000 хүртэл төгрөг, 8 хувь нь 500,000-1,000,000 төгрөг, 18 хувь нь 1,000,001-2,500,000 төгрөг, 26 хувь нь 2,500,001-5,000,000 төгрөг, 18 хувь нь 5,000,001-8,000,000 төгрөг, 25 хувь нь 8,000,001 төгрөг ба түүнээс дээш хэмжээнд орлого олж байна. Харин хүйсээр авч үзэхэд 2,500,000-8,000,000 хүртэлх төгрөгийн орлогыг эрэгтэй залуу малчид эмэгтэйчүүдтэй харьцуулахад 5.3 хувиар илүү бол 8 сая ба түүнээс дээш орлого олсон байдлаар залуу эмэгтэй малчид эрэгтэйчүүдтэй харьцуулахад 6.5 хувиар илүү байна.

Зураг 4.5 Залуу малчин өрхийн 2020 онд МAA-н үйлдвэрлэлээс олсон орлого, ам бүлийн тоо, дунджаар, байршлаар.




Судалгаанд хамрагдсан залуу малчин өрхийн МАА-н үйлдвэрлэлийн жилийн дундаж орлогыг байршлаар авч үзэхэд Өмнөговь аймаг хамгийн өндөр буюу 11,785,290 төгрөг байгаа бол Өвөрхангай аймаг 4,631,989 төгрөг байгаа нь бусад аймгуудтай харьцуулахад доогуур байна. Хэдий тийм боловч Өвөрхангай аймаг нь судалгаанд хамрагдсан 6 аймгаас хамгийн олон толгой малтай бөгөөд улсын хэмжээнд 21 аймгийн дунд малын тоогоор 5-т жагсаж байна. Мал аж ахуйн үр шимийг бүрэн хүртэх буюу сүү, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах, малын тоо бус чанарт анхаарах, малын гаралтай түүхий эдийг ашиглах явдал нь МАА-н үйлдвэрлэлийн орлого өндөр байхад голлон нөлөөлдөг болох нь харагдаж байна. Мөн мал аж ахуй эрхлэхэд хүн хүч ихээхэн шаарддаг тул ам бүлийн тооноос хамаарсан МАА-н үйлдвэрлэлийн орлогын ялгаа буй эсэхийг үзэхэд судалгаанд хамрагдсан залуу малчин өрхүүд дунджаар 4-5 ам бүлтэй бөгөөд ам бүлийн тооноос хамаарсан МАА-н үйлдвэрлэлийн орлогын ялгаа ажиглагдсангүй.

Зураг 4.6 Мал аж ахуйн бүтээгдэхүүнээс олсон орлогын дундаж хэмжээ.



Залуу малчдын мал аж ахуйн бүтээгдэхүүнээс олох орлогын хэмжээнд ноолуур, мах, мал төл зарах нь хамгийн өндөр орлогыг авчирдаг байна. Эндээс үзвэл Өмнөговь аймгийн залуу малчин өрхийн МАА-н үйлдвэрлэлээс олох орлого хамгийн өндөр байсан нь ноолуурын орлого буюу тухайн аймаг ямааны тоогоороо 21 аймгаас гуравт орж буйтай холбоотой байж болох юм. Судалгааны үр дүнгийн дунджаар 2020 онд 1 малчин өрх ноолуураас 3.7 сая төгрөг, махнаас 2.1 сая төгрөг, мал, төл зарж 2.3 сая төгрөг, сүү, сүүн бүтээгдэхүүнээс 591,167 төгрөг, малын арьс ширнээс 432,592 төгрөг, ноосноос 432,592 төгрөгийн орлого олсон байна. Харин орлого олох зорилгоор борлуулдаг мал аж ахуйн бүтээгдэхүүний төрлийг авч үзэхэд ноолуур 30 хувь, ноос 17.7 хувь, мах 16.8 хувь, мал төл зарах 14.7 хувийг тус тус эзэлж байна. Мал аж ахуйн бүтээгдэхүүнээс олсон дундаж орлогын хэмжээг хүйсээр авч үзэхэд ноос, ноолуураас бусад төрлийн бүтээгдэхүүний хувьд залуу эрэгтэй малчдын олсон орлогын хэмжээ эмэгтэйчүүдээс илүү өндөр байна. Тухайлбал сүү, сүүн бүтээгдэхүүнээс 257,954 төгрөгөөр, ноолуураас 471,495 төгрөгөөр, махнаас 289,114 төгрөгөөр, мал төлөөс 600,789 төгрөгөөр тус тус илүү орлого олсон байна. Судалгаанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй залуу малчдын мал аж ахуйн бүтээгдэхүүнээс олсон орлогын дундаж хэмжээг нэгтгээд үзвэл эрэгтэй залуу малчид дунджаар 10,272,977 төгрөг, эмэгтэй залуу малчид 8,980,486 төгрөгийг 2020 онд олсон нь 1,292,491 төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь эрэгтэйчүүдийнхээ дундаж орлогын 86.8 хувьтай тэнцүү байна.

Зураг 4.7 МАА-н үйлдвэрлэлийн орлогын бүтэц, МАА-н бүтээгдэхүүнээр.



Судалгаанд хамрагдсан залуу малчин өрхүүд МАА-н бүтээгдэхүүн дунд ноолуураас хамгийн өндөр орлого олдог буюу ноолуур зарсан малчдын 19 хувь нь 5 сая ба түүнээс дээш төгрөгийн орлого олсон байна. Эндээс үзвэл залуу малчдын орлогын бүтцэд ноолуур, мал, төл зарах, мах зарах нь дийлэнх хувийг эзэлж байна. Харин сүү, сүүн бүтээгдэхүүн зарах нь ноос, малын арьс шир зарснаас бага орлого олдог бөгөөд ганцаарчилсан ярилцлагаас үзвэл сүү, сүүн бүтээгдэхүүнийг борлуулах зах зээлгүй, мөн түргэн муудах бүтээгдэхүүнийг хэрхэн удаан хугацаанд хадгалах, боловсруулах тал дээр тодорхой сургалт шаардлагатай байдаг гэжээ.

Хүснэгт 4.2. Судалгаанд хамрагдсан сумдын малын тоо, сумдаас ирүүлсэн тоон мэдээллээр⁹.

Байршил		Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ	Бүгд
Сэлэнгэ	Зүүнбүрэн	35,256	36,039	13,597	4,604		89,496
	Мандал	36,710	42,954	35,453	14,631	34	129,782
	Цагааннуур	83,306	68,045	25,115	5,927		182,393
	Орхонтуул	109,509	87,640	18,834	14,776	362	231,121
Өмнөговь	Хүрмэн	38,621	115,174	1,345	7,287	11,104	173,531
	Гурвантэс	12,562	211,126	606	4,043	9,368	237,705
	Номгон	50,030	236,221	2,680	8,110	9,506	306,547
	Мандал-Овоо	56,114	102,479	1,118	5,923	25,022	190,656
Өвөрхангай	Сант	112,929	109,659	7,181	9,587	835	240,191
	Бат-Өлзий	109,053	77,862	46,670	29,847		263,432
	Богд	115,333	326,180	5,605	16,106	10,635	473,859
	Уянга	112,450	103,410	55,340	25,300	-	296,500
Ховд	Булган	62,534	191,529	34,193	12,946	2,297	303,499
	Дөргөн	31,715	89,168	4,552	5,796	4,976	136,197
	Мөнххайрхан	47,603	49,412	8,354	3,637	118	109,124
	Мангад	11,936	1,472	1,428	8,518	125,805	239,069
Увс	Наранбулаг	128,400	104,860	7,620	6,370	2,870	250,120
	Тариалан	84,909	57,115	6,805	3,492	885	153,206
	Тэс	1,584	3,334	201	15,025	7,841	27,984
	Зүүнхангай	95,928	67,385	11,562	11,309	158	186,342

9 www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_1001_021V1 YCX. 2020.

Дорнод	Баяндун	118,032	65,162	24,379	15,839	340	223,752
	Булган	106,301	63,911	19,606	30,729	413	220,960
	Матад	82,660	59,903	29,193	36,590	599	208,945
	Цагаан-овоо	112,981	90,795	27,029	30,980	651	262,436

Үндэсний статистикийн хорооны тоон мэдээнээс үзэхэд малын тоо, толгой жил тутам өсөн нэмэгдэж байна. Энэ нь малчдын амьжиргаа дагаад дээшилж байна гэж үзэх нэг үндэслэл юм. Хэдий тийм боловч малчин өрхүүдийн малын тоо, төрөл харьцангуй ялгаатай буюу дээд тал нь 1000 хоньтой айл байхад нөгөө талд хоньгүй, 1278 ямаатай малчин өрх байхад ямаагүй, 400 үхэртэй айл байхад огт үхэргүй, 600 адуутай айл байхад огт адуугүй, 217 тэмээтэй өрх байхад огт тэмээгүй зэргээр орлогын үндсэн эх үүсвэр болох малын тооноос хамаарсан орлогын тэгш бус байдал бий болжээ. Улсын хэмжээнд төвийн болон хангайн бүс нутаг дахь малын тоо нь баруун болон зүүн бүсээс илүү байгаа нь бэлчээрийн газрын хүрэлцээ, өвс ургамлын үржил шим төдийгүй малчин өрхийн тооноос шалтгаалж ялгаатай байна. Судалгаанд хамрагдсан залуу малчдын хариултын дунджаас үзвэл нэг өрх 117 хонь, 150 ямаа, 22 үхэр, 20 адуу, 3 тэмээтэй байна.

ШИГТГЭЭ 4.2


2021 оноос малын тоо толгойн албан татварын хууль хэрэгжиж 1 хонь 500, үхэр 500 ямаа адуу тус бүр 1000 төг жилд 2 хувааж төлнө. Энэ орлого суманд төвлөрч худаг ус гаргах, мал вакцинжуулах, малчдын орлого сайжруулахад зарцуулагдана. Уламжлалт хандлагаар малын тоог өсгөх, богино хугацаанд ашиг олохоо тооцож чадахгүй байна. Татварын хууль үүнийг малчдад ойлгуулна. Мөн үхрээ сүүнийх болгож байгаа тохиолдолд сүү борлуулах, зах зээл г.м бүх зүйлийг тооцож шийдэх хэрэгтэй. Бэлчээрийн даац 3 дахин хэтэрсэн. 28 га бэлчээрт 168,0 мал бэлчихээс 231,0 мал бэлчиж байна. 2015 оны АИТХ-ын тогтоолоор газар тариалангийн бүсэд гадны отор оруулахгүй байхаар зохицуулсан ч Өвөрхангай, Булган, Төв, УБ-аас 50 өрхийн 40,0 малтай гэр бүлээрээ ирж 3-4 сар оторлодог. Өвөрхангай өвс газрын гарц муудсан 7 жил нутагтаа очоогүй оторлож яваа малчид байна. Гадны оторчид жил бүр өөр өөр аймагт отор хийдэг. Манай сумынхан өвөлжөөн дээрээ хаварждаг, зуслан намаржаандаа 2 нүүдэг. Малчид давхар ажил эрхэлдэггүй, гэр бүлийн хүн нь ТАХ болж байна.

Сэлэнгэ аймаг, ХХА-н мэргэжилтэн эрэгтэй

Сүүлийн жилүүдэд мал маллах залуу малчид нэмэгдэж байгаа. Нийгмийн даатгалын сард төлөх хэмжээ хэтэрхий өндөр учраас хамрагдалт муу байна. Залуу малчдын өрхийн орлого муу, малын ашиг шим зах зээлд үнэ хямд байна.


Дорнод аймаг, ХАА-н мэргэжилтэн, эрэгтэй.

Зураг 4.8 Судалгаанд хамрагдсан сумдын 5 хошуу малын төрөл, хувиар.



Залуу малчдын хувьд МАА-н бүтээгдэхүүнээс олж буй орлогын дийлэнх хувийг ноолуур эзэлж байна. Энэ утгаараа маллаж буй малын 47 хувь нь ямаа байгаа бөгөөд үр шим их өгдөг гэж үзэн ямаа маллах явдал их боловч эргээд бэлчээр муудаж буйг ярилцлагын судалгааны үеэр онцолж байв. Бусад маллаж буй 5 хошуу малын хувьд хонь 35 хувь, үхэр 6 хувь, тэмээ 4 хувийг эзэлж байна. Тэмээ маллаж буй малчдын хувьд говь Ховд, Увс, Өмнөговь аймгийн зарим сумд тэмээ маллах явдал их байна.

Зураг 4.9 Судалгаанд хамрагдсан залуу малчдын малын тоо, хувиар.



Судалгаанд хамрагдсан залуу малчдын 43 хувь нь 200 хүртэл, 41.3 хувь нь 201-500 хүртэл буюу нийт 84.3 хувь нь 500 хүртэл толгой 5 хошуу малтай байна. Харин 12.8 хувь 500-1000 хүртэл, 2.9 хувь 1001 ба түүнээс дээш малтай байна. Эндээс залуу малчдын хувьд эзэмшиж буй малын тоо толгой хоорондоо ихээхэн ялгаатай байгаа нь орлого болон амьжиргааны хувьд ялгаатай байдлыг бий болгож байна гэж үзэж болох юм. Мөн судалгаанд залуу малчид хамрагдсан бөгөөд тэд эцэг, эхийн мал сүргээс таслан авч өөрийн гэр бүлийг үүсгэсэн тул цаашид дээрх малын тоо, толгой өсөх бүрэн боломжтой байна. Хэдий тийм боловч залуу малчдыг малын тоонд анхаарахаас илүүтэй чанартай, цөөн тооны малтай байх, энэ нь эргээд байгалийн хүчин зүйлээс хамаарч малын тоо цөөрөх, малгүй болох зэрэг эрсдэлээс өөрсдийг нь сэргийлэх ач холбогдолтойг таниулах нь зүйтэй байна. Түүнчлэн доктор А. Бакей “Монголын мал аж ахуйн тогтвортой хөгжлийн стратеги”-ийн судалгаанд 151-190 мал ногдож байвал баталгаажих дундаж түвшинг, 291-470 мал ногдож байвал хэвийн амьдралын түвшинг, түүнээс дээш толгой малтай бол өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийн түвшинг хангах боломжтой” гэсэн үзэл санааг анх дэвшүүлсэн¹⁰. Энэ санаанаас үзвэл малчин өрх 291 ба түүнээс дээш толгой малтай бол амьжиргааны баталгаажих түвшнээс дээгүүр түвшинд амьдрах ажээ.

10 Монголын таван хошуу малын бүтцийг толгойн тоогоор тогтоох нь төрийн бодлогын үндэс мөн. 2021.07.01 <https://khsukhbaatar.blogspot.com/2007/>

ШИГТГЭЭ 4.3

Малчдад сар болгон орлого гэж байхгүй, хавартаа л жоохон орлоготой, зундаа нэг орлоготой. Зундаа бол хонио хяргана, хавартаа ноолуураа аваад л байна...

Өмнөговь аймаг, гэрлэсэн эрэгтэй, 28 настай.

Зуны цагт цагаан идээ боловсруулдаг. Худалдан арилжих бололцоо тэр болгон гараад байдаггүй. Манай нутаг чинь хотоос алслагдмал хол байдаг болохоор тэр болгон өөрсдөө яваад байж чадахгүй. Улаанбаатар руу хааяа илгээнэ...

Увс аймаг, гэрлэсэн эрэгтэй, 32 настай .

Мал маллах нарийн ухаан, мэдлэг бага байна. Малаа бэлчээрт гаргах, услах, сааль бэлтгэх гээд ойр зуурын мэдлэгтэй байгаа. Сум орон нутгаас мал маллах, бэлчээр сонгох, орлого нэмэгдүүлэх чиглэлээр огт ажил зохион байгуулдаггүй...

Увс аймаг, гэрлэсэн эмэгтэй, 31 настай.

Залуу малчдын хувьд давхар ажил эрхлэлт 17.4 хувь буюу дийлэнх нь зөвхөн мал аж ахуй эрхэлж буйг өмнө авч үзсэн. Энэ дагуу мал аж ахуйн бүтээгдэхүүнээс олж буй орлогын хэмжээг авч үзэхэд ноолуур, мал, мах зарах зэргээс олж буй орлого орлогын бүтцэд томоохон байр суурь эзэлж байсан. Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс үзвэл цагаан идээг боловсруулах, зарж борлуулах, түгээх, бүтээгдэхүүнийг боловсруулах шинэ технологийн талаар сургалтад хамруулахад орон нутгийн удирдагууд дэмжлэг үзүүлэх шаардлагатай гэжээ.

Хүснэгт 4. 3. Мал аж ахуйн бус орлогын дундаж хэмжээ, (мянган төгрөг).

	Нийт		Залуу эрэгтэй малчин		Залуу эмэгтэй малчин	
	Сараар	Жилээр	Сараар	Жилээр	Сараар	Жилээр
Тэтгэвэр	139,896	1,628,125	186,134	2,186,441	65,541	737,838
Нийгмийн халамжийн тэтгэмж, шилжүүлэг	60,247	744,346	56,604	716,290	64,022	773,826
Хүүхдийн мөнгө	236,128	2,786,022	222,420	2,651,122	253,866	2,962,166
Цалин хөлс	393,564	4,180,748	464,378	4,772,302	279,706	3,267,573
Туслах аж ахуй, жижиг бизнесийн орлого	41,788	639,735	69,302	1,062,791	5385	80,000
Мал аж ахуйн бус орлогын нийт дүн	429,037	4,888,730	459,144	5,218,804	386,505	4,424,373


Судалгаанд хамрагдсан залуу малчин өрхүүд жилд дунджаар 6,410,388 төгрөгийг мал аж ахуйн бүтээгдэхүүнээс олж байсан бол мал аж ахуйн бус үйл ажиллагаанаас сард дунджаар 429.037 төгрөг, жилд дунджаар 4,888,730 төгрөг олж байна. Энэ дүнг нэгтгээд үзвэл залуу малчин өрх жилд дунджаар 11,299,118 төгрөгийн орлого олдог байна.

Хүснэгт 4.4. Залуу малчин өрхийн 1 хүнд ногдох орлогын хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинтэй харьцуулсан байдал, 2020 он, судлаачийн тооцооллоор.

Аймаг	1 хүнд ногдох МАА-н үйлдвэрлэлийн сарын дундаж орлого	1 хүнд ногдох МАА-н бус үйл ажиллагааны сарын дундаж орлого	Залуу малчин өрхийн 1 хүнд ногдох сарын дундаж орлого	Хүн амын амьжиргааны доод түвшин	Зөрүү
Дорнод	116788	88298	205086	201700	3386
Өвөрхангай	87727	70668	158395	198300	-39905
Өмнөговь	245527	135272	380799	206000	174799
Сэлэнгэ	108496	85668	194164	206000	-11836
Ховд	92584	96115	188699	203400	-14701
Увс	96577	90840	187417	203400	-15983
Нийт	124232	94743	218975	203133	-15841
Өрх толгойлсон эмэгтэй залуу малчид	93232	80781	174013	203133	-29120

Хүснэгт 4.4 -ийг харвал Үндэсний статистикийн хорооноос 2020 онд бүсээр гаргасан Хүн амын амьжиргааны доод түвшинг аймаг тус бүрээр авч үзэхэд судалгаанд хамрагдсан залуу малчин өрхүүдийн 1 хүнд ногдох МАА-н үйлдвэрлэлийн сарын дундаж орлого нь Өмнөговь аймгаас бусад аймагт хүн амын амьжиргааны доод түвшинд хүрэхгүй буюу 84912-110816 хүртэл төгрөгөөр доогуур байна¹¹. Энэ нь залуу малчдын МАА-н үйлдвэрлэлийн орлого хангалтгүй буюу өрхийн 1 хүнд ногдох мөнгөн орлого нь тухайн бүст тогтоосон хүн амын амьжиргааны доод түвшинд хүрдэггүй болохыг харуулж байна. Мөн МАА-н үйлдвэрлэлээс бусад орлого буюу цалин, хүүхдийн мөнгө, тэтгэвэр тэтгэмжийг оруулан тооцоход мөн ялгаагүй Өмнөговь аймгаас гадна Дорнод аймгийн залуу малчдын өрхийн 1 хүнд ногдох мөнгөн орлого нь хүн амын амьжиргааны доод түвшинг давж байна. Мөн өрх толгойлсон эмэгтэй залуу малчдын МАА-н үйлдвэрлэлийн орлого болон МАА-н бус орлого хоорондоо ойролцоо буюу 12,450 төгрөгийн зөрүүтэй байна. Мөн өрх толгойлсон эмэгтэй залуу малчдын 1 хүнд ногдох сарын дундаж орлого нь 174013 төгрөг байгаа нь хүн амын амьжиргааны доод түвшнээс бүсээс хамаарч 24287-55987 төгрөгөөр доогуур байна.

Зураг 4.10 Судалгаанд хамрагдсан сумдын амьжиргааны баталгаажих түвшнээс дээш орлоготой өрх, хувиар




Судалгаанд хамрагдсан залуу малчин өрхийн 64 хувь нь 2020 онд Үндэсний статистикийн хорооноос тогтоосон хүн амын амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой байна. Мөн судалгаанд хамрагдсан Өмнөговь аймгийн залуу малчдын 70.7 хувь нь

11 www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976. YCX, 2020

амьжиргааны баталгаажих түвшнээс дээгүүр орлоготой байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бол Өвөрхангай аймгийн залуу малчдын хувьд энэ үзүүлэлт 50 хувиар бага буюу 20.7 хувь нь амьжиргааны баталгаажих түвшнээс дээгүүр орлоготой байна.

Зураг 4.11 Судалгаанд хамрагдсан сумдын залуу малчдын мөнгөн орлого, төгрөгөөр.



Судалгаанд хамрагдсан залуу малчин өрхийн 1 хүнд ногдох сарын дундаж мөнгөн орлого дунджаар 218975 мянган төгрөг байна. Ховд аймгийн залуу малчдын МАА-н бус үйл ажиллагааны орлого нь МАА-н үйлдвэрлэлийн орлогоос өндөр байгаа бол бусад аймагт эсрэг дүр зураг буюу МАА-н үйлдвэрлэлийн орлого гол эх үүсвэр болж байна. Өрх толгойлсон эмэгтэй залуу малчдын өрхийн 1 хүнд ногдох сарын дундаж мөнгөн орлого нь 174013 төгрөг байгаа бөгөөд мөн хүн амын амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой байна.


Судалгаанд хамрагдсан нийт залуу малчин өрхийн МАА-н үйлдвэрлэлийн орлого болон МАА-н бус орлогын нийлбэр болох 11,299,118 төгрөгийг өрхийн ам бүлийн дундаж тоонд хуваахад 1 хүнд 2,627,702 төгрөгийн орлого жилд ногдож байна. Энэ нь сард 218,975 төгрөг болох бөгөөд 2020 онд бүс, аймгуудад тогтоосон хүн амын амьжиргааны баталгаажих түвшнээс 12,975 төгрөгөөр дээгүүр үзүүлэлт юм. 2020 онд хүн амын амьжиргааны баталгаажих түвшинг бүсүүдэд 198300-206000¹² төгрөгийн хооронд тогтоосон ба залуу малчдын хувьд МАА-н үйлдвэрлэлийн орлого дангаараа хүн амын амьжиргааны доод түвшинд хүрдэггүй тул МАА-н үйлдвэрлэлийн орлогыг нэмэгдүүлэх, мөн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж давхар цалин хөлстэй ажил эрхлэлтийг дэмжих шаардлагатай байна.

Судалгаанд хамрагдсан залуу малчдын мал аж ахуйн бус орлогын дундаж хэмжээг хүйсээр авч үзэхэд эрэгтэй залуу малчид эмэгтэйчүүдтэй харьцуулахад сард 72,639 төгрөгөөр, жилд 794,431 төгрөгөөр илүү орлого олдог байна. Мөн эрэгтэй залуу малчдын хувьд тэтгэврээс олох орлого эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр бөгөөд энэ нь өөрийн өрхийн буюу аав, ээжийнхээ тэтгэврийг мал аж ахуйн бус орлогод оруулан

12 www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1900_002V2, YCX, 2021

тооцсонтой холбоотой гэж үзэж байна. Судалгаанд хамрагдсан эмэгтэй залуу малчдын хувьд нийгмийн халамжийн тэтгэмж, шилжүүлэг, хүүхдийн мөнгөнөөс олох орлого эрэгтэйчүүдтэй харьцуулахад бага зэрэг илүү боловч тухайн жилд олж буй нийт мал аж ахуйн бус орлогын хэмжээгээр бага байна. Энэ нь мал аж ахуйгаас гадна давхар ажил эрхлэх байдал эрэгтэй залуу малчдын дунд өндөр, мөн цалин хөлстэй ажил эрхэлж буйтай холбоотой байж болох юм. Харин эмэгтэй залуу малчдын хувьд орон нутгийн байршлаас хамааран Сэлэнгийн эмэгтэй залуу малчид өрхийн аж ахуй эрхлэн хүнсний ногоо тарих зэргээр орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлж буй боловч хангалтгүй байна.

Зураг 4.12 Өрхийн орлогыг бүрдүүлэхэд гэр бүлийн гишүүдийн оролцоо, хүйсээр.



Судалгаанд хамрагдсан залуу малчдын хариултаас үзвэл өрхийн орлогыг бүрдүүлэхэд гэр бүлийн гишүүдийн оролцоо өндөр гэж 35.3 хувь нь үзжээ. Энэ нь мал аж ахуйн онцлог буюу эхнэр, нөхөр аль аль нь ижил тэгш хөдөлмөрлөж буйтай холбоотой байж болох юм. Харин нөхөр өндөр оролцоотой гэж судалгаанд хамрагдсан залуу малчдын 44.2 хувь нь үзжээ. Мөн эмэгтэй малчдын хувьд нөхөр илүү оролцоотой гэж хариулсан байдал эрэгтэйчүүдтэй харьцуулахад 1.1 хувиар өндөр байна. Харин эрэгтэй малчдын эхнэр илүү оролцоотой гэж хариулсан байдал эмэгтэйчүүдтэй харьцуулахад 7.6 хувиар бага байна. Мөн гэр бүлийн бусад гишүүд буюу аав, ээж хоёрын аав, хүү охин хоёрын хүү өрхийн орлогын бүрдүүлэхэд илүү оролцоотой гэж үзсэн байна. Энэ нь давхар ажил эрхэлж буй эрэгтэй залуу малчид эмэгтэйгээсээ 3.6 хувиар илүү байгаа зэрэг шалтгаанаар өрхийн орлогыг бүрдүүлэхэд нөхөр, аав, хүү нь эхнэр, ээж, охиноос өндөр оролцоотой байж болох юм.

ШИГТГЭЭ 4.4


Нэг өвөлжөөндөө хоёр айл өвөлжиж байна. Бэлчээрийн хомсдол үүсээд хүмүүс бие биенээсээ газар нутаг, ус ундаагаа харамлана. Мянгат малчид нь ойр хавийнхаа өвөлжөө, бууцыг худалдаад авчихдаг тэгэхээр газар олдох нь хэцүү л байлаа. Ойр хавийнхаа газрыг янз бүрийн үнээр худалдаж авч байна. Байрлал сайтай эсэхээс хамаараад 3,4 саяаас эхлээд 10 сая хүртэл байна. Ямаа ихтэй газар тийм ч учраас ямааны ноолуур үнэтэй болохоор ямаагаа голчлон өсгөнө. Эргээд бэлчээрийн даац хэтрээд асуудал гарч байна. Сүү цагаан идээний хувьд манай Богдын бор ааруул бол брэнд шүү дээ. Сүү цагаан идээгээр энэ жил цагаан идээ муу гараад ааруул 8000, 9000 байдаг байсан чинь энэ жил бүр 30000-д хүрсэн...

Өвөрхангай аймаг, гэрлэсэн эрэгтэй, 35 настай.

Цас, зудтай үед хэцүү. Энэ жил өвөл их чанга, өвс муутай, цас ихтэй байлаа. Энэ жил бас тэжээл их авлаа. Малынхаа боловсруулсан түүхий эдийг буцаагаад малдаа зарцуулж тэжээл, хүнсийг нь авлаа. Тэгэхээр ер нь амьдралын хувьд боломж муутай болж л байна. Сааль сүүгээ зундаа борлуулна. Намар голдуу айраг, сааль сүүгээ хураадаг. Тэгээд хонь ямаа, үхрээрээ саагаад ааруул, эзэгий хийгээд ерөнхийдөө аарцыг нь аваад л зарна даа. Аарцаа хурааж байгаад намартаа зараад л тэгээд өөрсдийнхөө хэрэгцээнд ааруулаа авдаг. Айраг бол зун, намартаа борлуулдаг, манайх зам дагуу байдаг болохоор зугаалгаар яваа хүмүүс айраг их авдаг...

Өвөрхангай аймаг, гэрлэсэн эмэгтэй, 31 настай.

Зураг 4.13 Сүүлийн 2 жилд МАА-н болон МАА-н бус орлогод гарсан өөрчлөлт, хүйсээр.



Дээрх зургаас үзвэл мал аж ахуйн бус орлогод сүүлийн 2 жилийн хугацаанд хамгийн бага өөрчлөлт орсон буюу хэвэндээ гэж 68.1 хувь нь хариулсан бол өссөн гэж 14.9 хувь, буурсан гэж 14.5 хувь нь үзсэн нь ойролцоо үзүүлэлт байна. Харин мал аж ахуйн орлогод өөрчлөлт ороогүй буюу хэвэндээ гэж 45.2 хувь нь хариулсан бөгөөд бага зэрэг буурсан гэж 32.7 нь, нь эрс унаж, үнэгүйдсэн гэж 7.4 хувь үзэж байна.

ШИГТГЭЭ 4.5

Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ тааруу байгаа...

Дорнод аймаг, гэрлэсэн эмэгтэй, 23 настай.

Зээлтэй. Малчны зээл авсан. Өвс тэжээлдээ зориулаад л зээл авсан...

Өмнөговь аймаг, гэрлэсэн эмэгтэй, 28 настай.

Зээл авахад хүндрэл нь гайгүй. Малын тоо цөөн бол зээл авахад хүндрэлтэй...

Малчны Төрийн Банкны зээлийн хүү өндөр, зээлээ зургаан сар тутамд нэг удаа төлдөг.


Өвөрхангай аймаг, гэрлэсэн эмэгтэй, 31 настай.

Банканд хадгаламжгүй, хадгалах ч мөнгө тэр болгон гардаггүй. Мал аж ахуйгаас олсон мөнгөө өдөр тутмын амьдралдаа зарцуулаад л дуусдаг...

Дорнод аймаг, гэрлэсэн эрэгтэй, 33 настай.

Ярилцлагад хамрагдсан залуу малчдын хувьд мөн л мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэ буурч байгаа нь эдийн засгийн хувьд малчдыг хүнд байдалд оруулж буй талаар онцолжээ. ҮСХ-ны эх сурвалжаас харахад 2017 оны байдлаар нийт малчдын 55.8 хувь нь зээлтэй байна¹³. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн дотроос ноолуур хамгийн өндөр орлогыг малчдад өгч буй боловч тухайн орлогоороо намар малын тэжээл авах зэргээр өвлийн бэлтгэлд зарцуулж дуусдаг байна. Энэ нь эргээд малчдыг банкнаас зээл авах, малаа, малын махаа хямдаар борлуулахад нөлөөлдөг байна. Мөн сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах сүлжээ байхгүй зэргээс шалтгаалж энэ төрлийн бүтээгдэхүүнээс орлого бүрдүүлэх явдал хангалтгүй байна.


Зураг 4.14 Айлын мал малладаг эсэх, хүйсээр.



Судалгаанд хамрагдсан залуу малчдын 13.8 хувь нь айлын мал малладаг ба МАА-с гадна давхар ажил эрхлэлтэд энэ нь багтаагүй юм. Мөн эрэгтэй залуу малчид айлын малыг маллах байдал эмэгтэйчүүдтэй харьцуулахад 0.7 хувиар илүү байна. Энэ нь эрэгтэйчүүдийн мал аж ахуйн болон мал аж ахуйн бус орлогын хэмжээ эмэгтэйчүүдээс өндөр байхад нөлөөлж буй хүчин зүйл байж болох юм. Түүнчлэн айлын малыг гэр бүлийн эхнэр, нөхөр хамтран малладаг тул хүйсээр харьцуулахад төдийлөн ялгаа ажиглагдсангүй.


13 ХНХЯ, ХНХСИ, 2018. Малчдын аж байдлын судалгаа. Улаанбаатар

Зураг4.15 Айлын мал малласны хариуд авч буй дэмжлэг, хүйсээр.



Судалгаанд хамрагдсан залуу малчдын 13.8 хувь нь айлын мал маллаж буйг өмнө дурдсан билээ. Тэднээс мал малласны хариуд ямар дэмжлэг авч буйг тодруулахад 32 хувь нь хөлсөөр ажилладаг, 28.2 хувь нь сүү, цагаан идээ авахыг зөвшөөрдөг, нүүж суухад тусалдаг, 27.2 хувь нь хоол хүнс, идэш уушаар хангадаг, 22.3 хувь нь өвс тэжээлээр хангадаг, 11.7 хувь нь мал, төлөөсөө өгдөг гэжээ. Эндээс үзвэл айлын мал маллах нь залуу малчин өрхийн хувьд цалин хөлснөөс гадна бусад дэмжлэгийг авчирдаг байна. Айлын мал малласны хариуд авч буй дэмжлэгийг хүйсээр авч үзэхэд эрэгтэй малчдын хувьд хоол хүнс, идэш уушаар хангадаг, мал, төлөө өгдөг, ноолуур, арьс, ширийг нь өгдөг гэсэн хариултууд эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр хувьтай байна. Харин эмэгтэй залуу малчдын хувьд нүүж суухад тусалдаг, өвс тэжээлээр хангадаг, хүүхдийг минь байлгаж, асардаг гэсэн хариултууд илүү өндөр хувьтай байна. Эндээс үзвэл эрэгтэй залуу малчдын хувьд айлын малыг малласны хариуд мал аж ахуйн бүтээгдэхүүн дундаас ашиг өндөртэй буюу ноолуур, мал төл авч байгаа бол эмэгтэй малчдын хувьд нүүж суухад тусалдаг, хүүхэд харж, асардаг зэрэг хариултыг сонгосон байна.

Зураг 4.16 Сүүлийн 2 жилийн байдлаар хамгийн их өсөж буй зардлууд, хүйсээр.



Судалгаанд хамрагдсан залуу малчдын сүүлийн 2 жилийн байдлаар хамгийн их өсөж буй зардалд МАА-н үйл ажиллагааны зардал буюу өвс, тэжээл, бордоо, малын эм тариа, отор нүүдэл хийх, өвөлжөө хаваржаагаа засах зардлууд багтаж байна. Мөн хоол хүнс, ахуйн хэрэглээ, хувцас хунар, түлээ түлш зэрэг зардлууд өсч буйг онцолж байна. Орчин үед техник, технологи хөгжихийн хэрээр малчид автомашин, мотоциклоор малаа хариулах болж шатахуун, түлшинд тодорхой зардлыг гаргах болжээ. Судалгаанд залуу малчид хамрагдсан нь тэдний хүүхдүүд их, дээд сургуульд хараахан элсэх болоогүй тул боловсрол, сургалтын төлбөрийн зардал өсч байна гэж харьцангуй бага хувь нь үзжээ. Хөдөлмөрийн судалгааны хүрээлэнгээс 2018 онд хийсэн Малчдын аж байдлын судалгаанд малчин өрхийн сарын дундаж зарлагын бүтцийг гаргасан ба нийт зардлын 14.8 хувийг хүнсэнд, 13.1 хувийг гэр ахуйн бараа, хувцас хэрэглэл худалдаж авахад, 4.3 хувийг сургалтын төлбөрт, 18.2 хувийг малын тэжээлд, 1.7 хувийг шатахуунд, 11.0 хувийг түлээ, түлшинд, 3.4 хувийг харилцаа холбоонд, 6.1 хувийг боловсролд, 5.7 хувийг эрүүл мэндийн үйлчилгээнд, 17.4 хувийг зээлийн төлбөрт, 2.2 хувийг туслах ажилтны цалинд, 1.0 хувийг цахилгаан, ус дулааны төлбөрт, үлдсэн 1.1 хувийг бусад зүйлд зарцуулсан байна. Мөн тус судалгаанд дурдсанаар малчин өрх сард дунджаар 1 227.0 мянган төгрөг зарцуулдаг гэжээ. Энэ нь жилд 13.320.0 мянган төгрөг болох бөгөөд судалгааны өмнөх хэсэгт дурдсанчлан залуу малчдын жилийн орлого болох 11.299.1 мянган төгрөгөөс давсан зарлагын дүн юм.

Үндэсний статистикийн хорооны өрхийн сарын дундаж орлогын тоон мэдээг үзвэл 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар хөдөөгийн өрхийн МАА-н үйлдвэрлэлийн орлого нь сард дунджаар 454.191 төгрөг, нийт мөнгөн орлого нь сард дунджаар 994,949 төгрөг байв¹⁴. Харин нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагыг авч үзвэл 2020 оны байдлаар хөдөөгийн өрх 1,127,793 төгрөгийн зардал гаргаж буй нь мөнгөн орлогоосоо 135,000 төгрөгөөр давж буй юм. Хөдөөгийн малчин өрхийн хувьд мал аж ахуйн бүтээгдэхүүнийг худалдан авах шаардлагагүй тул хүнсний зүйлийн зардал мөнгөн зарлагын бүтцэд 14.3 хувийг эзэлж байна. Хэдий тийм боловч өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн хөдөөгийн өрхийн нийт зарлагын бүтцийн 12.5 хувь байна. Түүнчлэн зарлагын бүтцэд хадгаламж 0 хувийг эзэлж байгаа бөгөөд малчин өрхүүдэд хадгаламжтай болох, өрхийн орлого, зарлагын харьцааг тэнцвэржүүлж орлогоос давсан хэрэглээг бууруулах зэрэг санхүүгийн мэдлэг шаардлагатай байна. Ялангуяа нүүдлийн мал аж ахуй эрхлэх нь цаг уурын эрс тэс байдлаас шалтгаалж цөөрөх, улмаар малгүй болох зэрэг эрсдэл өндөртэй тул цөөн, чанартай малтай байх, малын тэжээлийг хангалттай нөөцлөх зэргээр малчид өөрсдийн эрсдэлийг бууруулах, хуваарилах шаардлагатай.

ДҮГНЭЛТ

- Судалгаанд хамрагдсан залуу малчдын дийлэнх олонх хэсэг зөвхөн мал аж ахуйгаас орлого олж, амьдардаг бол цөөн хэсэг нь давхар ажил эрхэлж байна. Төрийн алба, улирлын чанартай ажил, ачаа тээврийн жолооч, хувийн хэвшил, үйлчилгээний бизнес зэрэг давхар ажлыг эрхэлж байна. Мөн мал аж ахуйгаас гадна давхар ажил эрхлэх байдал эрэгтэй залуу малчдын хувьд эмэгтэйчүүдтэй харьцуулахад 3.6 хувиар илүү байна.

14 <https://www.1212.mn/tables.aspx>? YCX, 2021

- Судалгаанд хамрагдсан залуу малчид дунджаар 2 эх үүсвэрээс орлого олж байгаа бөгөөд орлогын эх үүсвэрт мал аж ахуй (98.7), хүүхдийн мөнгө (76.5), нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмж, шилжүүлэг, цалингийн орлого (16.5) гол хэсгийг бүрдүүлж байна. Өрхийн орлогын эх үүсвэрийг хүйсээр авч үзэхэд эрэгтэй малчдын хувьд цалингийн орлого олж буй байдал эмэгтэй малчидтай харьцуулахад 7.3 хувиар, өндөр насны тэтгэврээс олж буй орлого 4.1 хувиар, айлын мал маллаж олж буй орлого 1.3 хувиар тус тус илүү байна. Харин эмэгтэй малчдын хувьд хүүхдийн мөнгөнөөс орлого олж буй байдал 18.9 хувиар, нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмжээс орлого олж буй байдал 10.1 хувиар, газар тариалан, хүнсний ногоо, жимсгэнэ зэрэг өрхийн аж ахуйн орлого олж буй байдал 2.3 хувиар эрэгтэй малчидтай харьцуулахад өндөр байна.
- Залуу малчдын МАА-н бүтээгдэхүүнээс олж буй орлогын дийлэнх хувийг ноолуур эзэлж байна. Энэ утгаараа маллаж буй малын 47 хувь нь ямаа байгаа бөгөөд үр шим их өгдөг гэж үзэн ямаа маллах явдал ихэсчээ. Судалгаанд хамрагдсан залуу малчин өрхүүд мал аж ахуйн бүтээгдэхүүнээс жилд дунджаар 6,410,388 төгрөгийг олж байсан бол мал аж ахуйн бус үйл ажиллагаанаас сард дунджаар 429.037 төгрөг, жилд дунджаар 4,888,730 төгрөг олж байна. Энэ дүнг нэгтгэхэд залуу малчин өрх жилд дунджаар 11,299,118 төгрөгийн орлого олж байна.
- Судалгаанд хамрагдсан залуу малчдын хариултаас үзвэл өрхийн орлогыг бүрдүүлэхэд гэр бүлийн гишүүдээс бүгдийн оролцоо өндөр гэж 35.3 хувь нь үзжээ. Энэ нь мал аж ахуй эрхлэхийн онцлог буюу эхнэр, нөхөр төдийгүй гэр бүлийн гишүүн бүр ижил тэгш хөдөлмөрлөж буйтай холбоотой. Мөн нөгөө талаас залуу эмэгтэй малчдын хувьд нөхөр өрхийн эдийн засагт илүү оролцоотой гэж хариулсан байдал эрэгтэйчүүдтэй харьцуулахад ялимгүй өндөр байна. Харин эрэгтэй малчдын эхнэр илүү оролцоотой гэж хариулсан байдал эмэгтэйчүүдтэй харьцуулахад бага байна.
- Судалгаанд хамрагдсан залуу малчдын цөөн хэсэг айлын мал малладаг бөгөөд эрэгтэй малчид айлын малыг маллах байдал эмэгтэйчүүдтэй харьцуулахад ялимгүй илүү байна. Айлын мал маллахдаа 32 хувь нь хөлсөөр ажиллаж, бусад нь сүү, цагаан идээ авах, нүүхэд туслах, хоол хүнс, идэш, өвс тэжээлээр хангах, мал, төлөөсөө өгөх зэргээр дэмжлэг үзүүлдэг байна.

ЗӨВЛӨМЖ


1. МАА-н гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг бэлтгэх, үйлдвэрлэх, борлуулах сүлжээг бий болгон хөгжүүлэхэд салбар, орон нутгийн байгууллага, удирдлагууд дэмжлэг үзүүлэх,
2. Малын тэжээл, малын эм тариаг хөнгөлөлттэй үнээр худалдан авах гэрээ хэлцлийг орон нутгийн засаг захиргаанаас тухайн чиглэлийн ААНБ-тай байгуулах
3. Залуу малчдын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах замаар тэднийг хуримтлалтай болгох, МАА-н үйлдвэрлэлийн орлого, зарлагыг бүртгэх дадал хэвшүүлэх

Бүлэг 5.


НӨӨЦИЙН ӨМЧЛӨЛ, АШИГЛАЛТ

Жендэрийн дүн шинжилгээг хийхдээ хэн нөөцийг өмчилж, захиран зарцуулж буй эрх мэдэл, байр суурийн ялгааг тодруулахад анхаарав. Асуулгын дүнгээр, 15-34 насны залуу малчдын 56.6 хувь нь малаа өмчлөгч, 40.4 хувь нь хамтран өмчлөгч байсан ба хүйс болон судлагдсан аймгуудаар харьцуулан шинжилж Зураг 5.1, 5.2-т үзүүлэв. Зураг 4.1-т харуулснаар эмэгтэй малчдын 24.5 хувь, эрэгтэйчүүдийн 75.5 хувь би малаа өмчилдөг гэсэн хариултыг өгчээ. Нутагшилтын ялгаатайгаар авч үзэхэд хамтран өмчлөгчийг сонгосон хувь Өмнөговь, Увс, Сэлэнгэ аймагт 44.9-57.1 хувийн хооронд хэлбэлзэж байгаа бол Өмнөговь аймгийн хувьд хоёр малчин тутмын нэг нь малаа хамтран өмчилдөг аж.

Зураг 5.1 5-34 насны залуу малчдын мал хөрөнгийн өмчлөлийн байдал, хүйсээр болон хувиар



Зураг 5.2 15-34 насны залуу малчдын мал хөрөнгийн өмчлөлийн байдал, байршлаар болон хувиар (n=816)



Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Гурвантэс, Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Зүүнхангай сумдын хувьд малаа хамтран өмчилдөг байдал өндөр хувьтай (буюу 68,6-72.2) үзүүлэлт болж байна. Хөрөнгө нөөцийн өмчлөлийг залуу малчдын боловсролын түвшинтэй харьцуулахад, дээд боловсролтой малчдын тэн хагас, бусад боловсролын түвшинд 33.3-43.8 хувь нь малаа хамтран өмчилдөг дүнтэй гарчээ. Аймаг, сумдын МАА-н мэргэжилтэн болон 15-34 насны гэрлэсэн малчин эрэгтэй, эмэгтэйчүүдтэй ярилцахад, бэлэвсэн, өрх толгойлсон эмэгтэй эсвэл нөхөр нь тухайн орон нутгийн харьяалалгүй тохиолдолд эмэгтэйн нэр дээр бусад тохиолдолд эрэгтэйчүүдийн, нөхрийн нэр дээр малыг бүртгэдэг байна.

ШИГТГЭЭ 5.1 Нөөц, эд хөрөнгийн өмчлөл

Малаа гол төлөв нөхрийн нэрээр, өвөлжөө, хаваржааны газар нөхрийн нэрэн дээр, бэлэвсэрлээ гэхэд хүүхдийнхээ нэрэн дээр бүртгүүлчихдэг.

Өвөрхангай аймаг, ХХААГ-ын мэргэжилтэн, эмэгтэй.

Баруун аймагт эрэгтэйчүүд өрхийн тэргүүн, гэрийн эзэн гэсэн ёс уламжлалаа хадгалдаг, дагадаг. МАА-д эрэгтэйчүүд давамгайлж ажилладаг, мал, хөрөнгө нөөцийн өмчлөлтэй холбоотой асуудлаа эрэгтэйчүүд шийддэг.

Увс аймаг, ХХААГ-ын мэргэжилтэн, эрэгтэй.

Малчдын хувьд өвөлжөө, хаваржаа болон хадлангийн газрын өмчлөлийн асуудал нь залуу малчдын халааг таслахгүй байх мөн эдийн засгийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудалтай холбогддог. Залуу эрэгтэй малчдын 81.2 хувь, эмэгтэй малчдын 78.9 хувь, эрэгтэй өвөлжөө хаваржааны газар авах боломж хомс байгааг харуулахүйц хариултыг өгчээ. Залуу малчдын 20 орчим хувь өвөлжөө, хаваржааны газар авах бололцоотой гэсэн нь тэдний хувьд хөрөнгө нөөц өмчлөлтэй холбоотой асуудал байгааг дахин нотолж буй үр дүн юм (Зураг 5.3).

Зураг 5.3 15-34 насны малчдын өвөлжөө, хаваржааны газар авах боломж, хүйсээр болон хувиар, (n=841).



Хүснэгт 5.1-т харуулснаар, Өвөрхангай, Сэлэнгэ аймгийн 15-34 насны залуу малчдын хувьд өвөлжөө хаваржааны газартай болох боломж бололцоо хумигдмал болсныг тоон баримт харуулж байна.

Хүснэгт 5.1 15-34 насны залуу малчдын өвөлжөө, хаваржааны газар авах боломж, байршлаар болон хувиар.

Байршил	Бүрэн боломжтой	Тааруухан	Боломжгүй	Нийт
Аймаг				
Дорнод	41.3	47.8	10.9	100
Өвөрхангай	4.3	90	5.7	100
Өмнөговь	27.9	32.1	40	100
Сэлэнгэ	6.5	68.3	25.2	100
Ховд	17.6	63.4	19	100
Увс	20.4	50	29.8	100
Сум				
Баяндун	14.3	74.3	11.4	100
Булган (Дорнод)	35.3	47.1	17.6	100
Матад	38.2	55.9	5.9	100
Цагаан-Овоо	80	11.4	8.6	100
Зүүнбүрэн	2.9	60	37.1	100
Мандал	22.9	42.9	34.3	100
Орхонтуул	0	74.3	25.7	100
Цагааннуур	0	97.1	2.9	100
Булган (Ховд)	19.4	58.3	22.2	100
Дөргөн	40	45.7	14.3	100

Мөнххайрхан	2.9	65.7	31.4	100
Зүүнхангай	2.8	75	22.2	100
Наранбулаг	13.9	58.3	27.8	100
Тариалан	60	37.1	2.9	100
Тэс	5.7	28.6	65.7	100
Бат-Өлзий	8.6	85.7	5.7	100
Богд	5.7	91.4	2.9	100
Сант	2.9	88.6	8.6	100
Уянга	0	94.3	5.7	100
Гурван тэс	11.4	40	48.6	100
Мандал-Овоо	40	31.4	28.6	100
Номгон	20	34.3	45.7	100
Хүрмэн	40	22.9	37.1	100
Нийт	19.7	58.5	21.8	100

Өвөлжөө хаваржаа, хадлангийн газрын хүртээмж, өмчлөлтэй холбоотой маргаан ихэнх сумдын залуу малчдын хувьд тулгамдсан асуудал болсныг малчид болон мэргэжилтнүүдийн өгсөн чанарын судалгааны дүн харуулах юм. Чанарын судалгааны дүнгээс ажиглахад, Өвөрхангай аймаг болон Өмнөговь аймагт айл өрхүүд өвөлжөөгөө өмчилж авсан байдаг, бэлтэй, хөрөнгөтэй, олон малтай малчид (залуу малчдын хэлснээр мянгат малчид) хавь ойрын өвөлжөө хаваржааны газрыг худалдаад авсан байдаг, байршил сайтай газар өндөр үнэтэй учраас шинэ залуу малчдад тулгамдаж байгаа томоохон асуудал болжээ. Сэлэнгэ аймаг бол газар тариалан бүс нутаг, үүнтэй холбоотойгоор тариаланч, малчдын хооронд зөрчил маргаан байнга гардаг, бэлчээрийн даац хэтэрсэн, хадлан хадах газаргүй болоод байгааг судалгаанд оролцогчид тэмдэглэсэн. Үүнтэй холбоотойгоор залуу малчдын хувьд ашиг шимтэй мал өсгөж үржүүлэх замаар ашиг орлогоо нэмэгдүүлэх, мөн бэлчээрийн даац хэтрэлтийг бууруулахад тэдний санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарахыг орон нутгийн мэргэжилтнүүд санал болгосон. Эндээс дүгнэхэд дунджаар 2 орлогын эх үүсвэртэй, 1,179,000 төгрөгийг МАА-н болон МАА-н бус бусад эх үүсвэрээс олдог залуу малчдад орлогоос тодорхой хувийг тогтмол хуримтлуулж хадгалах, энэхүү хуримтлал нь залуу эрэгтэй, эмэгтэй малчдад тулгамдаад байгаа өвөлжөө, хаваржааны газрын асуудлаа шийдэх цаашлаад өмч хөрөнгөтэй болох гарц юм гэдгийг санхүүгийн боловсролоор дамжуулж ойлгуулах шаардлагатай байна. Нөгөө талаас, гэрлээгүй залуу малчидтай харьцуулахад гэрлэсэн залуу малчид өвөлжөө хаваржааны газрын асуудал хүндрэлтэй гэсэн хариултыг өгчээ. Ганцаарчилсан ярилцлагын дүнгээр, гэрлэсэн, боловсрол бага, цөөн малтай залуу малчид өвөлжөө хаваржааны газаргүй, ноолуур, махаас орлогоо бүрдүүлдэг ч олсон орлогоо отор нүүдэл, малын өвс, тэжээл болон өдөр тутмын амьдралдаа зарцуулаад хуримтлал үүсгэх нөхцөл бүрддэггүй талаар ярилцлагын үеэр дурдсан болно.

Залуу малчид тэр дундаа бага орлоготой, цөөн малтай, амьжиргааны түвшин доогуур залуу малчдын хувьд хөрөнгө нөөцийн өмчлөл дэх зөрүүтэй байдлыг арилгах улмаар өвөлжөө хаваржаа, хадлангийн газар өмчлөх адил тэгш боломжоор хангах асуудал дэвшигдэж байгааг тоон болон чанарын судалгааны баримт харуулж байна.

ШИГТГЭЭ 5.2 Хадлангийн газар

Залуучуудад хадлангийн газар байхгүй, хөгшчүүл нь миний өвөг дээдсийнх гэж маргаан гаргадаг. Хадлангийн газар бол төрийн өмч, иргэн эзэмших эрхээр авдаг, хэрэв хадлангийн зориулалтаар ашигладаггүй бол газрыг нь хураах хүртэл арга хэмжээгээ авдаггүй.

Сэлэнгэ аймаг, МAA-н мэргэжилтэн, эрэгтэй.

Залуучуудын хувьд мал дээр гарна гэхэд өвөлжөө, бууцны асуудал их байна. Манай сумын хэмжээнд залуу малчид аав, ээжээсээ тусдаа гаръя гэхээр өвөлжөө бууц олдохгүй, хамт байгаад байдаг. Өвөлжөө бууц авья гэхээр урагшаа говийн бүс рүү орчихоор төв суурингаасаа холдох болно, дээрээс нь элсний нүүдэл болдог учраас хамаагүй өвөлжөө, бууц авдаггүй. Нэг бууцан дээр 2-3 айл байх жишээтэй.

Өмнөговь аймаг, МAA-н мэргэжилтэн, эмэгтэй.

Тариаланч, малчдын зөрчил дээр багийн засаг дарга, сумын засаг дарга үндсэн ажлаа хаяад ажилладаг. 17 сумын мал зүйчид” газар тариалангийн бүсэд МAA эрхлэх стандарт” /100 малд 15 хувь ямаа, 5 хувь адуу байхаар малаа төрөлжүүлэх, ашиг шимтэй мал маллах тохиолдолд хөнгөлөлт авах, өвөлжөө хадлан эзэмших г.м/ гаргаж, хангаж ажиллах талаар ИТХ-д асуудал тавьдаг, ойлгуулж байтал солигддог. Энэ асуудлыг аймаг дийлдэггүй. ИТХ-д малчдын төлөөлөл олонх болж асуудлыг унагадаг. Уг нь амархан шийдэх асуудал. УИХ хууль гаргах хэрэгтэй.

Сэлэнгэ аймаг, МAA-н мэргэжилтэн, эрэгтэй.

Малаа мянга хүргэж мянгат малчин болно доо гэж бодож байна. Малаа бэлчээрээр л маллаж байна. Тариалангийн талбайг бүрэн хашаажуулах хэрэгтэй байна. Зөвшөөрсөн м.кв-аараа хашаагаа барихгүй хамаг бэлчээр хаагаад том том хашаа бариад байгааг болиулах, цэгцлэх хэрэгтэй.

Ганцаарчилсан ярилцлага, Сэлэнгэ аймаг, гэрлэсэн залуу малчин, эрэгтэй.

Хадлан тэжээл бэлтгэх газар бол хамгийн гол тулгамдаж байгаа асуудал болж байна даа. Хадлан хийх газар хомс байна. Үүнээс болоод намар өвс тэжээл худалдаж авна. Мал ихэдсэн, малын бэлчээрийн газар багатай. Даац хэтэрсэн.

Сэлэнгэ аймаг, гэрлээгүй залуу малчин, эмэгтэй.

Бэлчээрийн хомсдол үүсээд хүмүүс бие биенээсээ газар нутаг, ус ундаагаа харамлаж байна. Мянгат малчид нь ойр хавийнхаа өвөлжөө, бууцыг худалдаад авчихдаг тэгэхээр газар олдох нь хэцүү л байлаа. Байрлал сайтай эсэхээс хамаараад 3,4 саяаас эхлээд 10 сая хүртэл байна.


Өвөрхангай аймаг, гэрлэсэн, малчин эрэгтэй.

ҮСХ-ны ХAA-н салбарын танилцуулга 2019-д малчин өрхийн 82.6 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 73.1 хувь нь телевизортой, 51.2 хувь нь автомашинтай, 51.7 хувь нь мотоциклтой, 3.4 хувь нь трактортой байна¹⁵. Өмнөх онтой харьцуулахад цахилгаан эх үүсгэр, телевиз, автомашин, мотоцикльтой малчдын эзлэх хувь өсчээ. Эндээс харахад, өрхөд эрэгтэйчүүдийн түлхүү эзэмшдэг, өмчилдөг эд хөрөнгийн төрөл болох мотоцикль, автомашин, трактортой өрхийн эзлэх хувь болон гэр бүлийн нийт гишүүдийн хэрэгцээний эд зүйл болох телевиз, цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо жилээс жилд өсч байна. Жендэрийн дүн шинжилгээгээр, МAA эрхэлж буй залуу малчин эрэгтэй, эмэгтэйчүүдээс өрх дэх эд хөрөнгийг хэн өмчилдөгийг хүйсээр шинжлэхэд, эрэгтэйчүүдэд хамаатуулсан хувийн жин өндөр дүнтэйгээр дүгнэгдлээ. Зураг 5.4-т харуулснаар, өвөлжөө, хаваржааны газрын эзэмшил эрэгтэйчүүдийн нэр дээр 57.2, эмэгтэйчүүдийн нэр дээр гэж 5.6 хувь

15 ҮСХ. 2019. Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга. Улаанбаатар

нь хариулжээ. Өрхөд түгээмэл байдаг 12 төрлийн эд хөрөнгийн өмчлөгчийг хүйсээр ангилан дунджлахад 21.98 хувь эрэгтэйчүүдэд, 1.76 хувь эмэгтэйчүүдэд ногдож байна.

Зураг 5.4 Өрх дэх эд хөрөнгийн өмчлөл, хүйсээр болон хувиар.



Тайлбар: Эд хөрөнгө байхгүй гэж хариулагчдын эзлэх хувийн жинг хасч тооцсон тул 100 хувь барихгүй.

Өрхийн орлого, мал хөрөнгөө хувааж хуваарилах, мал, бүтээгдэхүүн, эд зүйлээ худалдах, солилцох болон өрхийн орлогын зарцуулалтад залуу малчин эрэгтэй, эмэгтэйчүүдийн үүрэг, байр суурийг тодруулахад судлагдсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль аль нь 90 гаруй хувьтайгаар оролцдог гэж хариулсан нь нөөцийг захиран зарцуулахад адил тэгш оролцоотойг илтгэх дүн үзүүлж байна. Ялангуяа өрхийн орлогоо зарцуулахад байнга оролцож буй хувийн жин эрэгтэйчүүдээс даруй 10 орчим пунктээр илүү байгаа дүр зураг ажиглагдаж байна. Тэгэхээр гэр бүлийн гишүүдийн хоол хүнс, хувцас хунар гэх мэт өдөр тутмын өргөн хэрэгцээний бүтээгдэхүүний зарцуулалтыг дангаараа эмэгтэйчүүд барьж байна гэсэн үг.

ДҮГНЭЛТ

- 15-34 насны залуу малчдын хувьд мал хөрөнгө ихэвчлэн эрэгтэйчүүдийн нэр дээр бүртгэгдэж, өмчлөгдөж байна. Дээд боловсролтой малчин эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувьд хамтран өмчлөх хэлбэр бусад боловсролтой малчидтай харьцуулахад давуутай байна.
- Хөрөнгө нөөцийн өмчлөлтэй холбоотой залуу эрэгтэй, эмэгтэй малчдад тулгамдаж буй томоохон асуудлын нэг бол өвөлжөө хаваржаа, хадлангийн газар өмчлөх адил тэгш боломжоор хангах асуудал болж байгааг тоон болон чанарын судалгааны баримт харуулж байна.
- Гэрлэсэн бүрэн дунд болон түүнээс бага боловсролтой, цөөн малтай залуу малчид өвөлжөө хаваржааны газаргүй, малаас олсон орлогоо отор нүүдэл, малын өвс, тэжээл болон өдөр тутмын амьдралд нь зарцуулагдаж хуримтлал үүсгэх нөхцөл бүрдэхгүй байгааг чанарын судалгааны дүн харуулж байна.
- Өрхийн зориулалттай эд хөрөнгийн ихэнхийг залуу эрэгтэй малчдын хэрэгцээнд ашиглаж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Уламжилж ирсэн соёлын хандлагын нөлөөгөөр өрхийн тэргүүний нэр дээр мал, эд хөрөнгө бүртгэгдэж байгааг өөрчилж, өрхийн гишүүдийн нэр дээр бүртгэхэд шилжих шаардлагатай байна. Мал тооллогын анхан шатны бүртгэлийн маягт дахь өрхийн үндсэн мэдээлэл хэсэгт өрхийн тэргүүлэгч болон эхнэр, нөхрийн овог, нэр, регистрийн дугаарыг хамтад нь бүртгэх нь мал хөрөнгөө өмчлөх адил тэгш боломжоор хангах юм. Иймд ҮСХ-ны даргын 2019 оны А/152 тушаалаар баталсан “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого”-ын М1 маягтад дээрх өөрчлөлтийг оруулах шаардлагатай.
2. Залуу малчин өрх дунджаар 2 орлогын эх үүсвэртэй, сая гаруй төгрөгний сарын орлогыг МАА-н болон МАА-н бус эх үүсвэрээс бүрдүүлдэг нөхцөлд тодорхой хувийг тогтмол хуримтлуулж хадгалах замаар залуу эрэгтэй, эмэгтэй малчдад тулгамдаад байгаа өвөлжөө, хаваржааны газрын асуудлыг шийдэх, цаашлаад өмч хөрөнгө, хуримтлалыг бий болгох талаар санхүүгийн боловсролоор дамжуулж чадавхжуулах нь зүйтэй.


Бүлэг 6.

ӨРХИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТ

Залуу малчдын өрхийн шийдвэр гаргалтад дахь оролцооны байдлыг шинжилсэн юм. Судалгаанд оролцогчид өрхийн мал хөрөнгөө хувааж хуваарилах, мал, бүтээгдэхүүн, эд зүйлээ худалдах, солих, өрхийн орлогоо зарцуулахад 70 гаруй хувь нь байнга оролцдог, таван залуу малчны нэг нь хааяадаа оролцдог бол дөрвөн хувь нь огт оролцдоггүй гэж хариулжээ. Өрхийн орлого, мал хөрөнгөө хувааж хуваарилах (74.5 хувь) болон мал, бүтээгдэхүүн, эд зүйлээ худалдах (73.1 хувь) өрхийн шийдвэр гаргалтад эрэгтэй малчид эмэгтэйчүүдтэй харьцуулахад арай илүү оролцоотой байгаа бол өрхийн орлогыг зарцуулахад (77.7 хувь) эмэгтэйчүүд илүү оролцоотой байгааг судалгааны дүн харуулж байна (Зураг 6.1).

Үүнээс харахад залуу эрэгтэй малчид мал, малын бүтээгдэхүүнээ зарж борлуулахад түлхүү оролцоотой бол залуу эмэгтэй малчид өрхийн төсөв мөнгийг хуваарилж зарцуулахад илүү оролцоотой байна.

Зураг 6.1 Залуу малчдын өрхийн шийдвэр гаргалт дахь оролцоо, хүйсээр.



Ганцаарчилсан ярилцлагад оролцсон зарим залуу малчид өрхийн шийдвэр гаргалтад баруун аймгийн эрэгтэйчүүд голлох үүрэгтэй байдаг бол төвийн бүсийн аймгийн эрэгтэйчүүд эмэгтэйчүүд өрхийн шийдвэрийг ихэнхдээ хамтдаа гаргадаг гэж дурдсан хэдий ч судалгааны үр дүнгээр баруун аймгийн эрэгтэйчүүд өрхийн шийдвэрт давамгайлж үүрэгтэй гэдэг батлагдаагүй юм.


Залуу малчдын өрхийн шийдвэр гаргалт дахь оролцоог гэрлэлтийн байдлаар аваад үзвэл гэрлэсэн залуу малчдын 80 орчим хувь нь байнгын оролцоотой байдаг бол гэрлээгүй эцэг эхтэйгээ хамт амьдарч байгаа залуу малчдын оролцоо гэрлэсэн залуучуудтай харьцуулахад хааяадаа л оролцдог байдал давамгайлж байна.

Хүснэгт 6.1 Залуу малчдын өрхийн шийдвэр гаргалт дахь оролцоо, гэрлэлтийн байдлаар, хувиар.

	Гэрлэлтийн байдал	Байнга оролцоно	Хааяадаа оролцоно	Огт оролцдоггүй
Өрхийн мал хөрөнгөө хувааж хуваарилах	Гэрлээгүй	35.6	52	12.4
	Гэрлэсэн	79.5	18.6	1.9
Мал, бүтээгдэхүүн, эд зүйлээ худалдах, солих	Гэрлээгүй	34.5	52	12.4
	Гэрлэсэн	79	19.3	1.9
Өрхийн орлогоо зарцуулах	Гэрлээгүй	35	50.3	12.4
	Гэрлэсэн	83.5	15.6	1.9

Залуу малчидтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаар гэрлэсэн залуу малчдын хувьд гэр бүл үр хүүхэдтэй болсноор амьдрал ахуйгаа хөтлөх, мал аж ахуйгаа эрхлэх бүхий үйл ажиллагаандаа бие даан оролцож шийдвэр гаргаж байдаг бол гэрлээгүй залуу малчид аав ээж, ах дүү нартайгаа мал аж ахуйн ажил үүргээ хувааж гүйцэтгэдэг боловч өрхийн шийдвэр гаргалтад аав ээжийн оролцоо голлож байдаг тухай өгүүлж байна.

Зураг 6.2 Өрхийн мал хөрөнгөө хувааж хуваарилахад залуу малчдын оролцоо, насаар, хувиар.



Судалгаанд оролцсон 15-19 насны оролцогчдын тал нь хааяа, гуравны нэг нь өрхийн шийдвэр гаргалтад огт оролцдоггүй бол 30-34 насныхны 82.2 хувь нь өрхийн шийдвэр гаргалтад байнга оролцож байгаагаас харахад нас дээшлэх тусам өрхийн шийдвэр гаргалтад дахь оролцоо нэмэгдэж байгааг Зураг 6.2-оос харж болох юм. Мал, бүтээгдэхүүн, эд зүйлээ худалдах, солих болон өрхийн орлогоо зарцуулахад гэрлээгүй эцэг эхтэйгээ хамтарч мал аж ахуйгаа эрхэлж байгаа залуу малчдын хувьд өрхийн шийдвэр гаргалтад байнга оролцоод байдаггүй нь судалгаанаас харагдлаа. 15-19 насныхан шийдвэр гаргах түвшний ажилд харьцангуй бага оролцож, ахуйн хүрээн дэх хөдөлмөрт идэвхтэй оролцдог байна¹⁶.

ДҮГНЭЛТ

- Өрхийн орлого, мал хөрөнгөө хувааж хуваарилах (74.5 хувь) болон мал, бүтээгдэхүүн, эд зүйлээ худалдах (73.1 хувь) өрхийн шийдвэр гаргалтад эрэгтэй малчид эмэгтэйчүүдтэй харьцуулахад арай илүү оролцоотой байгаа бол харин өрхийн орлогыг зарцуулахад (77.7 хувь) эмэгтэйчүүд илүү оролцоотой байна.
- Гэрлэсэн залуу малчдын 80 орчим хувь нь өрхийн шийдвэр гаргалтад байнгын оролцоотой байдаг бол гэрлээгүй эцэг эхтэйгээ хамт амьдарч байгаа залуу малчдын оролцоо харьцангуй доогуур байна.
- Гэрлээгүй залуу малчид аав ээж, ах дүү нартайгаа мал аж ахуйн ажил үүргээ хувааж гүйцэтгэдэг боловч өрхийн шийдвэр гаргалтад эцэг эх оролцоо голлодог байна.

ЗӨВЛӨМЖ


1. Малчин өрх, гэр бүл дэх шийдвэр гаргах эрх мэдэл нөхөр, эрэгтэйчүүдэд хэт давамгайл байгаа нь эмэгтэйчүүдийг малчин болохоос татгалзахад хүргэх нэгэн хүчин зүйл болох тул гэр бүл дэх жендэрийн эрх тэгш байдлыг хангахын ач холбогдол, арга замын талаарх мэдлэг, хандлагыг малчдад хөгжүүлэх шаардлагатай байна.

Бүлэг 7.

БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ БАЙДАЛ, ДААТГАЛД ХАМРАГДАЛТ

Бид судалгаагаар залуу малчдаас ямар нэгэн зээлтэй эсэхийг тодруулсан юм. Судалгаанд оролцогчдын 70.0 хувь нь ямар нэгэн зээлтэй бөгөөд 64.1 хувь нь банкнаас, 5 хувь нь ах дүү, хамаатан саднаас, 2.6 хувь нь найз нөхдөөс, 3.6 хувь нь дэлгүүрээс, 0.2 хувь нь банк бус санхүүгийн байгууллагаас, 0.2 хувь нь хуримтлалын бүлэг, хоршооноос зээл авсан байна. Харин 30 хувь нь зээлгүй гэж хариулсан ажээ. Эмэгтэй малчид эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүүтэй зээл авсан болохыг судалгааны дүн харуулж байна. Бүх төрлийн эх сурвалжаас тодруулбал, банк, ах дүү, хамаатан садан, найз нөхөд, дэлгүүр, хуримтлалын бүлэг, банк бус санхүүгийн байгууллагаас эмэгтэйчүүд эрэгтэйчүүд илүүтэй зээл авч байна (Зураг 7.1). Бүхий л аймгийн малчид зээл түгээмэл авч байгаа бөгөөд тэр дундаа Өвөрхангай аймагт бусад аймгаас илүүтэй ажиглагдав.

Зураг 7.1 Залуу малчдын зээл авсан байдал, хувиар, хүйсээр.



Залуу малчидтай хийсэн ярилцлагын үеэр банк болон бусад сурвалжаас зээл авахад хүргэж буй дараах шалтгааныг дурджээ. Үүнд:

- Зуншлага тааруу болж, өвөлжилт хүндэрсэн орон нутгийн хувьд зээл авч өвс тэжээл авах
- Машин, мотоцикль авах
- Мал худалдан авах (үүлдэр угсаагаа сайжруулах, тоогоо нэмэх г.м)
- Баяр тэмдэглэх (цагаан сар, наадам г.м)
- Өвөлжөө, хаваржаа, бууц, хонд худалдаж авах, засах, сайжруулах
- Өвөлжөөн дээрээ байшин барих, засах зэрэг болно. Малчид гол төлөв аж ахуйдаа хөрөнгө оруулах зорилгоор төдийгүй баяр тэмдэглэх зэрэг хэрэглээний зориулалтаар зээл авч байна.

Судалгаанд нийт оролцогчдын бараг 50 хувь нь банк болон банк бус санхүүгийн байгууллагаас зээл авахад ямар нэг хүндрэл учирдаггүй гэж хариулсан байна. Харин бэрхшээлтэй гэж хариулсан оролцогчид зээлийн хүү өндөр, хүссэн хэмжээний зээлээ авч чаддаггүй, цөөн малтай малчид зээл авах боломж хомс, барьцаа хөрөнгийг багаар үнэлдэг, зээлийн хугацаа богино гэсэн хүндрэл гардаг болохоо хуваалцжээ. Эдгээр

хариултад хүйсийн ялгаа үл ялиг ажиглагдсан боловч ач холбогдлын түвшинд илэрсэнгүй (Хүснэгт 7.1). Судалгаанд оролцогчдын гуравны нэг орчим нь “зээлийн хүү өндөр” гэсэн бэрхшээлийг дурдсан байна. Хаан банкнаас “Малчныг дэмжих зээл” (3 хувийн хүүтэй) хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн саяхнаас хэрэгжүүлж эхэлсэн ч малчдын дунд мэдээлэл багатай болох нь ганцаарчилсан ярилцлагын мэдээллээс ажиглагдав. Цөөн малтай малчдын дунд санхүүгийн хүндрэлтэй нөхцөл үүсэх үед тухайлбал, өвөлжилт хүндэрсэн, ган гачиг тохиолдсоны улмаас хадлан тэжээл бэлтгээгүй нөхцөлд өвс, тэжээл худалдан авах шаардлага үүслээ гэхэд банкнаас зээл авах боломж тааруу байна. Тухайлбал, Хаан банк малчдад жилийн 3-19.2 хувийн хүүтэй 6 төрлийн зээл олгож байгаа бөгөөд хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээлийг авахад 100-аас доошгүй тооны (хоньд шилжүүлснээр) малтай байхыг шаарддаг байна.

Бусад оролцогчидтой харьцуулахад судалгаанд оролцсон бэлэвсэн, өрх толгойлсон эмэгтэйчүүд “зээлгүй” байх нь олон байна. Хэдийгээр зээл авах шаардлага байхгүй гэдгээр энэхүү баримтыг тайлбарлаж болох ч чанарын судалгааны баримтууд банкнаас зээл авах боломжоор хомс байгааг нотолж байв (Шигтгээ 7.1 харна уу).

Хүснэгт 7.1 Банк болон банк бус санхүүгийн байгууллагаас зээл авахад гардаг хүндрэл бэрхшээл, хувиар, хүйсээр.

	Бүгд	Эрэгтэйчүүдийн	Эмэгтэйчүүдийн
Хүссэн хэмжээний зээлээ авч чаддаггүй	10.4	10.0	11.0
Зээлийн хугацаа богино	6.1	6.8	5.0
Зээлийн хүү өндөр	29.1	30.3	27.4
Зээлийн барьцааг багаар үнэлдэг	6.5	6.0	7.2
Зээл төлөлт уян хатан биш	2.2	1.9	2.5
Бага орлоготой, цөөн малтай залуу малчид зээл авах боломж муу	8.8	7.7	10.4
Хөнгөлөлттэй зээлийн хүртээмж муу	3.0	2.6	3.8
Хүндрэл, асуудал байхгүй	47.4	47.8	46.9
Бусад	0.8	0.9	0.6

ШИГТГЭЭ 7.1

Банкнаас зээл авахад хүндрэл багатай болсон, гэхдээ цөөн малтай иргэдэд зээл өгдөггүй, баталгааг нь хангадаггүй гэж яригддаг. Хөнгөлөлттэй зээлийн мэдээлэл байхгүй, ямар зээлийг хаанаас авдгийг ч мэдэхгүй.

Өмнөговь аймаг, малчин эмэгтэй.

Манайх зээлгүй, гэхдээ манайх цөөн малтай тул зээл авч чаддаггүй, ах дүү, ээж аавын дэмэнд амьдардаг. Цөөн малтай малчинд банк зээл олгодоггүй.

Өвөрхангай аймаг, малчин, өрх толгойлсон эмэгтэй.


Хаан банкны малчны зээл, хөнгөлөлттэй нөхцөл бүхий малчны зээл, малчны дэмжих зээл гэх мэт төрлийн 6 төрлийн зээл олгож байна. Хөнгөлөлттэй нөхцөл бүхий малчны зээл (хүү: 16.8 хувийг авахын тулд “Хамгийн багадаа 100-с доошгүй хонин толгой малтай байх” ёстой гэсэн шаардлагыг биелүүлэх ёстой).

<https://www.khanbank.com/mn/personal/product/94>-аас 2021 оны 5 сарын 16-ны мэдээллээр.

Судалгаанд хамрагдсан залуу малчдын дунд “зээлтэй” байх нь нийтлэг илэрч байсны эсрэгээр хадгаламжтай байх нь 20 хүрэхгүй хувьд нь илэрч байна. Мөн тэдгээрийн дийлэнх олонх буюу 89 хувь нь банкны карт ашигладаг, бараг бүгдээр ямар нэг банкинд данс эзэмшиж байна. Банкны карт эзэмших тухайд хүйсийн ялгаа бараг үгүй, харин хадгаламж эзэмшиж буй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ бараг 5 хувиар илүү байна (Зураг 7.2). Судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн хувьд зээл авах нь эмэгтэйчүүдээсээ цөөн атлаа хадгаламжтай байдлаараа эмэгтэйчүүдээсээ давамгайл байгаа нь санхүүгийн боломжийн хувьд эрэгтэй залуу малчид илүү давуу боломжтой болохыг харуулах юм.

Хадгаламжтай оролцогчдын 42 хувь нь хадгаламжаа өсгөж чадсан, 39 хувь нь хэвэндээ, 19 хувь нь хадгаламж нь буурсан гэж хариулжээ. Хадгаламжтай эмэгтэй оролцогчид хадгаламжаа өсгөхөд эрэгтэйчүүдээс илүүтэй (7 хувиар илүү) анхаарч чадаж байгаа ч “хадгаламж нь буурсан” дүн эрэгтэйчүүдийнхээс 7 хувиар өндөр байлаа. Хадгаламжтай оролцогчид орлогынхоо 0-80 хувийг, дунджаар 15 хувийг хувийг хадгаламжидаа зориулж чадаж байна.


Зураг 7.2 Банканд карт, хадгаламжтай гэж хариулсан залуу малчдын эзлэх хувийн жин, хүйсээр.



Даатгалууд дотроос судалгаанд оролцсон залуу малчдын хувьд автомашины болон жолоочийн хариуцлагын даатгалд 44 хувь, малын эрсдэлийн даатгалд 22 хувь нь хамрагддаг ба 5 хүрэхгүй хувь нь эд хөрөнгийн болон гэнэтийн ослын даатгалд хамрагдаж байна. Автомашины болон жолоочийн хариуцлагын даатгалаас бусад даатгалд хүйсээр төдийлөн ялгаа ажиглагдсангүй.

Харин автомашины болон жолоочийн хариуцлагын, малын эрсдэлийн, эд хөрөнгийн, гэнэтийн ослын даатгалд малчдын малын тоо өсөх тусам өсөж байгаа бөгөөд цөөн тоотой малчдын хувьд олон талын эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжоор хомс байна.

Зураг 7.3 Даатгалд хамрагдсан байдал, хувиар.



Залуу малчдын татвар, төлбөр төлж байгаа байдлыг судлахад 11.5 хувь нь хүн амын орлогын татвар, 38.8 хувь нь хадлан, ногооны талбай зэрэг газрын төлбөрийг төлдөг байна. Татвар, төлбөрийн тухайд хүйсээр ялгаа илэрсэнгүй. Татвар, төлбөрийн ачаалал бага атлаа эрсдэлийн даатгалд хамрагдаггүй, орлогоо хуримтлуулж чадахгүй хандлага эрэгтэй, эмэгтэй залуу малчдын дунд зонхилонгүй илэрч байгаа тул санхүүгийн боловсрол олгох асуудалд анхаарах шаардлага байгаа нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

- Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүтэй зээл авдаг хандлага илэрсэн ч судалгаанд оролцсон бэлэвсэн, өрх толгойлсон залуу эмэгтэйчүүд “зээл”-ийн үйлчилгээнд бага хамрагдаж байгаа бөгөөд үүний шалтгааныг зээл авах боломжтой нь холбон нягтлах нь зүйтэй. Учир нь, цөөн малтай малчин хүн банкнаас зээл авах боломж хязгаарлагдмал байгааг анхаарууштай.
- Судалгаанд хамрагдсан залуу малчдын дунд “зээл” авсан нь нийтлэг байгаагийн эсрэгээр цөөхөн малчид хадгаламжтай байна, Судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн хувьд зээл авах нь эмэгтэйчүүдээсээ цөөн атлаа хадгаламжтай байдлаараа эмэгтэйчүүдээсээ давамгайл байгаа тул эрэгтэй залуу малчид санхүүгийн хувьд илүү давуу боломжтой байна. Гол төлөв аж ахуйдаа хөрөнгө оруулах зорилгоор зээл авч байгаа ч, хэрэглээний зориулалттай зээл басхүү нэлээд хувийг эзэлж байна. Иймд малчдын зардлаа хянах, орлогоосоо хуримтлал бий болгох санхүүгийн боловсролыг дээшлүүлэх шаардлагатай байна.
- Автомашины болон жолоочийн хариуцлагын даатгалаас бусад төрлийн даатгалд хүйсээр ялгаа төдийлөн илэрсэнгүй. Гэхдээ даатгалын үйлчилгээнд хамрагдах байдал малын тооноос хамаарч байгаа бөгөөд цөөн тоотой малчдын хувьд олон талын эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжоор хомс байна.

ЗӨВЛӨМЖ

1. Банк, даатгалын үйлчилгээ авах боломж хүйсээр ялгаа багатай ч цөөн малтай малчид, тэр дундаа өрх толгойлсон залуу эмэгтэйчүүдийг дэмжсэн үйлчилгээ үгүйлэгдэж байна.
2. Малчдын санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх тэр дундаа эмэгтэй малчдын хуримтлал бий болгох чиглэлд чадавхжуулах шаардлага байна.

Бүлэг 8.

МАЛ МАЛЛАГАА, МАЛ АЖ АХУЙН ХӨДӨЛМӨРИЙН ХУВААРИЛАЛТ

8.1 Мал маллагаа

Төрөөс мал аж ахуйн салбарт баримтлах бодлого, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрт уламжлалт мал аж ахуйн хэв шинжийг газар тариалангийн бүс, хот суурингийн орчимд эрчимжсэн МАА-тай зохистой хослон хөгжүүлэх зорилтыг дэвшүүлжээ. Асуулгын дүнгээр, 6 аймаг, 24 сумаас судлагдсан 15-34 насны залуу малчдын 79.5 хувь бэлчээрээр буюу уламжлалт нүүдлийн хэлбэрээр малаа маллаж байна. Дорнод, Сэлэнгэ аймагт хагас суурин болон суурин, Ховд аймагт хагас суурин МАА-г эрхэлж байна. Хувийн жинг дунджилсан үзүүлэлтээр, Дорнод аймгийн Баяндун, Матад, Цагаан-Овоо, Булган сумаас судлагдсан 2 малчин тутмын нэг, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Мандал, Орхонтуул, Цагааннуур сумын малчдын 31.45 хувь суурин болон хагас суурин хэлбэрээр мал аж ахуй эрхэлж байна. (Хүснэгт 8.1)

Хүснэгт 8.1 15-34 насны залуу малчдын мал аж ахуй эрхэлж буй арга ажиллагаа, байршлаар болон хувиар.

Байршил	Бэлчээрийн	Хагас суурин	Суурин (фермер)	Нийт
Аймаг				
Дорнод	48.7	42	10.1	100
Өвөрхангай	96.4	3.6	0	100
Өмнөговь	97.1	2.9	0	100
Сэлэнгэ	68.3	21.6	10.1	100
Ховд	78.2	21.1	0.7	100
Увс	88.7	9.9	1.4	100
Сум				
Баяндун	65.7	31.4	2.9	100
Булган (Дорнод)	50	32.4	2.9	100
Матад	58.8	38.2	2.9	100
Цагаан-Овоо	17.1	65.7	17.1	100
Зүүнбүрэн	51.4	40	8.6	100
Мандал	45.7	28.6	25.7	100
Орхонтуул	80	17.1	2.9	100
Цагааннуур	97.1	0	2.9	100
Булган (Ховд)	69.4	27.8	2.8	100
Дөргөн	77.1	22.9	0	100
Мөнххайрхан	91.4	8.6	0	100
Зүүнхангай	100	0	0	100
Наранбулаг	97.2	0	2.8	100
Тариалан	77.1	20	2.9	100
Тэс	80	20	0	100
Бат-Өлзий	100	0	0	100

Богд	85.7	14.3	0	100
Сант	100	0	0	100
Уянга	100	0	0	100
Гурван тэс	97.1	2.9	0	100
Мандал-Овоо	100	0	0	100
Номгон	94.3	5.7	0	100
Хүрмэн	97.1	2.9	0	100
Нийт	79.5	16.8	3.7	100

Асуулгад оролцсон 5 малчин тутмын нэг нь суурин болон хагас суурин мал аж ахуй эрхэлж байна. Мал маллагааны талаар хариулагчдын хүйсээс хамаарсан онцлох ялгаа ажиглагдаагүй болно. (Зураг 8.1)

Зураг 8.1 15-34 насны залуу малчдын мал аж ахуй эрхэлж буй арга ажиллагаа, хүйсээр болон хувиар.



“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар 2025 он хүртэл баримтлах бодлого”-д уламжлалт өв соёлыг хадгалсан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн мал аж ахуйг зонхилон эрхэлж, хүн ам олноор суурьшсан хот, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэхээр мал аж ахуйн салбарын хөгжлийн чиглэлийг тогтоосон байдаг. Орон нутгийн статистикийн мэдээлэл болон ХХААГ, МАА-н мэргэжилтэн малчдын өгүүлснээр малын тоо өсч бэлчээрийн даац дор хаяж хоёр дахин хэтэрсэн нөхцөлд уламжлалт бэлчээрийн МАА-г зонхилон эрхлэх төлөв ажиглагдсан ч хоёр залуу малчин тутмын нэг (53.2 хувь) уламжлалт бэлчээрийн МАА-г, 36.4 хувь эрчимжсэн МАА-г сонгожээ. Энэ нь одоогийн мал маллагаанд зонхилох бэлчээрийн маллагааг даруй 26.3 хувиар бууруулахаар, эрчимжихийг 16 хувиар нэмэгдүүлэхээр байна. Гэхдээ судлагдсан байршлын хувьд ялгаа ажиглагдсан нь газар тариалангийн бүс нутаг Сэлэнгэ аймгийн малчдын 57.6 хувь эрчимжсэн МАА, Өвөрхангай аймагт 80 хувьд уламжлалт нүүдлийн МАА-г эрхлэхээр сонгосон нь хамгийн өндөр хувьтай үзүүлэлт болж байна. Увс, Дорнодын залуу малчдын хувьд Өвөрхангай, Өмнөговь аймагтай харьцуулахад бэлчээрийн МАА-г сонгосон хувь бага атлаа ирээдүйд мал маллагааны аль хувилбарыг сонгох байдалд эргэлзсэн хувь өндөр дүнтэй илэрчээ. Төв, хангайн бүсийн зарим аймгийн ХХААГ, МАА-н мэргэжилтнүүд эрчимжсэн мал аж ахуй хөгжихгүй байгааг технологи, тэжээлийн үйлдвэр хөгжөөгүй, зах зээлийн хувьд Улаанбаатар болон төв суурин газраас хол, малчдын бүлэг хоршооны зохион байгуулалт сул байгаагаар тайлбарлалаа.

ШИГТГЭЭ 8.1

Малаа мянга хүргэж мянгат малчин болно доо гэж бодож байна. Малаа бэлчээрээр л маллаж байна. Цагийн аясаар эрчимжүүлсэн мал ахуйтай болох байх даа.

Сэлэнгэ аймаг, гэрлэсэн, эрэгтэй, малчин.

Аймгийн ХАА-н талаар баримтлах урт хугацааны бодлого боловсруулж байгаа. Малын тоо цөөрүүлэх, өндөр ашиг шимтэй мал өсгөхөөр тусгагдсан. Засгийн газраас эрчимжсэн МАА хөтөлбөрөөр фермерийн аж ахуй хөгжүүлэхээр тусгасан ч хөрөнгө байдаггүйгээс хэрэгжихгүй байна.

Сэлэнгэ аймаг, ХХААГ-ын мэргэжилтэн, эрэгтэй.

Малын чанар, үүлдэр угсаа муудаж, бие давжаарсан. Малчид хээлтүүлэгч малаар нас биед гүйцсэн мал сонгохгүй төл малаар тавих, эсвэл хангайн малаар эцэг малаар тавих зэрэг шинжлэх ухаан, уламжлалт мэдлэгтэй тулгуурлан сонголт хийх чадвар суларсан, тэгэхээр төл мал нь муудаж байна. Малын тоо нь өсөөд байгаа атлаа бие нь давжаарч, ашиг шим нь буурах хандлагатай.

Өвөрхангай аймаг, ХХААГ-ын мэргэжилтэн, эмэгтэй.

Дорнод аймаг болон Увс аймгийн Наранбулаг сум говь тал хээрийн бүс тул эрчимжсэн МАА боломжгүй, говь талын экосистем зонхилдог Тэс сумын тухайд үхрийн аж ахуйгаар эрчимжих боломжтой, хангайн бүсийн Тариалан сумын малчид газар тариалан эрхэлж хадлан авдаг уламжлалтай, хагас суурин үхрийн аж ахуй эрхлэх боломжтой, хангайн бүсэд багтдаг Зүүнхангай сум байгаль цаг уурын хувьд хүйтэн, цас их унадаг учраас эрчимжсэн мал аж ахуй тохиромж муутайг ХХААГ-ын мэргэжилтнүүд тэмдэглэсэн. Залуу малчид тэр дундаа эрэгтэйчүүд малаа өсгөх сонирхолтой байгаа нөхцөлд чанаргүй олон мал маллах эсвэл чанартай, төрөлжсөн мал өсгөх, бэлчээрээр эсвэл эрчимжсэн МАА эрхлэх сонголт хийхэд эдийн засгийн тооцоо судалгаа дутдаг, энэ талын чадамжийг дээшлүүлэхийг мэргэжилтнүүд санал болгож байна. Салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2018-2021 онд эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх, газар тариалангийн зохистой дадлыг эзэмшүүлэх зэрэг малчид, фермерүүдэд шинэ мэдлэг мэдээлэл, ур чадвар олгоход чиглэсэн гарын авлага, мэдээлэл сурталчилгааны жендэрийн мэдрэмжийг сайжруулах чиглэлээр сургалт хийхээр төлөвлөсөн байдаг¹⁷. Хоёрдугаар бүлэгт өгүүлснээр, мянгат малчин болох зорилгоор уламжлалт бэлчээрийн маллагаагаар малаа өсгөж буй залуу эрэгтэй малчид зонхилж буйг чанарын судалгааны дүн харуулсан. МАА-н мэргэжилтнүүд залуу малчдад ашиг шимтэй чанарлаг мал өсгөх, малаа эдийн засгийн эргэлтэд оруулах чадамжтай болгох, эрчимжсэн МАА-г хөгжүүлэхэд төсөв хөрөнгө зарцуулах, (хээлтүүлэгч, үүлдэрлэг мал, малын тэжээл бэлтгэх г.м) малын түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр хөгжүүлэх, борлуулалтын асуудлыг шийдэх явдал тулгамдсан хэвээр байгааг онцолсон. Эндээс дүгнэхэд, бэлчээрийн даац болон малын тооны зохист харьцаа алдагдсан нөхцөлд Дорнод аймаг эрчимжсэн МАА эрхэлдэг, Увс аймаг эрчимжих сонирхолтой, говийн бүс Өмнөговь аймагт өвс, тэжээлийн хүрэлцээгээс хамаарч эрчимжих боломжгүй зэрэг онцлогийг харгалзсан тооцоолол дээр тулгуурлан цогц (бэлчээрийн менежмент, хоршоо, түүхий эд боловсруулах, санхүүгийн боловсрол олгох г.м) сургалтын хөтөлбөрөөр эсвэл мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар залуу малчдын чадамжийг дээшлүүлэх нь анхаарах асуудал мөн.

17 ХХААХҮЯ. 2018. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын жендэрийн талаар баримтлах бодлого (2018-2025). Улаанбаатар

8.2 Мал аж ахуйн хөдөлмөрийн хуваарилалт

Асуулгын дүнгээр, өрхөд хөдөлмөрийн насны 989 эрэгтэй, 853 эмэгтэй бүртгэгдсэн буюу нэг өрхөд хөдөлмөрийн насны хоёр хүн ногдож байна. Өрхийн мал аж ахуйд дунджаар хоёр хүн ажиллаж байна. Нэг өрхөд хамгийн олондоо 6, хамгийн цөөндөө нэг хүн МАА-д ажиллаж, ам бүлийн тоо нэмэгдэх тусам ажиллах хүчний тоо өсч байна.

Хүснэгт 8.2 Мал аж ахуйд ажиллаж буй өрхийн гишүүдийн дундаж тоо, байршлаар.

Аймаг	МАА-д ажилладаг өрхийн гишүүдийн дундаж тоо	МАА-д ажилладаг өрхийн гишүүдийн дундаж тоо (хамгийн цөөн)	МАА-д ажилладаг өрхийн гишүүдийн дундаж тоо (хамгийн олон)
Дорнод	2.26	1	6
Өвөрхангай	2.29	1	5
Өмнөговь	2.04	1	4
Сэлэнгэ	2.02	1	4
Ховд	2.27	1	6
Увс	2.08	1	5
Нийт дундаж	2.16	1	6

Монголчууд эрс тэс, хатуу ширүүн байгаль, цаг уурын нөхцөлд жилийн 4 улирлаар нүүдэллэн МАА-гаа эрхэлдэг онцлогтой. Нүүдлийн МАА-д эмэгтэйчүүд үнээ малаа саах, эрэгтэйчүүд отор нүүдэл хийх, мал хариулах, хадлан тэжээл авах зэрэг уламжлалт хөдөлмөрийн хуваарь хадгалагдаж байгаа ч цэцэрлэг, сургуулийн хүүхдээ дагаж, залуу гэр бүл тусдаа амьдрах болсноор эмэгтэйчүүд мал аж ахуйн хөдөлмөрөөс хөндийрэх, малын ашиг шимийн ашиглалт буурах (сааль авах, цагаан идээ бэлтгэх) эрэгтэйчүүд мал ах ахуйн хөдөлмөрийн ачаалал нэмэгдэх зэрэг олон талт асуудлыг дагуулж байгааг ХХААГ, МАА-н мэргэжилтнүүд онцгойлон анхааруулсан. Хангай, төвийн бүстэй харьцуулахад баруун аймагт (Ховд, Увс) Монгол ёс уламжлалаа дагаад отор нүүдэл хийх, малаа хэрэглэх зэргээр МАА-н үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн үүрэг давамгайлдаг гэж үзэхдээ 20 километрийн алсаас эрэгтэйчүүд малаа авчирна, эрэгтэйчүүдийн оролцоотой хадлан тэжээл, хонь хяргах зэргээр эрэгтэйчүүдийн хөдөлмөр зонхилдог гэх патриархаль тайлбарыг хийсэн юм. Сэлэнгэ аймгийн жишээн дээр эмэгтэй залуу малчид төл авах, сүү цагаан идээ авах, тэжээлийн малаа маллах зэргээр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэхийн сацуу жендэрийн хөдөлмөрийн хуваарь дахь нөхөн үржихүйн хөдөлмөрийн ангилалд багтах гэрийн ажлаа хариуцдаг, эрэгтэйчүүд малчид богины оторт явах, хадлан авах, малаа хариулах зэргээр ялгаатай ажил эрхэлж байна. Сэлэнгэ аймгийн сумдын МАА-н мэргэжилтнүүдийн хэлснээр, МАА-н хөдөлмөрөөс гадна малчин эрэгтэйчүүд бичил уурхай эрхлэх, самар жимс түүх, эмэгтэйчүүд төмс хүнсний ногоо тариалах, арчлах зэргээр давхар ажил эрхэлж, Өмнөговь аймагт ямаа саах зэрэг мал аж ахуйн үйл ажиллагаа багасч, цөөн малтай залуучууд уул уурхайд хөдөлмөр эрхэлж буй ялгаатай төлөв байдал ажиглагдаж байна.

ШИГТГЭЭ 8.2

Нөхөр нь малаа хараад, малаа борлуулаад, борлуулсныг нь эхнэр, хүүхэд нь үрсэн аястай харагддаг. Сум, аймгийн төвөөс эхнэр авлаа гэхэд хүүхэд гарахаар нь хүүхдээ хараад төв дээр суучихдаг болсон. Хөдөө очихоор хэдэн залуус малаа дагасан ганцаараа амьдарч байдаг болсон.

Өвөрхангай, ХХААГ-ын мэргэжилтэн, эмэгтэй.

Хүүхдүүд нь сургууль, цэцэрлэгт ороход эхнэр нь аймагт очоод суудаг, нөхөр нь малаа хараад үлддэг асуудал сүүлийн жилүүдэд гараад байна.

Өмнөговь аймаг, МАА-н мэргэжилтэн, эрэгтэй.

Залуу малчин ээжүүд бага насны хүүхдээ харах шалтгаанаар мал аж ахуйгаасаа хөдийрэх хандлага ихсэж байгаа. Энэ нь нэгж малаас авах бүтээгдэхүүн үйлдвэрлэл төдий хэмжээгээр багасаж ирж байгаа юм.

Ховд аймаг, ХХААГ-ын мэргэжилтэн.

Залуу малчин өрхүүд бага насны хүүхэдтэй, эхнэр нь хүүхдүүдээ сургууль, цэцэрлэгт хамруулж сумын төвд амьдарч байна. Нөхрүүд нь хөдөө мал дээр малаа маллаж ихэнх малчин залуу гэр бүл тусдаа амьдарч байна.

Дорнод аймаг, Багийн засаг дарга, эрэгтэй.

Жендэрийн дүн шинжилгээгээр эрэгтэй, эмэгтэйчүүдийн гүйцэтгэж буй ажил үүрэг хүлээж буй үүргийн ялгааг судалдаг. Хүснэгт 8.3-т харуулснаар, үйлдвэрлэлийн буюу отор нүүдэл хийх, малаа хариулах, хадлан бордоо бэлтгэх, түлээ бэлтгэх, чөдөр ногт хийх зэрэг МАА-н үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрэгтэйчүүд оролцоо өндөр байгаа бол сүү сааль авах, сүүн бүтээгдэхүүн бэлтгэх мал аж ахуйн хөдөлмөрөөс гадна гэрийн ажил гэж нэрлэгддэг хүүхэд асрах, гэр цэвэрлэх, хоол хийх, угаалга, ахмад настан хийгээд гэр бүлийн гишүүдээ халамжлах, оёдол хийх зэрэг нөхөн үржихүйн хөдөлмөрт эмэгтэй малчдын оролцоо өндөр байна. Өмнө дурдсанчлан залуу малчин гэр бүл хүүхдээ сургахаар тусдаа амьдрах болсны нөлөөгөөр эмэгтэй малчдын оролцоотойгоор хийгддэг байсан зарим хөдөлмөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь буурч байна.

Хүснэгт 8.3. МАА эрхлэх, гэрийн өдөр тутмын ажлыг ихэвчлэн хийдэг гэр бүлийн гишүүд, хүйсээр болон хувиар.

Үйл ажиллагаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хамтдаа (эрэгтэй, эмэгтэй)	Гэр бүлийн бусад гишүүд	Хийдэггүй	Нийт
Бэлчээр сонгох (отор нүүдэл хийх, өвөлжөө, хаваржаа тааруулах)	44.9	2.1	32.7	17.5	2.9	100
Малын түүхий эд бэлтгэх, боловсруулах (ноос, ноолуур, мал мах, арьс шир)	27.7	14.3	44.1	10.2	3.7	100
Чөдөр ногт, хазаар зангидах	54.5	17.6	0.1	8.1	19.7	100
Сүү сааль, сүүн бүтээгдэхүүн хийх	4.2	47.7	22.2	13	13	100


Хадлан бордоо бэлтгэх, авах, хашаалах	45.1	3	26.9	5.9	19.1	100
Согоовор, малын тэжээл тарих, ногоо тарих	7.4	1.1	9.5	3.2	78.8	100
Худаг ус гаргах, булаг шанд хаших, хамгаалах	20.7	1.9	11.4	7.4	58.6	100
Гэрийн ажил хийх (хүүхэд өсгөх, хүмүүжүүлэх, юм оёх г.м)	5.8	45.3	31.3	13.4	3.2	100
Ус авах, малаа услах	49	5.2	36	8.9	0.8	100
Түлээ бэлтгэх	52.8	3.3	33.3	8.8	1.8	100
Ажил хөөцөлдөх, хүнтэй уулзах	28.5	8.8	45.4	13.1	4.2	100
Малчдын бүлэг, хоршооны гишүүнээр ажиллах, хурал, зөвлөгөөн, сургалтад оролцох	16.6	4.9	20.3	7.8	50.3	100
Малаа хариулах, хайх	54.7	2.9	33.3	7.4	1.8	100
Малаа эмчлэх, өвчнөөс сэргийлэх, угаах г.м	34.4	2.6	45.3	10.9	6.8	100
Малын хашаа, бууц, хавь орчноо цэвэрлэх	24	4.6	57	11.1	3.3	100

Маллах, төл бойжуулах, мал услах, нүүдэл хийх, оторлох ажил, ноос ноолуураа авах нь хүн хүч шаардсан, гэр бүлийн эрэгтэй, эмэгтэй малчид хоёулаа хамтарч хөдөлмөрлөдөг онцлогтой. Гэрлэсэн залуу малчдын ярилцлагаар, мал аж ахуйн хөдөлмөр бол хүнд, уртаар үргэлжилдэг. Мал аж ахуйн хөдөлмөрийн хуваарилалтад томоохон өөрчлөлт гарч байгаа нь эмэгтэйчүүд сургууль, цэцэрлэгийн хүүхдээ дагаад төв суурин газар тусдаа амьдрах болж, хөдөөд эрэгтэйчүүд малаа маллах нь судлагдсан 24 суманд нийтлэг ажиглагдлаа. Маш цөөн тохиолдолд, Увс аймгийн жишээн дээр аав ээжтэйгээ хоёр гэрээрээ амьдардаг залуучуудын гэр, сааль сүүний ажилд аав ээж нь элбэлцдэг, аав ээж нь сургуулийн насны хүүхдийг нь авч сум, аймагт амьдрах эсвэл төв сууринд амьдардаг аав ээждээ хүүхдээ суулгаж байгаа малчдын хувьд эхнэрийн хамт мал аж ахуйгаа эрхэлж байна. Судлагдсан эмэгтэйчүүдийн өгсөн мэдээллээр мал төллүүлэх, үхрээ бэлчээх, тэжээлийн мал арчлах, үхэр мал саах, малын хот хороо цэвэрлэхийн завсраар (малчин эмэгтэйчүүдийн хэлснээр) хүүхдээ асрах, гэрээ цэвэрлэх, угаалга, хоолоо хийх зэрэг “гэрийн ажил” гэж нэрлэгддэг ажлыг амжуулж байна. Сэлэнгэ аймгийн тухайд газар тариалан, бичил уурхай эрхлэх, байгалийн дагалт баялаг ашиглахтай холбоотойгоор залуу эмэгтэй малчид ногоо арчлах, зэрлэг зулгаах, эрэгтэйчүүд услах, зарж борлуулах, эрэгтэйчүүд бичил уурхай эрхлэх, эрэгтэйчүүд жимс, самар жимс түүх (2-3 сараар), борлуулах ажлыг МАА-н эрхлэхийн зэрэгцээ хийж байна.

Чанарын судалгааны дүнд тулгуурлан дүгнэхэд, байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж отор нүүдлийн давтамж нэмэгдсэн нь эрэгтэй малчдын хөдөлмөрийн ачааллыг тэр хэмжээгээр нэмэгдүүлж байна.

Хүснэгт 8.2-т малын түүхий эд авах, сүү цагаан идээ боловсруулах, хадлан тэжээл авахад зориулсан тоног төхөөрөмжтэй гэж 1.4-4.2 хувь хариулсан байхад гэрийн хөдөлмөрийг хөнгөвчлөхөд тустай угаалгын машин, хийн зуухтай гэж 33.2-42.8 хувь хариулжээ. Хоол хийх, хувцас угаах ажил эмэгтэйчүүдэд оногддог бөгөөд тэдний ажлыг хөнгөвчлөхөд тустай ахуй хэрэглээний цахилгаан бараа, техник, тоног төхөөрөмжөөр нийт малчдын 36.85 хувь (дунджаар) хангагдсан ба гэр ахуйн хөдөлмөрийг хөнгөвчилдөг эд зүйлсэд угаалгын машин, хөргөгч багтаж байна. Харин 8.92 хувь нь (дунджаар) МАА-н хөдөлмөрийг хөнгөвчлөхөд тустай тоног төхөөрөмжтэй байна.

Зураг 8.2 Малчин өрхөд дараах эд зүйлс байдаг гэж хариулагчдын эзлэх хувийн жингээр.



Мал саах, ноос ноолуур хяргах, самнах, малын гаралтай түүхий эд боловсруулах, малын өвс тэжээл бэлтгэх зэрэг эрэгтэй, эмэгтэйчүүдийн МАА-н үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, технологийн дэвшлийг нэвтрүүлэхэд анхаарах шаардлага байгааг тоон судалгааны дүн илтгэж байна. Үүнийг дараах чанарын судалгааны дүн баталгаажуулж байна.

Гэрлэсэн болон гэрлээгүй эмэгтэй, эрэгтэй залуу малчдын ярилцлагаар, өглөө 5-6 цагт босч, эмэгтэйчүүд үхэр малаа сааж, хониндоо явах, үхэр малын баас түүх, мал хотлуулах, гэрээ цэвэрлэх, оёдол үйл хийх, эрэгтэйчүүд хонинд явах, мал хариулах зэргээр оройн 19-20 цагт ажил дуусч байна. Ярилцлагад оролцсон ихэнх малчид чөлөөт цаг гардаггүй, эмэгтэй малчдын хувьд ид саалийн цагаар үхэр малаа саасаар өдөр өнгөрдөг, мал олонтой, отор нүүдэл хийдэг малчдын тухайд өглөө 4-5 цагт босч, орой 10 цагт малын аж ахуйн ажлаа дуусгаж байна. Өвс ургамлын гарц муудаж, жилээс жилд бэлчээрийн даац хэтэрсэн нь отор, нүүдлийн тоо нэмэгдэж тэр хэмжээгээр МАА-д зарцуулах цаг уртасч байгааг чанарын судалгааны дүн давхар баталгаажуулсаар байна. Гэрлэсэн залуу малчдын тэмдэглэснээр цаг агаар тогтуун сайхан үед чөлөөт цаг гардаг гэр бүл, үр хүүхэдтэйгээ тоглох, телевиз үзэхэд цагаа зарцуулдаг аж. Салбарын жендэрийн бодлогод малчин эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих бага оврын тоног төхөөрөмжийг нэвтрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгагдсан байдаг. Сэлэнгэ аймгийн мэргэжилтнүүдийн тэмдэглэснээр үхрийн фермерийн аж ахуйд эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн үйл ажиллагаа зонхилдог ч

саалтууртай болж хөдөлмөр хөнгөвчлөгдөж байгаа ахиц дэвшил гарч байгааг дурдаж, нийт малчдад түгээн дэлгэрүүлэх шаардлагатай юм. МАА-н мэргэжилтнүүдийн санал болгосноор МАА-н хөдөлмөр хөнгөвчлөхөд чиглэсэн тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх нь зөвхөн хөдөлмөр хөнгөвчлөөд зогсохгүй органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх давхар ач холбогдолтой хэмээн үзлээ.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлд мал аж ахуйн салбарт туслах малчин, хөлсний малчны хөдөлмөрийн харилцаа бий болж, улмаар туслах малчин гэсэн томъёоллыг хэрэглэх болж, 2017 оноос ҮСХ туслах малчинтай холбоотой мэдээллийг албан ёсоор гаргах болжээ¹⁸. 2017-2020 онуудад туслах малчдын тоо өсч, 2017 онтой харьцуулахад 2020 онд 27.9 хувиар өссөн дүнтэй гарчээ. 2017-2019 онуудын улсын дүнгээр, 15-34 насныхан туслах малчдын 44 хувийг (дунджаар) бүрдүүлж, тус 3 онд тооны хувьд буурч иржээ¹⁹. Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьжиргааны жендэрийн дүн шинжилгээгээр, залуу малчдын 3 хувийг туслах малчин бүрдүүлснээс 2.4 хувь нь эрэгтэй (n=12,) 3.9 хувь нь эмэгтэй (n=13) байв. Нийт туслах малчдын 76 хувь нь Дорнод аймагт ногдож байгаа юм. Хамгийн олон туслах малчинтай Дорнод аймгийн хувьд малын тоогоор ямаа, тэмээнээс бусад төрөлд тэргүүлсэн нь туслах малчдын тоо өндөр байх үндэслэл байж болзошгүй юм. ХЭҮК-ын 20 дахь илтгэлд малын тоо өсч байгаа нөхцөлд туслах малчдын хэрэгцээ дагаж өсдөг хэмээн дүгнэжээ.

Залуу малчдын 7.1 хувь (n=60) мал аж ахуйдаа туслах малчин ажиллуулж байгаагаас эрэгтэйчүүд 7.3 хувь, эмэгтэйчүүд 6.8 хувийг эзэлжээ. Судлагдсан аймгуудаар шинжлэхэд, туслах малчдын 66.7 хувь Увс, Ховд, Дорнод аймагт ногджээ. ҮСХ, ХЭҮК-ын болон жендэрийн дүн шинжилгээгээр мал аж ахуйн салбарын хөдөлмөрийн үйл ажиллагаанд туслах малчин үүрэгтэйгээр оролцож байгааг харуулах юм.

ДҮГНЭЛТ

- 6 аймгийн 24 сумын 15-34 насны залуу малчид бэлчээрийн мал аж ахуй эрхлэх нь зонхилох төлөвтэй байгааг асуулга судалгааны дүн харуулсан бол чанарын судалгааны дүнгээр залуу эрэгтэй малчид малаа өсгөх, эмэгтэй малчдын дунд ашиг шимтэй, чанартай мал маллах сонирхол бүхий байгаа нь ажиглагдаж байна. ХХААГ, МАА-н мэргэжилтнүүд малаа залуу малчдын хувьд малаа өсгөх сонголтыг хийж байгаа нь амьжиргаагаа дээшлүүлэх хүсэл эрмэлзэлтэй нь холбож, малаа өсгөх эсвэл чанартай төрөлжсөн МАА эрхлэхэд чиглэсэн бизнесийн болон санхүүгийн боловсрол дутаж байгаагаар холбон тайлбарлаж байна.
- Ирээдүйд залуу малчдын тэн хагас нь уламжлалт бэлчээрийн МАА эрхлэхээр байгаа ч үлдсэн нь эрчимжсэн МАА-г эрхлэх сонирхолтой байна.
- Бэлчээрийн даац хэтэрсэн өнөөгийн нөхцөлд Дорнод аймаг эрчимжсэн МАА эрхэлдэг, Увс аймаг эрчимжих сонирхолтой, говийн бүс Өмнөговь аймагт өвс, тэжээлийн хүрэлцээгээс хамаарч эрчимжих боломжгүй гэж үзэх ялгаа илрэв.
- Мал аж ахуйн хөдөлмөрийн хуваарилалтад томоохон өөрчлөлт гарч байгаа нь эмэгтэй малчид сургууль, цэцэрлэгийн хүүхдээ дагаад төв суурин газар тусдаа амьдрах болж, хөдөөд эрэгтэйчүүд малаа маллах болсон явдал. Энэхүү томоохон өөрчлөлт нь МАА-н хөдөлмөрийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог

18 ХЭҮК. 2021. Хүний эрх, эрх чөлөөний 20-р илтгэл. Улаанбаатар

19 ҮСХ. 2019. ХАА-н салбарын танилцуулга. Улаанбаатар

хумьж, өрхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байгаагийн хамт нийгмийн олон талт асуудлыг дагуулж байна гэж оролцогчид дүгнэж байна.

- Зарим сумын МАА-н мэргэжилтнүүд эмэгтэй малчид хүүхдээ даган төв суурин газар амьдрах болсноор сааль сүү авах, цагаан идээ боловсруулах үйл ажиллагаа орхигдож, тэрхэмжээгээр малын ашиг шимийн ашиглалт буурч байгааг тэмдэглэсэн.
- МАА-н хөдөлмөр хөнгөвчлөхөд чиглэсэн тоног төхөөрөмжийг нэвтрүүлснээр хөдөлмөр хөнгөвчлөөд зогсохгүй органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, МАА-н салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх давхар ач холбогдолтой байна.

ЗӨВЛӨМЖ

1. Залуу малчин эрэгтэй, эмэгтэйчүүдийн чадамж, хэрэгцээнд суурилсан тухайн орон нутгийн экосистем, байгаль цаг уур болон бусад нөлөөллийг тооцсон мал маллагаа, эрчимжсэн МАА эрхлэх, малчдын бүлэг, нөхөрлөл, хоршооны үргэлжилсэн сургалтууд болон мэргэжлийн зөвлөх үйлчилгээг зохион байгуулан, жинхэнэ үйлдвэрлэл, борлуулалтаараа холбогдсон, харилцан хяналттай, эрх тэгш оролцоотой, үр шимээ шударгаар хуваарилж бодит бүлэг нөхөрлөл, хоршоог бий болгож амьжиргаагаа дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх. Энэ нь залуусыг, тэр дундаа эмэгтэйчүүдийг МАА-н үйлдвэрлэлд татагдах нөхцөлийг бүрдүүлэх юм.
2. ШХА-ийн Ногоон алт төслийн хүрээнд ноолууртай дүйхүйц эдийн засгийн үр ашгаа өгөх сарлагийн хөөврийг боловсруулж, бэлтгэн экспортод гаргаж буй сайн туршлагыг судалж, залуу малчдад танилцуулах, ноолуур, махаас өөр малын бусад ашиг шим, түүхий эдээр бүтээгдэхүүн хийж, ашиг орлогоо нэмэгдүүлэхэд олон тал (салбарын яам, аймаг, сумын холбогдох байгууллага болон залуу эрэгтэй, эмэгтэй малчдыг оролцоо)-ын хамтын ажиллагаа, дэмжлэг шаардлагатай байна.
3. Малчин эрэгтэй, эмэгтэйчүүдийн зонхилох хэрэгцээнд тулгуурлан хөдөлмөрийг хөнгөвчлөх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих бага оврын тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, хөнгөлттэй үнэ, хүүгүй зээлээр худалдан авах боломжийг бүрдүүлэх.

Бүлэг 9.

БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ

Өнөөгийн малчдын аж байдалд нэн тулгамдаж буй асуудлуудын нэг бол бэлчээрийн доройтол, хомсдол юм.

Хүснэгт 9.1-д үзүүлсэнчлэн, Монгол Улсын нийт малын тоо толгой 1990 онтой харьцуулахад 2.6 дахин өссөн бөгөөд тэмээний тоо 0.88-аар буурсан байхад ямааны тоо толгой 5.4 дахин өссөн байна (Хүснэгт 9.1). Энэ нь ямааны ноолуур малчдын амьжиргааны гол эх үүсвэр болж байгаатай холбоотойгоор өссөн, гэвч бэлчээр доройтох нэгэн шалтгаан болж байна. Ямаа харьцангуй багатай байсан аймгууд болох Сэлэнгэд ямааны тоо толгой 24 дахин, Дорнодод 18 дахин өссөн бөгөөд сумдаас хамгийн өндөр буюу Сэлэнгэ аймгийн Мандал суманд 88 дахин, Цагааннуур 48 дахин, Дорнод аймгийн Матад суманд 28 дахин өссөн дүн илэрлээ. Харин ямааны тоо толгой Өмнөговь аймгийн Гурвантэс суманд 1.2 дахин, Ховдын Мөнххайрхан, Увсын Тариалан сумдад тус бүр 2.5 дахин өссөн нь хамгийн бага дүн юм. Малын тоо толгой нийт бэлчээрийн даацаас хэтэрсэн, сүргийн бүтэц, харьцаа өөрчлөгдсөн зэрэг нь малчин түмний өөрсдийнх нь аж ахуйгаа удирдаж буй шийдвэрийн үр дагавар.

Хүснэгт 9.1 Малын тоо, төрлөөр, өсөлт, 1990-2020 он, мян.тол²⁰.

Малын төрөл	1990	1995	2000	2005	2010	2015	2020	Өсөлт
Бүгд	25,856.88	28,572.31	30,227.5	30,398.83	32,729.53	55,979.78	67,068.49	2.59
Адуу	2,262.	2,684.4	2,660.8	2,029.1	1,920.3	3,295.34	4,093.86	1.81
Үхэр	2,848.7	3,317.1	3,097.6	1,963.6	2,176.	3,780.4	4,732.01	1.66
Тэмээ	537.5	367.5	322.9	254.2	269.6	367.99	472.93	0.88
Хонь	15,083.	13,718.6	13,876.3	12,884.5	14,480.4	24,943.13	30,049.43	1.99
Ямаа	5,127.7	8,520.7	10,269.8	13,267.4	13,883.2	23,592.92	27,720.25	5.41

Монгол Улсын нийт газар нутгийн 80 гаруй хувь нь бэлчээр бөгөөд 2015 оны байдлаар нийт бэлчээрийн 65 хувь нь байгалийн унаган дүр төрхөө алдаж доройтоод байна. Судлагдсан сумдад 2017 оны бэлчээрийн мониторингийн судалгаагаар бэлчээрийн даац 0.1-11 дахин хэтэрсэн бөгөөд хамгийн бага түвшин Дорнод аймгийн Матад, хамгийн өндөр түвшин Ховд аймгийн Дөргөн суманд илэрсэн буюу бэлчээрийн даац нь 11 дахин хэтэрсэн байна.

²⁰ www.1212.mn. YCX, 2020.

Хүснэгт 9.2 Нийт бэлчээр, доройтсон бэлчээр, бэлчээрийн даацын хэтрэлт, судлагдсан аймаг, сумдаар.


Аймаг, сум		Бэлчээрийн эзлэх хувь	Доройтсон бэлчээр, хувиар	Бэлчээрийн даацын хэтрэлт
Улсын хэмжээнд		80	65	
Ховд	Аймгийн хэмжээнд	67	50 орчим	2.6-12.4 дахин
	Булган			5.2 дахин
	Дөргөн			11 дахин
	Мөнххайрхан			7.4 дахин
	Мянгад			2.7 дахин
Дорнод		70	40 орчим	хэтрээгүй
	Баяндун			0.2 дахин
	Цагаан-Овоо			0.4 дахин
	Булган			0.2 дахин
	Матад			0.1 дахин
Өвөрхангай		90	70 гаруй	0.8-6.8 дахин
	Богд			1.4 дахин
	Сант			7.6 дахин
	Бат-Өлзийт			9.4 дахин
	Уянга			3.2 дахин
Өмнөговь		69	50 гаруй	1-7.5 дахин
	Хүрмэн			1.7 дахин
	Номгон			1.2 дахин
	Гурвантэс			5.1 дахин
	Мандал-овоо			2 дахин
Увс		66	70 орчим	1.3-3.5 дахин
	Зүүнхангай			2.9 дахин
	Тэс			4.8 дахин
	Наранбулаг			1.4 дахин
	Тариалан			1.7 дахин
Сэлэнгэ		39	80 гаруй	1-10.7 дахин
	Зүүнбүрэн			1.1 дахин
	Мандал			7.3 дахин
	Орхонтуул			4.8 дахин
	Цагааннуур			1.7 дахин

Эх сурвалж: Бэлчээрийн мониторингийн судалгаа. 2017 он.
Аймгуудын бэлчээрийн төлөв байдлын мэдээлэл видеонаос.

Судалгаа явагдсан бүх аймаг, сумдад “бэлчээрийн даац” хэтэрсэн гэж олонх (80 хувь) нь хариулсан бөгөөд ялангуяа Өвөрхангай, Сэлэнгэ, Ховд аймгаас судалгаанд оролцогч залуусын 90 орчим хувь нь ийн хариулжээ (Зураг 9.2). Энэ нь хүснэгт 9.1 дэх мэдээлэлтэй

ерөнхий утгаараа дүйж байна. Дорнод, Өвөрхангай аймгаас судалгаанд оролцсон эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 5 хувиар, бусад аймгуудад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ 4-16 хувиар илүүтэйгээр бэлчээрийн даац хэтэрсэн гэж дүгнэж байна. Эдгээр баримтууд бэлчээрийн даацын талаар залуу малчид харилцан адилгүй мэдээлэлтэй, харилцан адилгүй түвшинд санаа тавьж байгааг харуулна. Малчдыг үнэн зөв мэдээллээр хангасны үндсэн дээр бэлчээрийг сэргээх, сүргийн зохистой бүтцийг хангах шийдвэр гаргах зэрэг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг хөгжүүлж төлөвшүүлэх хэрэгт малчин залуусын өөрсдийнх нь санаачилга, оролцоог хангах нь илүү үр дүнтэй.

Зураг 9.1 Бэлчээрийн даац хэтэрсэн эсэх, оролцогчдын хариулт, хүйсээр, бүсээр.



Бэлчээрийн доройтол, даацын хэтрэлтийн улмаас зарим сумдын олон малчид өөрийн оршин суугаа сум, аймгаасаа нүүдэллэн, бэлчээр хайн амьдрах болоод байна. Судалгаанд оролцсон залуу малчдын 9.6 хувийнх нь мал нутгаасаа өөр газар өвөлжиж хаваржиж байна. Ялангуяа Өмнөговь аймгаас оролцогчдын 26.4 хувь, Өвөрхангай аймгаас оролцогчдын 16.4 хувийнх нь мал отроор өвөлжжээ. Харин Сэлэнгэ, Увс аймгийн малчид орон нутагтаа харьцангуй тогтвортой амь зууж байгаа бөгөөд Сэлэнгэ, Дорнод аймаг отрын малчдыг хүлээн авагчид болж байгаа нь бусад баримтаас ажиглагдлаа. Малчид хол нутагт отроор явахдаа ихэвчлэн гэр бүлээрээ нүүдэллэдэг ч хүүхдүүдээ сургуульд сургах үүднээс зарим тохиолдолд эрэгтэйчүүд нь дангаар буюу гэр бүл тусдаа амьдрах хэлбэрээр оторлож байна. Энэ байдал Хүснэгт 9.2 болон 9.3-аас ажиглагдаж байна.

Хүснэгт 9.3 Өөр нутагт мал нь өвөлжиж, хаваржиж буй залуу малчдын тоо, хувиар, хүйсээр.

Аймаг	Тоо	Хувь	Эрэгтэй	Эмэгтэй
Дорнод	9	6.50	66.67	33.33
Өвөрхангай	23	16.40	30.43	69.57
Өмнөговь	37	26.40	59.46	40.54
Сэлэнгэ	1	0.70	100.00	0.00
Ховд	8	5.60	75.00	25.00
Увс	2	1.40	50.00	50.00

Сумдаас Өвөрхангай аймгийн Сант сумаас 54.3 хувь, Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумаас 51.3 хувь, Гурвантэс, Номгон сумдаас тус бүрдээ 20 хувь, Хүрмэн сумаас судал-

гаанд оролцогчдын 14.3 хувийнх нь мал өөр сум, аймгийн нутагт оторлон өвөлжжээ. 2020 оны байдлаар Өвөрхангай аймагт Сант сумын малчин өрхийн 30 хувь буюу нийт 1000 гаруй хүн ам 150-780 км зайд отроор нүүдэллэжээ. Ганц биеэрээ оторлож буй малчид бүгд эрэгтэй (Хүснэгт 9.3). Судалгаанд оролцсон 54 хувь нь өвөлжилт хүндэрснээс, 34 хувь нь өвөл тэжээлийн хомсдлоос, 7 хувь нь зуншлага тааруу болж нүүхээс өөр аргагүйд хүрч аймаг, сумдын нутагт оторлож байгаагаа тайлбарлаж байна.

Хүснэгт 9.4 Өвөрхангай аймгийн отроор явж буй малчдын мэдээлэл, 2021 оны байдлаар

Сумын нэр	Оторт явсан малчин өрхийн эзлэх хувь	Нийт явсан хүн ам	Үүнээс Эрэгтэй, хувиар	Ганц биеэрээ оторлож буй хүн ам	Оторт явж эхэлсэн он	Оторлосон зай, км	Сүүлийн 2 жилд нутагтаа эргэж ирээгүй хүн ам
Сант	30.2	1017	48.1	47	2019	150-780	33
Уянга	1.2	59	42.4	Байхгүй	1999	871км	Байхгүй
Бат-Өлзий	17.4	781	61.6	19	2016	110	-

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн ХХААГ-ын мэдээлэл, 2021.

Судалгаанд оролцсон залуу малчид дунджаар 96км, эмэгтэй малчид дунджаар 94, эрэгтэй малчид дунджаар 97 км зайд оторлож байна. Аймгаар шинжилбэл, Өвөрхангай аймгийн малчид дунджаар 299 км (эрэгтэйчүүдийн дундаж эмэгтэйчүүдийнхээс 50 км хол), Өмнөговь аймагт 234 км (эрэгтэйчүүдийн дундаж эмэгтэйчүүдийнхээс 80 орчим км-ийн хол)-ийн газар оторлож байгаа бөгөөд сум хоорондоос гадна аймаг хооронд нүүдэллэж байна. Гэрлээгүй, бэлэвсэн, гэрлэлтээ цуцалсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү хол зайд оторлодог болох нь тус судалгааны баримтаас харагдлаа. Ялангуяа эрэгтэйчүүд илүү хол газар оторлож, отрын үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн ачаалал давамгайл болох нь харагдаж байна. Гэрлэж амжаагүй эрэгтэйчүүд эцэг эх, ах дүүсийнхээ малыг авч илүү хол зайд, өөр аймаг, сумдад оторлодог болох нь чанарын судалгааны мэдээллээс ажиглагдав. Түүнчлэн, хол газар оторлох болсноор гэр бүлүүд тусдаа удаан хугацаанд амьдрахад хүрч байна.

Хүснэгт 9.5 Малчдын оторлож буй нутаг хүртэлх дундаж км-ээр, хүйсээр, аймгаар.

Аймгийн нэр	Хүйс	Дундаж км	Нийт	Ст.хазайлт
Дорнод	Эрэгтэй	29.68	34	24.646
	Эмэгтэй	28.65	23	19.286
	Бүгд	29.26	57	22.458
Өвөрхангай	Эрэгтэй	269.78	9	218.805
	Эмэгтэй	316.67	15	204.718
	Бүгд	299.08	24	206.64
Өмнөговь	Эрэгтэй	263.96	23	198.359
	Эмэгтэй	182.6	15	173.879
	Бүгд	231.84	38	190.943

Сэлэнгэ	Эрэгтэй	49.48	73	49.034
	Эмэгтэй	54.49	49	54.556
	Бүгд	51.49	122	51.161
Ховд	Эрэгтэй	24.62	34	18.019
	Эмэгтэй	21.54	28	12.744
	Бүгд	23.23	62	15.809
Увс	Эрэгтэй	140.63	65	150.737
	Эмэгтэй	116.79	39	122.38
	Бүгд	131.69	104	140.635
Бүгд	Эрэгтэй	97.05	238	136.831
	Эмэгтэй	94.53	169	132.242
	Бүгд	96	407	134.786

Зураг 9.4-т малаа оторлуулж буй нутаг хүртэлх зай малын тооноос хамаарч байгааг харуулж байна. Ялангуяа өөр аймгийн нутагт малаа оторлуулж буй малчдын дунд олон малтай малчид зонхилдог байж магадгүй байна. Малчдын дунд бэлчээрийн маргаан нэг нутгийн малчид төдийгүй ахан дүүсийн хооронд гардаг болсныг Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооныхон дүгнэсэн байна. Иймээс монгол уламжлалаар бэлчээр, усаа харилцан хуваалцдаг ёс алдагдаж байгаагийн хамт аймаг, сум хооронд төдийгүй баг хооронд оторлох тохиолдолд өвөлжөө, хаваржаа, бууц, хондоо түрээсэлдэг байдал түгээмэл болжээ. Иймээс түрээсийн төлбөрт малаасаа илүүчилж чадахуйц малчид хол зайд оторлох боломжтой аж. Ийнхүү цаг уурын хүндрэл, ган, зуд, бэлчээрийн хомсдол цөөн малтай малчид, өрх толгойлсон цөөн малтай эмэгтэйчүүдийн амьжиргаанд илүү хүнд тусах хандлагатай байна.

Зураг 9.2 Оторлож буй нутаг ба малын тоо.



Судалгаанд оролцсон малчдын дийлэнх олонх буюу 90 хувь нь нутгийн бэлчээрийг үнэ төлбөргүйгээр, 8 хувь нь хамаатныхаа өвөлжөө, хаваржааг үнэ төлбөргүйгээр ашиглаж байна. Тун цөөхөн хувь нь өвөлжөө, хаваржааг түрээсээр болон гэрээгээр ашиглаж байна. Эмэгтэй тэргүүтэй өрхүүдээс өвөлжөө, хаваржааг түрээсээр болон гэрээгээр ашигладаг нэг ч тохиолдол таарсангүй.

ШИГТГЭЭ 9.1

Бэлчээрийн хомсдол үүсээд хүмүүс бие биенээсээ газар нутаг, ус ундаагаа харамлана. Мянгат малчид нь ойр хавийнхаа өвөлжөө, бууцыг худалдаад авчихдаг тэгэхээр газар олдох нь хэцүү, янз бүрийн үнээр худалдаж авч байна. Байрлал сайтай эсэхээс хамаараад 3-4 саяаас эхлээд 10 сая хүртэл байна.

Өвөрхангай аймаг, залуу малчин, эрэгтэй.

Хүндрэлтэй байна. Авлаа гэхэд хүний газар байна, ерөөсөө өвөлжихгүй байж газраа өгөхгүй, зарахгүй гэнэ, эсвэл өвөлжөө байгуулья гэхээр хүний бууцтай ойр байх гэх мэт хүндрэлтэй.

Өмнөговь аймаг, залуу малчин, эрэгтэй.

Аав ээж нь малчин эсвэл олон хүүхэдтэй малчин айлын хүүхэд шинээр өвөлжөө, бууц, хонд авах хэцүү болсон. Урагшаагаа байна, гэвч усгүй, худаг гаргалаа ч хүн мал уух аргагүй, худаг, бүрд, тойрмоо бараадаад олон айл буухаар бэлчээр нь хүнд болчихож байгаа юм. Баячуул нь аргатай, айл айлын бууц худалдаад авчихна. Тэгээд манай газар гээд хажуу хавиргаа ойртуулахгүй.

Өмнөговь аймаг, ХАА-н мэргэжилтэн, эмэгтэй.

Залуу малчдаас илүү нас тогтсон хүмүүс нь худаг усаа харамлаад худагтаа шавар шороо дүүргээд мал услах боломжгүй болгодог. Хувийн худаг биш, нийтийн худаг. Тэгэхээр бэлчээрээс гадна худаг усны асуудал хүнд байгаа.


Өвөрхангай аймаг, залуу малчин, эрэгтэй.

Сүүлийн үеийн залуу малчдад их хүндрэлтэй болсон байна лээ. Малчин айлын хүүхдүүд бол эцэг эхийнхээ газрыг авчихна. Харин шинээр мал маллаж буй хүмүүст хэцүү байгаа.

Өвөрхангай аймаг, залуу малчин, эмэгтэй.


Бэлчээрээс гадна ундны болон малаа услах усны хангамж залуу малчдад тулгамдаж буй асуудлуудын нэг юм. Тэр дундаа судалгаанд оролцогч эмэгтэй малчдын 58 хувь, эрэгтэй малчдын 53 хувь нь амьдран суугаа нутгаа усны гачаалтай гэж хариулсан бөгөөд энэ байдал бүх бүс нутагт адил илэрч байна. Тэр тусмаа өндөр уулын бүс нутгийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 16 хувиар илүү ийн хариулсан байгаа бөгөөд энэ нь нэг талаас нутгийнхаа усны хангамжид санаа илүү зовж буйг, нөгөө талаас усны хангамж тэдний амьдрал үйл ажиллагаанд илүүтэй хүндрэл учирч буйг харуулах юм. Судалгаанд оролцогчид дунджаар 3.58 км зайнаас, тэдний 29 хувь нь нэг км, 52 хувь нь хоёр км, 67 хувь нь 3 хүртэлх км, 33 хувь нь 4-өөс дээш км-ийн, хамгийн холдоо 30-50 км зайтай газраас ундны усаа авч, малаа усалж байна. Эмэгтэй малчин ундны болон малаа услах газраас дунджаар 3.7 км, эрэгтэй малчны хувьд 3.5 км зайтай газраас ус авч, малаа усалж байна.

Зураг 9.3 Усны гачаалтай гэж хариулсан оролцогчид, хүйсээр.



Монгол Улс дахь нийт худгийн тоо 1996 онтой харьцуулахад 2018 гэхэд 2 дахин өссөн байна. Гүний өрөмдмөл худаг 2000, он хүртэл өсөж, 2012 оноос хойш буурч байснаа 2012 оноос хойш өссөн ч 1996 оны түвшиндээ хүрээгүй байна, гэвч богино яндант болон бусад төрлийн худгийн тоо, энгийн уурхайн худгийн тоо ямагт өсөж иржээ²¹ (Зураг 9.4). Худаг ус ойр байрлах, хүртээмжтэй байх нь ундны усаа авах, малаа услахад зарцуулах ажлын ачаалал, цагийг бууруулдаг. Түүнчлэн, малчин өрхөд ногдох бэлчээрийн хэмжээг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй бөгөөд ус, худаг дагасан бэлчээрийн доройтлыг бууруулж, бүх бэлчээрээ үр дүнтэй ашиглах боломжийг бүрдүүлж, худгаас үүдэлтэй малчдын зөрчил маргааныг бууруулах нь гарцаагүй. Үүнтэй холбоотойгоор орон нутгийн удирдлага зохих түвшинд анхаарч ажиллаж байна. Тухайлбал, Өмнөговь аймаг 2020 оны байдлаар нийт бэлчээрийн 54.7 хувь нь найдвартай усны эх үүсвэрээр хангагдсан бөгөөд жил тутам 4-5 хувиар нэмэгдүүлсээр 2024 онд 70 хувьд хүргэхээр зорьж байна. Энэ жилд 79 инженерийн хийцтэй худаг шинээр гаргахаар, 30 худаг сэргээн засахаар төлөвлөж байгаа аж. Энгийн худаг ховоогоор татах тул цаг их зарцуулдаг, гэхдээ ихэнх малчид ус татах зөөврийн мотортой болж ажлаа хөнгөвчлөх болсон нь сайшаалтай. Учир нь, говь хээр, тал хээрийн бүс нутаг дахь худаг устай холбоотой эмэгтэй малчдад үүсдэг бэрхшээл багасч байна гэсэн үг юм. Ус авах, малаа услахад зарцуулах цаг буурснаар бусад үйл ажиллагаан дахь эрэгтэй, эмэгтэйчүүдийн оролцоо тэнцвэржиж, ингэснээр эмэгтэйчүүдийн гэрийн болон өрхийн үйлдвэрлэлд зарцуулах цаг, ачааллыг бууруулах юм.

Зураг 9.4 Худаг, усан сан, уст цэгийн тоо, улсын хэмжээнд, ҮСХ, 2018 он.



21 https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_1001_031V1

ДҮГНЭЛТ

- Бэлчээрийн доройтол, даацын талаар эрэгтэй, эмэгтэй малчид харилцан адилгүй мэдээлэлтэй байгаа бөгөөд малчдыг үнэн зөв мэдээллээр хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх ажлыг малчин залуусын өөрсдийн санаачилга, оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Бэлчээрийн доройтол, хомсдол залуу малчдын дунд удаан хугацаагаар эрэгтэйчүүд дангаар буюу гэр бүлээсээ тусдаа амьдрахад хөтөлж байна. Отрын үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн ачаалал эмэгтэйчүүдийнхээс давамгайл байна. Гэрлээгүй, бэлэвсэн, гэрлэлтээ цуцалсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү хол зайд оторлодог энэ нь нийгмийн харилцаанд оролцох, гэрлэхэд нь сөргөөр нөлөөлж, БЗДХӨ-өөр халдварлах эрсдэлийг өсгөж болзошгүй юм.
- Чинээлэг малчид бусад малчдын өвөлжөө, хаваржаа бууц, хондыг худалдан авах эсвэл түрээслэх замаар илүү том хэмжээний бэлчээр ашиглан, байгалийн хүнд хүчир үеийг даван туулах боломж харьцангуй өндөр байгаа бол цөөн малтай малчид, өрх толгойлсон цөөн малтай эмэгтэйчүүдийн амьжиргаанд цаг уурын хүндрэл, ган, зуд, бэлчээрийн хомсдол илүү хүнд тусах хандлагатай байна.
- Бэлчээрийн доройтолтой худаг усны хангамж холбогдож байна. Худгаас хэрэгцээний усаа хангадаг малчдын дийлэнх нь худгийн мотор ашиглан, ундны усаа авч, малаа усалдаг бөгөөд мотор хэрэглэснээр эмэгтэйчүүдийн гэрийн болон өрхийн үйлдвэрлэлд зарцуулах цаг, ачааллыг бууруулах юм.

ЗӨВЛӨМЖ

1. Уур амьсгалын өөрчлөлтөд зохицон аж ахуй, амьдрал үйл ажиллагааг өөрчлөх, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадамжийг залуу малчдад хөгжүүлэхийн тулд тэднийг идэвхтэйгээр оролцуулах чадавхжуулах арга хэмжээг системтэйгээр хүргэх шаардлагатай байна.
2. Ашиглаж буй бэлчээрийн талбай, бэлчээрийн хуваарилалт чинээлэг эсэхээс хамаарч, цөөн малтай малчид, өрх толгойлсон цөөн малтай эмэгтэйчүүдийн амьжиргаанд цаг уурын хүндрэл, ган, зуд, бэлчээрийн хомсдол илүү хүнд тусах хандлагатай байгаа тул тэгш, шударгаар хуваарилах, зохицуулах.
3. Боловсрол, эдийн засгийн боломжоор тааруу малчид өвөлжөө, хаваржаагаа өмчилж чадаагүй тохиолдол байгаа тул тэдгээр малчдад тусгайлан анхаарч, газар өмчлөх эрхээ эдлэхэд туслах шаардлагатай байна.
4. Тал, говь хээрийн бүсэд бэлчээрийн талбайг нэмэгдүүлэх, худаг усны хангамжийг сайжруулах, ингэхдээ малчдад адил тэгшээр ашиглах, хүртэх боломжийг бүрдүүлэх. Худгаас ус авахад цаг их зарцуулдаг учраас малчдад мотор худалдан авахад зээлийн хэлбэрээр туслалцаа үзүүлэх, нийтийн эзэмшлийн худгийг малчид адил тэгш ашиглах зохицуулалтыг сайжруулах

Бүлэг 10.

МАЛЧДЫН БҮЛЭГ, НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮНЧЛЭЛ, НИЙГЭМ-ХАМТ ОЛНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ОРОЛЦОО

2000 оноос бэлчээр, байгалийн нөөцөө хамгаалах зорилгоор малчдын бүлэг, нөхөрлөлийг олон улсын байгууллагуудын хөгжлийн төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн байдаг. 2019 оны байдлаар давхардсан тоогоор малчдын 58.3 хувь (166400) малчин хоршоо, нөхөрлөл, малчдын бүлгийн гишүүн байна. Үүнээс, 29.9 хувь хоршоо, 8.0 хувь нөхөрлөл 18.1 хувь малчдын бүлгийн, 2.2 хувь бусад бүлгийн гишүүн байна. Насны бүлгээр авч үзвэл, 15- 24 насны малчдын 43.6 хувь (10400), 25-34 насны малчдын 53.7 хувь (34800) малчны хоршоо, нөхөрлөл, малчдын бүлэг болон бусад ямар нэг бүлгийн гишүүн байна²². Судлагдсан Увс, Ховд, Дорнод, Өвөрхангай аймгийн малчдын 50.8-57.3 хувь хоршоо, нөхөрлөл, малчдын бүлэгт гишүүн аж. ҮСХ-ноос малчдын бүлэг, нөхөрлөл, хоршооны гишүүнчлэлийг хүйсээр ангилан гаргадаггүй байна.

Жендэрийн дүн шинжилгээгээр, малчдын бүлэг нөхөрлөлийн гишүүнчлэлийн байдлыг судалсан ба давхардсан тоогоор 15-34 насны 4 малчин тутмын нэг (26.5 хувь) гишүүнчлэлтэйгээс эрэгтэйчүүд 26.7 хувь, эмэгтэйчүүд 26.1 хувийг эзэлж байгаа аж. Хүснэгт 10.1-т үзүүлснээр, залуу малчдын бүлэг нөхөрлөл, хоршооны гишүүнчлэлийг ҮСХ-ноос гаргадаг үзүүлэлттэй харьцуулахад чамлалттай үзүүлэлт бөгөөд мэргэжилтнүүд болон залуу малчдын өгсөн ярилцлагаар, бүлэг, нөхөрлөл, хоршооны үйл ажиллагаа сул, ерөнхийдөө ноосны урамшуулал авах хэлбэр төдий байгаад шүүмжлэлттэй хандсан юм.

Хүснэгт 10.1 Малчдын бүлэг, нөхөрлөл болон хоршооны гишүүнчлэлтэй гэж хариулагчдын эзлэх хувийн жингээр болон хүйсээр.

Гишүүнчлэл	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
Хоршооны гишүүн	20.6	18.5	19.7
Малчдын бүлэг, нөхөрлөл	11.3	14.6	12.6
Залуучуудын бүлэг, нөхөрлөл	2.2	5.4	3.5

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан нутгийн иргэдэд байгалийн нөөцийг дундаа хариуцан хамгаалах, зохистой ашиглах болон нөхөн сэргээх эрхийг олгож, нутгийн иргэд нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс нийгэм, эдийн засгийн ашиг тусыг хүртэхээр, Хоршооны тухай хуулиар малчид мал аж ахуйн бүтээгдэхүүнээ борлуулах, боловсруулах, малын удам, үүлдрээ сайжруулах зорилгоор хоршиж, хамтарч ажиллах харилцааг зохицуулдаг. Асуулгын дүнгээр, малчид бүлэг хоршооны үйл ажиллагаанд оролцох болсноор залуу малчдын 33.3 хувь ноос ноолуурын урамшуулал дэмжлэг авдаг, 30.6 хувь малчид хоорондоо уулзаж, туршлага солилцдог, 30.1 хувь хэрэгцээт мэдээлэл авах хэлбэрээр үр өгөөжөө өгч байгаа гэж хариулсан нь нийт дүнд өндөр хувьтай илэрчээ. Хүйсээр шинжлэхэд эмэгтэйчүүдийн 37.6 хувь малчид хоорондоо уулзаж, туршлагаа хуваалцдаг, эрэгтэйчүүдийн 35.8 хувь ноос ноолуурын урамшуулал, дэмжлэг авдаг гэж хариулсан нь тэргүүлэх эрэмбийн үзүүлэлт болж байна (Зураг 10.1).

²² ҮСХ. 2019. ХАА-н салбарын танилцуулга. Улаанбаатар

Зураг 10.1 Малчдын бүлэг, нөхөрлөл болон хоршооны үйл ажиллагааны үр өгөөж, гишүүнчлэлтэй малчдын эзлэх хувь болон хүйсээр.



Монгол Улс бэлчээрийн даацад тохирсон өндөр ашиг шимтэй мал өсгөх бодлогын зорилтуудыг дэвшүүлээд байгаа. Энэ зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд яах аргагүй нөлөөлөх хүчин зүйлийн нэг бол малчдын хамтын бүлэг, оролцоог үр дүнтэй, хариуцлагатайгаар хөгжүүлэх явдал. Малчдын бүлэг, нөхөрлөл, хоршооны үйл ажиллагаа яагаад жинхэнэ утгаараа хөгжихгүй байна вэ гэдэг асуудал анхаарал татсан хэвээр байна. Судлагдсан малчдын 79.6 хувь хоршиж, нийлж ажиллах нь нэр төдий, муу гэсэн үнэлгээ өгчээ. Харин сайн ажилладаг гэж хариулагчдад Дорнод (64.3 хувь), Увс (42.1 хувь) аймгийн малчид тэргүүлж байна.

Чанарын судалгаанд оролцсон аймаг, сумдын ХХААГ, МАА-н мэргэжилтэн болон багийн засаг дарга нар Засгийн газраас малчдын хоршоог хөгжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авдаггүй, төсөв санхүүжилт шийдэгддэггүйгээс ажил хэрэг болдоггүй, хоршоо, нөхөрлөл, малчдын бүлэг байгуулах санаачилга, үйл ажиллагаа ихэвчлэн олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хүрээнд явагддаг, төсөл хөтөлбөр зогсоход түүнийг дагаад малчдын хамтын бүлэг, оролцооны асуудал сулардаг нийтлэг төлөв ажиглагдаж байна. ШХА-ийн Ногоон Алт төсөл 2004 оноос малчдын анхан шатны байгууллага болох бэлчээр ашиглагчдын бүлэг (БАХ)-үүдийг бэлчээрийн нөөцийг тогтвортой ашиглах, эдийн засгийн боломжийг сайжруулах чиглэлээр дэмжин ажиллажээ. 2014 оноос Завхан, Увс, Ховд, Говь-Алтай, Баян-Өлгий, Архангай, Баянхонгор аймгийн 96 суманд нийт 53,000 малчин өрх буюу бүх малчин өрхийн 30 гаруй хувийг хамарсан 960 БАХ, малчдын 67 хоршоо байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Улсын хэмжээнд 329 сумын 66-д сумын бэлчээр ашиглагчдын холбоо, 21 аймгийн 5-д аймгийн бэлчээр ашиглагчдын холбоог байгуулжээ. Судлагдсан сумдын МАА-н мэргэжилтнүүд төсөл дуусч, бэлчээр ашиглагчдын хэсгийн малчдын үйл ажиллагаа зогсонги байдалд орж байгаад шүүмжлэлттэй хандав. Ер нь малчдын бүлэг, хоршоодоос гарах санал санаачилгад

тулгуурлах, малчид, сум орон нутгийн байгууллага зэрэг олон талуудын бодитой, үр дүнтэй оролцоонд тулгуурлан хөгжүүлж, эдийн засгийн эрх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох нь малчдын бүлэг, нөхөрлөл урт удаан хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулна гэсэн байр суурийг илэрхийллээ.

Матриц 10.1 Малчдыг бүлэг, нөхөрлөл, хоршооны үйл ажиллагаа.

Аймаг	Хоршоог дэмжих чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүлээж буй үр дүн
Увс	- 2021 онд ХАА-н загвар хоршоо төслийн хүрээнд “Туяа” хоршоо (ДБХС)	- Ирак улсад мал, мах экспорлох - МАА-н бүтээгдэхүүн боловсруулах \ноос, эсгий хийх\
	- 2021 онд бүх суманд Шинэ хөдөө төсөл (УИХГ, АЗД-ын санаачилга, орон нутгийн төсөв)	- Тэжээлийн үйлдвэр барих - Сүүний үйлдвэр барих
	- Тариалан суманд загвар хоршоо байгуулах - Малчид 1 сая төгрөг хандивлаж тэргүүлэгч гишүүн болох	- Малаа эдийн засгийн эргэлтэд оруулах
	- Зүүнхангай суманд залуу малчдын холбоо байгуулсан - Хадлан тэжээлийн нөхөрлөл байгуулах	- Архидалт, малын хулгайгаас сэргийлэх
Сэлэнгэ	- Малчид бүлэг хоршооны зохион байгуулалтаар идэвхтэй ажилладаггүй - ШХА-ийн төслийн хүрээнд байгуулсан БАХ-ийн бүлгийн үйл ажиллагаа суларсан - Зүүнбүрэн сум: Залуучууд хадлан хадах г.м түлхүү хөдөлмөрөө хоршиж байна. (сошиал, телевиз)	- Хөдөлмөрөө хоршиж хадлан хадах
Өвөрхангай	- Малчид хамтран ажиллах, хурал уулзалтад оролцох идэвх оролцоо сул - Хурал уулзалтад эмэгтэйчүүд оролцдог, эрэгтэйчүүд хойрго	

Манай улс эрчимжсэн МАА-г хөгжүүлэх зорьж байгаа нөхцөлд малчдын бүлэг, нөхөрлөл, малчны хоршоог дэмжихгүйгээр бэрхшээлтэй хэмээн МАА-н мэргэжилтнүүд үзэж байна. Жишээ нь хоршооны тухай хуультай ч түүний хэрэгжилт сул, ноос ноолуурын урамшуулал авахаас хэтрэхгүй, хоршоо хөгжихгүй байгаа үндсэн шалтгаан, хууль эрх зүйн орчин, удирдлага зохион байуулалт, мэдээлэл, төсөв хөрөнгө, орон нутгийн захиргааны байгууллагын эрх үүрэг, оролцоо, малчны хоршоог дэмжих чиглэлд Засгийн газар болон орон нутгаас ямар бодлого барьж ажиллах зэрэг асуудлууд тулгамдсан хэвээр байна. УИХ-аас хоршоог хөгжүүлэх чиглэлд анхаарч хоршоог хөгжүүлэх сан болгох журам гаргахаар ажиллаж байна. Ирээдүйд малчдын хоршоог жинхэнэ утгаар нь хөгжүүлснээр малчдын хөдөлмөрийг хорших, малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, МАА-н бүтээгдэхүүнээр органик бүтээгдэхүүн хийх зэргээр үйлдвэрлэгч болох, хамтран ажиллагч байгууллагуудтай гэрээ хийх, МАА-н бүтээгдэхүүнийг ченжээр дамжуулахгүйгээр хэрэглэгчдэд хүргэх цаашлаад залуу малчдын хүсээд байгаа бэлчээрийн даацад тохирсон өндөр ашиг шимтэй мал маллах, бизнесмэн малчныг бэлтгэх зэрэг олон талт асуудалтай холбогдож байна.

ШИГТГЭЭ 10.1

Бэлчээрийн даацад тохирсон ашиг шимтэй мал өсгөж, малчдын орлого амьжиргаагаа нэмэгдүүлнэ. Ингэхдээ малчдын хоршоо дамжуулж, МАА-н бүтээгдэхүүн боловсруулахаар “Шинэ хөдөө” төсөл, “Загвар хоршоо” бүх суманд байгуулахаар зорьж байгаа ба эхнээс нь байгуулж байна.


Увс аймаг, ХХААГ-ын удирдах ажилтан.

Увс аймгийн Тэс сум аймагтаа хамгийн олон малтай сум, малын тоо өсч хорших, хамтрахаасаа тусдаа мал малладаг.

Увс аймаг, Тэс сумын МАА-н газрын мэргэжилтэн.

Малчдын ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахдаа залуу малчдад мэдээлэл өгөх, тэдний оролцоог хангаж, санал бодлыг сонсох нь хангалтгүй байна гэж дүгнэхээр үр дүн үзүүлж байна (Хүснэгт 10.2). Малчдаас гаргасан санал санаачилга, оролцоонд тулгуурлаж зөвлөлдөхгүйгээр малчдын бүлэг, хоршоо хөгжихгүй байгааг өмнөх туршлагауд харуулсан тул эрэгтэй, эмэгтэй малчдын хэрэгцээ, ашиг сонирхлын асуудлаар шийдвэр гаргахдаа тэдний оролцоог заавал хангах арга зам, хувилбарыг эрэлхийлэх нь тэргүүн зэргийн тулгамдсан асуудал мөн. 2021 онд АХБ, ЖҮХ-ноос “Хүндлэлд хүйс хамааралгүй” аяныг зорилтот хүн ам түүний дотор малчдад хүргэхэд подкаст, стори, шторк зэргийг ашигласан нь малчиндаа хүрсэн үйл ажиллагаа болсон сайн туршлага байна.

Зураг 10.2 Малчдын ашиг сонирхлын асуудлаар шийдвэр гаргахдаа залуу малчдын оролцоог хангаж буй байдал, хүйсээр болон хувиар.



Сумдын мэргэжилтнүүдийн тэмдэглэснээр жилдээ нэг удаа малчин залуучуудын уулзалт, зөвлөгөөн хийх, багийн хуралд оролцуулах зэргээр залуу малчдын оролцоо хязгаарлагдаж байна.

Иймд малчдын бүлэг, хоршоог урт хугацаанд дэмжих, дороос гарсан санаачилгыг дэмжих нь шаардлага байгааг тоон болон чанарын судалгааны үр дүн харуулж байна.

Мөн яагаад малчдын бүлэг, нөхөрлөл нэр төдий үйл ажиллагаа явуулж байгаад суурь судалгаа хийх шаардлагатай юм.

ДҮГНЭЛТ

- Судлагдсан малчдын дөрөвний нэг нь малчдын хамтын бүлэг, нөхөрлөл, хоршоонд гишүүнчлэлтэй, ноос ноолуурын урамшуулал, дэмжлэг авах, мэдээлэл, туршлагаа хуваалцах байдлаар үр өгөөжийг нь хүртдэг байна.
- Аймаг, сумдын түвшинд малчдын оролцоот байгууллага, хамтын бүлэг, нөхөрлөл, малчны хоршооны үйл ажиллагаа (ноосны урамшуулал авахаар хязгаарладаг) сул, гишүүнчлэлтэй малчдын хувьд идэвхгүй оролцоо давамгайлж байна. Малчдын хамтын бүлэг, оролцоог хангахад чиглэсэн бүлэг, нөхөрлөл, хоршоо ихэнхдээ олон улсын байгууллагын дэмжлэг, санаачлагаар хэрэгждэг, төсөл хөтөлбөр дуусахад үйл ажиллагаа суларч, зогсдог чиг хандлагатай байна.
- Малчдын бүлэг, хоршоодоос гарах санал санаачилгад тулгуурлах, малчид, сум орон нутгийн мэргэжилтнүүд зэрэг олон талуудын бодитой, үр дүнтэй оролцоонд тулгуурлан хөгжүүлж, эдийн засгийн эрх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох нь малчдын бүлэг, нөхөрлөл урт удаан хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулна гэсэн байр суурьтай байгааг аймаг, сумдын мэргэжилтнүүдтэй хийсэн чанарын судалгааны баримт харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Нэг талаас МАА-н үйлдвэрлэлийн үр шимийг нэмэгдүүлэх, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нөгөө талаас нийтийн эзэмшлийн байгалийн нөөц болох бэлчээрийн доройтол, даацыг бууруулахад малчдын бүлэг, нөхөрлөл, малчны хоршоогүйгээр амжилттай хэрэгжих боломжгүй нь олон улсын туршлагаас харагдаж байна. Иймд мэдлэг ойлголт, хандлагыг сайжруулахад дорвитой анхаарч, хоршооны харилцан ашигтай, хөдөлмөрөө хуваарилсан, хяналттай, итгэлцэл бүхий болгохуйц хууль, дүрэм журмын өөрчлөлтийг зайлшгүй хийх шаардлага бий болоод байна. Мөн хоршоог доороос санаачилгатай, энгийн гишүүдийн оролцоог жинхэнэ утгаар хангасан байхаар, нэг сум, аймгаар хязгаарлалгүй байгуулж, дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.
2. Малчдын бүлэг, хоршоог урт хугацаанд дэмжих, дороос гарсан санаачилгыг дэмжих шаардлага байгааг тоон болон чанарын судалгааны үр дүн харуулсан бөгөөд малчдын бүлэг, нөхөрлөлүүд сүүлийн 20 жил тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй талаар нарийвчлан судалж, нотолгоонд тулгуурласан бодлого хэрэгжүүлэх шаардлагатай юм.
3. 2021 онд АХБ, ЖҮХ-ноос “Хүндлэлд хүйс хамааралгүй” аяныг зорилтот хүн ам түүний дотор малчдад хүргэхэд подкаст, стори, шторк зэргийг ашигласан нь малчиндаа хүрсэн үйл ажиллагаа болсон сайн туршлага байна.

Бүлэг 11.

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМААРАХ АСУУДЛУУД

11.1 Эрүүл мэндийн асуудал

Судалгаагаар эрүүл мэндийн үйлчилгээний хүрээнд ямар асуудал залуу малчдад тулгамдаж байгааг тодруулав. Судалгаанд оролцсон залуусын 83 хувь, эмэгтэй малчдын 85 хувь, эрэгтэй малчдын 81 хувь нь шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн үйлчилгээ авч чаддаг гэж хариулжээ. Харин 13 хувь нь өдөр тутамдаа амин дэм хэрэглэдэг бөгөөд амин дэм хэрэглэдэг эмэгтэй малчдын хувийн жин эрэгтэйчүүдийнхээсээ 2 дахин өндөр байна (Хүснэгт 11.1).

Зураг 11.1 Эмнэлгийн үйлчилгээ авсан байдал, хүйсээр.



Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 40 хувь нь сарын өмнө эмнэлгийн үйлчилгээ авсан байгаа бол эрэгтэй малчдын 40 гаруй хувь нь сүүлийн хэдэн жил эмнэлэгт үзүүлээгүй байна. Ийнхүү эмнэлгийн үйлчилгээ авах байдалд хүйсийн ялгаа ажиглагдаж байна. Энэхүү баримтыг бусад судалгааны баримтууд давхар баталдаг²³. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаагаа судалгаанд оролцогчдын 25 хувь нь үйлчилгээ авах газраасаа хол, 21 хувь нь мал маллах хүнгүй, завгүйгээс очиж чаддаггүй, 13 хувь нь явуулын эрүүл мэндийн үйлчилгээг хүргэдэггүй, 9 хувь нь сумын эмнэлгийн үйлчилгээний чанар муу, тоног төхөөрөмж муу, 8 хувь нь өртөг өндөр гэж хариулсан аж. Үүнд хүйсийн ялгаа төдийлөн ажиглагдсангүй.

Судалгаанд хамрагдсан нийт залуусын 56 хувь, эмэгтэй малчдын 60.7 хувь, эрэгтэй малчдын 52.3 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Эрүүл мэндийн даатгалд даатгуулаагүй оролцогчдын 38 хувь нь сүүлийн хэдэн жил эмнэлэгт үзүүлээгүй байна. Энэхүү баримт нь эрүүл мэндийн даатгалд даатгуулаагүйн улмаас эмнэлэгт хандахгүй байгааг илэрхийлж болох ч, нөгөө талаас эмнэлэгт үзүүлэх шаардлага үүсээгүйн улмаас эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй байх нөхцөл болж байна. Иймээс залуусын дунд эрүүл мэндийн даатгалд хамрагдахын ач холбогдлын тухай мэдлэг ойлголтыг

²³ ЭМХТ, ДЭМБ. 2016. Эрүүл мэндийн үзүүлэлт-2016 Улаанбаатар.

сайжруулах шаардлагатай байна. Тэр дундаа эрэгтэйчүүдийг татан оролцуулахад түлхүү анхаарах нь зүйтэй.

Жирэмсэн, амаржсан эмэгтэйчүүдийн дийлэнх олонх (98 хувь) нь жирэмсний хяналтад орж байгаа ч цөөн тооны эмэгтэйчүүд энэ үйлчилгээний гадна үлдсэн байна. Иймд тэдгээр эмэгтэйчүүд рүү тухайлан анхаарах шаардлага байсаар байна (Хүснэгт 11.1). Хэдийгээр нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд хязгаарлагдмал ч 500-аас доош тооны малтай эмэгтэйчүүд жирэмсний хяналтад орж чадаагүй байдал ажиглагдав. Газар зүйн байршлын хувьд гол төлөв өндөр уулын болон хангайн бүсийн сумдын эмэгтэйчүүдэд түлхүү илэрлээ. Жирэмсний хяналт эхийн эсэн мэнд амаржихад нөлөөтэй бөгөөд эндэж буй эхчүүдийн дунд малчид, тэр дундаа алслагдмал нутгийн малчид зонхилох хандлагатай байдаг²⁴. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (2018)-ны дүн харахад хөдөөгийн багт амьдардаг буюу малчин эмэгтэйчүүдээс цөөн хэсэг нь тус үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгааг давхар нотолж байна.

Хүснэгт 11.1 Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах байдал, мэдлэг, хариултын хувиар, хүйсээр.

	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
А. Шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн үйлчилгээ авч чаддаг эсэх, хувиар						
Тийм	695	82.7	409	81.0	286	85.4
Үгүй	145	17.3	96	19.0	49	14.6
Б. Өдөр тутмын амин дэмийн хэрэглээ						
Тийм	108	12.8	47	9.3	61	18.2
Үгүй	733	87.2	458	90.7	275	81.8
В. Жирэмсэн эхийн хяналт						
Тийм					287	97.6
Үгүй					7	2.4
Г. Гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн талаарх мэдлэг						
Сайн мэдлэгтэй	248	29.5	104	20.6	144	42.9
Дунд зэрэг мэдлэгтэй	362	43.1	233	46.2	129	38.4
Бага зэрэг ойлголттой	185	22.0	132	26.2	53	15.8
Юу ч мэдэхгүй	45	5.4	35	6.9	10	3.0
Д. ДОХ, БЗДХӨ-өөс сэргийлэх арга хэрэгслийн талаарх мэдлэг						
Сайн мэдлэгтэй	259	30.8	130	25.7	129	38.5
Дунд зэрэг мэдлэгтэй	343	40.8	213	42.2	130	38.8
Бага зэрэг ойлголттой	204	24.3	136	26.9	68	20.3
Юу ч мэдэхгүй	34	4.0	26	5.1	8	2.4

Судалгаанд оролцсон залуу малчдын 72.6 хувь нь гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн, 71.6 хувь нь ДОХ, ХДХВ, БЗДХӨ-өөс сэргийлэх арга хэрэгслийн талаар дундаас дээш түвшний мэдлэгтэй гэж өөрсдийгөө үнэлжээ. Тэр

24 MONFEMNET, ARROW, SRHR for all, SIDA (2013) Нөхцөл байдлын үнэлгээ: Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх түгээмэл эрхийн хэрэгжилт. Монгол улс. Улаанбаатар. 7 дугаар тал

дундаа эмэгтэйчүүдийн мэдлэгтэй гэж үзсэн хувь эрэгтэйчүүдийнхээс өндөр байна. ЖСАХ-ийн хэрэгцээ хангагдсан эмэгтэйчүүдийн хувийн жинг байршлаар харьцуулахад хөдөөгийн малчин эмэгтэйчүүдийн хувь өндөр байдаг аж²⁵. Гэхдээ бэлгийн харилцаанд орох, ЖСАХ хэрэглэх шийдвэр гаргах эрх мэдлийн хувьд хөдөөгийн зарим эмэгтэйчүүд бусад байршлын эмэгтэйчүүдээс дутмаг байна. Тодруулбал, хөдөөгийн малчин эмэгтэйчүүдийн 74.9 хувь нь НҮТС-аар хүсээгүй үедээ нөхөр хамтран амьдрагчдаа бэлгийн хавьталд орохоос татгалзаж чаддаг, 55.8 хувь нь ЖСАХ-ийн шийдвэрийг өөрөө бие даан гаргадаг гэж хариулсан бөгөөд энэ нь бусад байршлын эмэгтэйчүүдээс бага зэрэг доогуур байгаа юм. Түүнчлэн, нөхөр, хамтран амьдрагч шийддэг гэж 18.6 хувь нь хариулсан бөгөөд энэ нь бусад байршлаас хамгийн өндөр түвшин ажээ²⁶. Эндээс хөдөөгийн залуусын дунд жендэр, эрүүл мэнд, нөхөн үржихүйн боловсрол олгох ажлыг сайжруулах хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

Ганцаарчилсан ярилцлагын мэдээллээс эрүүл мэндийн боловсрол, гэр бүл төлөвлөлт, ЖСАХ, ДОХ, ХДХВ, БЗДХӨ-өөс сэргийлэх сургалтад судалгаанд оролцогч малчин залуус бараг бүгд оролцож байгаагүй нь ажиглагдав. Иймээс тэдгээрийн дийлэнх нь энэ төрлийн сургалтыг малчдын дунд зохион байгуулах шаардлагатай гэж чухалчилж байв (Матриц 11.1). Насан туршийн боловсролын төвийн хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрийн агуулгад дурдсан сэдвүүд багтсан ч зорилтот бүлэгтээ хэрхэн хүргэх талаар анхаарах шаардлагатай байна.

Матриц 11.1 Эрүүл мэндийн чиглэлийн сургалтад хамрагдсан байдал.

Аймгийн нэр	Хүйс	Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт		Гэр бүл төлөвлөлт, ЖСАХ-ийн сургалт		ДОХ, ХДХВ, БЗДХӨ-өөс сэргийлэх сургалт	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй		Үгүй
Дорнод	Эрэгтэй	+	+	+	+		+
	Эмэгтэй		++		++		++
Өвөрхангай	Эрэгтэй		++		++		++
	Эмэгтэй		++		++		++
Өмнөговь	Эрэгтэй		++		++		++
	Эмэгтэй		++		++		++
Сэлэнгэ	Эрэгтэй	+	+	+	+		+
	Эмэгтэй		++		++		++
Увс	Эрэгтэй	+	+	+	+		+
	Эмэгтэй		++		++		++
Ховд	Эрэгтэй		++		++		++
	Эмэгтэй		++		++		++

Эх сурвалж: Залуу малчидтай хийсэн ярилцлагын мэдээллээс.

Судалгааны явцад судлагдсан аймаг, сумдаас осол гэмтлийн болон байгалийн гамшгийн шалтгаантай залуу малчдын нас баралтын талаарх мэдээллийг цуглуулсан юм (Хүснэгт 11.2). Тус мэдээллийг хүйсээр ангилсан хэлбэрээр аймаг, сумдын түвшинд олоход

25 УСХ, НҮБХАС, НҮБХС. 2018. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа – 2018. Улаанбаатар.

26 ibid. p97

бэрхшээлтэй байв. Гэхдээ албан бус мэдээллээр гол төлөв эрэгтэйчүүд илүүтэй өртдөг байна.

Хүснэгт 11.2 Осол гэмтэлд өртсөн, байгалийн гамшигт өртсөн нас баралтын тоо, судлагдсан аймаг, сумдаар, 2020 оны байдлаар.

Аймаг	Осол гэмтэлд өртсөн залуу малчдын тоо	Байгалийн гамшгийн (шуурга, зуд) улмаас нас барагсдын тоо
Дорнод	-	-
Өвөрхангай (аймгийн хэмжээнд)	50	7
Өмнөговь (судлагдсан сумдын хувьд)	8	2
Сэлэнгэ		
Увс (судлагдсан сумдын хувьд)	15	0
Ховд (судлагдсан сумдын хувьд)	24	0

Эх сурвалж: Аймаг сумдын эрүүл мэндийн үзүүлэлтийн мэдээллээс, 2020 оны байдлаар.


ШИГТГЭЭ 11.1

2021 оны 3 сарын 13-14-нд болсон салхи шуурганы улмаас Архангай аймагт 1, Дундговь аймагт 8 хүн (гол төлөв малчид) нас барсан байна.

Эх сурвалж: <https://news.mn/r/2410935/>

Шүдний өвчлөл нүүдэлчин монголчуудын дунд бага тархалттай өвчнүүдийн нэг бөгөөд сүүлийн үед хоол хүнсний хэрэглээнд гарсан өөрчлөлт шүдний өвчлөлд нөлөөлж байна. Хөдөө орон нутагт шүдний өвчлөл нэмэгдэж байгаа ч сумын төвд шүдээ эмчлүүлэх хийгээд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үйлчилгээг авах боломжгүй хэвээр байсаар байна (Зураг 11.2).


Зураг 11.2 Шүд цоорох өвчин, улс, бүсээр, 10000 хүнд ногдох, НЭМҮТ, 2019.



11.2 Нийгмийн хамгаалал, халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлууд

Судалгаанд хамрагдсан залуу малчдын гуравны нэг нь нийгмийн халамжийн хөтөлбөрт өөрсдийгөө хамрагдах шаардлагагүй гэж хариулсан бол 21 хувь нь бүрэн хамрагдсан гэж хариулсан байна. Харин 44 хувь нь нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдах ёстой ч хамрагдаж чадахгүй байгаа гэж хариулсан бөгөөд энэ нь нэг талаас зорилтот бүлгийн залуусаас халамжид хамрагдаж чадаж байгаа эсэхийг нягтлах шаардлага буйг харуулж байна. Нөгөө талаас нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдах гэсэн хүсэл сонирхол бага бус болохыг харуулж байна (Зураг 11.2). Үүнд хүйсийн зөрөө мэдэгдэхүйц ажиглагдсангүй.

Зураг 11.3 Шаардлагатай нийгмийн халамжийн үйлчилгээ, дэмжлэгт хамрагдаж буй байдал, хариултын хувиар.



Нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдаж чадахгүй байгаагаа 13 хувь нь оношлуулж чаддаггүй, 86 хувь нь мэдээлэл дутмаг, 9 хувь нь халамжийн ажилтнуудын харилцаа хандлага, 2 хувь нь санхүүгийн хүндрэлтэй холбож тайлбарлажээ. Хүйсээр мэдэгдэхүйц ялгаа илрээгүй ч, оношлуулж чаддаггүй, халамжийн ажилтнуудын харилцаа хандлагын бэрхшээлийн хувьд эмэгтэйчүүдэд, мэдээллийн дутмаг байдал эрэгтэйчүүдийн дунд бага зэрэг илүүтэй илэрч байна.

Судалгаанд хамрагдсан нийт малчдын 17 хувь, эмэгтэй малчдын 22 хувь, эрэгтэй малчдын 14 хувь нь малжуулах хөтөлбөрт хамрагдсан байна. Малжуулах хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт багтаан хэрэгжүүлдэг байсан бөгөөд 4-5 сая төгрөгөөр зах зээлийн үнээс хямдаар мал худалдан авч өгдөг байна. Тус хөтөлбөрт 18-45 насны, хоёроос доошгүй ам бүлтэй өрх хамрагддаг бөгөөд 2017 ба түүнээс өмнө 150-200 малтай өрхийг, 2018-2019 онд малгүй эсвэл 200 хүртэлх тоо толгой малтай өрхийг хамруулдаг байв. Санхүүгийн дэмжлэгийг 36 сар буюу 3 жилийн дотор хуваарь гарган, 100 хувь эргүүлэн төлөх ёстой. Харин 2021-2022 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт “Малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” (малжуулах) багтаагүй тул одоогоор хэрэгжихгүй байна.

Матриц 11.2 Малжуулах хөтөлбөрийн давуу болон сул тал

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Цөөн тооны малтай өрхийн амьжиргааг дээшлүүлэх боломжийг бүрдүүлдэг. - Халамжид хамруулах гэхээсээ хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг. - Хүүгүй. 	<ul style="list-style-type: none"> - Эргэн төлөх хугацаа хэт богино. - 2019 оноос өмнө 150-аас цөөн малтай эсвэл малгүй өрхийг орхигдуулдаг байсан нь зорилтот бүлгийн хүрээг хязгаарласан. - Малын тэр дундаа үржлийн малын үнэ өссөн тул дэмжлэг хязгаарлагдмал г.м - Малгүй хүмүүс хамрагдах боломжгүй (малтай болох гэж байгаа айл, өрх)

Эх сурвалж: Малчид, сум, аймгийн мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс.

ХНХЯ-аас 2018 оноос “Гэрээт малчин-өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэ нь хот суурин газраас хөдөө, орон нутагт

шилжин суурьшиж малчин болох, олон малтай малчны малыг гэрээгээр маллах боломжийг ажилгүй иргэдэд, хүний нөөцийн дутмаг байгаа олон малтай малчдад малаа маллуулах боломжийг олгож байгаа юм байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас гэрээт малчдын (гэр бүлийн гишүүдийн) нийгмийн даатгалын шимтгэл, хөдөө, орон нутаг руу нүүх тээврийн зардлыг даадаг. Мөн гэрээт малчин нь олон малтай малчинтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана. Бидний судалгаанд “Гэрээт малчин” хамрагдаагүй. Судлагдсан аймгуудын хэмжээнд энэхүү хөтөлбөр харилцан адилгүй хэрэгжиж байна.

ШИГТГЭЭ 11.2

Малжуулах хөтөлбөрт хамруулахдаа гэр бүлд олгохоор, тэр дундаа хөдөө суурьшин хоёул хамтдаа хөдөлмөрлөх гэсэн шаардлага тавьж байж нэг нь хөдөөнөө, нөгөө нь сумын төв дээр амьдраад байгааг бууруулна гэж боддог. Мөн цөөхөн малчдыг хамруулдаг, малгүй хүнийг хамруулдаггүй.

Өмнөговь аймаг, ХАА-н мэргэжилтэн, эрэгтэй.

Малжуулах хөтөлбөр учир дутагдалтай. Жил нь хэт богино. Мал авсны дараа жилээсээ эхлээд буцаагаад төлөөд эхэлдэг. Малтай болмоор байдаг, төлбөрөө төлмөөр байдаг гэсэн асуудалд ордог. Залуу улс мал цөөтэй, малаа өсгөх гэж л хамрагдаж байгаа.

Өвөрхангай аймаг, сумын МАА-н мэргэжилтэн, эмэгтэй.

Хээлтүүлэгч мал өндөр үнэтэй тул дэмжлэг нь бага. Хот суурин газраас хөдөө олон малтай өрхийн малыг маллуулах “Гэрээт малчин” хөтөлбөр хэрэгжиж эхэлж байх шиг байна. Нөхөрт нь хээлтэгч малаар жилд урамшууллыг олгох, эхнэр нь цалин хөлсний доод хэмжээгээр цалин олгох гэсэн хэлбэрээр гэрээ байгуулахад нь талуудад тусалж чадвал үр дүнтэй байж чадна. Гэтэл одоогийн байдлаар олон малтай малчны талд илүү чиглэсэн гэрээ байгуулагддаг нь харагддаг.

Өвөрхангай аймаг, ХАА-н мэргэжилтэн, эмэгтэй.

Нийгмийн даатгалд даатгуулсан залуус судалгаанд оролцогчдын 31 хувийг эзэлж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн 32.1 хувь, эмэгтэйчүүдийн 29.2 хувийг эзэлж байна. Ер нь нийгмийн даатгалд даатгуулсан байдлаараа залуу малчид (25-34 насны) хамгийн бага хамрагддаг ажээ²⁷. Иймд малчдын дунд нийгмийн даатгалд хамрагдах түвшинг нэмэгдүүлэх арга хэмжээ үгүйлэгдэж байна.

ДҮГНЭЛТ

- Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол эмнэлгийн үйлчилгээ авах нь харьцангуй тааруу байна. Судалгаанд хамрагдсан залуусын дунд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал хангалтгүй, тэр дундаа эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ доогуур хамрагдаж байна. Судалгааны дүн жирэмсэн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг алслагдмал нутгийн малчин эмэгтэйчүүд рүү анхаарч сайжруулах хэрэгцээ байгааг дахин нотолж байна.
- Хөдөөгийн малчин эмэгтэйчүүдийн дунд ЖСАХ-ийн хэрэгцээ хангагдсан байдал өндөр илэрч байгаа ч, бэлгийн харилцаанд орох, ЖСАХ хэрэглэх шийдвэр гаргах эрх мэдлийн хувьд хөдөөгийн зарим эмэгтэйчүүд бусад байршлын эмэгтэйчүүдээс

27 ҮСХ. 2017. Нийгмийн халамж, даатгал – 2017. Улаанбаатар

дутмаг байгаа тул хөдөөгийн залуусын дунд жендэр, эрүүл мэнд, нөхөн үржихүйн боловсрол олгох ажлыг сайжруулах хэрэгцээ байгаа нь харагдаж байна. Мөн судалгаанд хамрагдсан залуусын дунд эрүүл мэндийн боловсрол, гэр бүл төлөвлөлт, ЖСАХ, ДОХ, ХДХВ, БЗДХӨ-өөс сэргийлэх сургалтад хамрагдаж байгаагүй бөгөөд ийм төрлийн хэрэгцээтэй гэж тэд дүгнэж байна.

- Шүдний эрүүл мэндийн чиглэлд нийгмийн эрүүл мэндийн болоод тусламж үйлчилгээг хүргэх чиглэлд анхаарах хэрэгцээ илэрлээ.
- Залуу эрэгтэй, эмэгтэй малчдын дунд нийгмийн халамжийн үйлчилгээ, дэмжлэгт хамрагдах хүсэл сонирхол бага бус болох нь илэрлээ. Мөн шаардлага нөхцөлийг нь хангаж байгаа атлаа халамжид хамрагдаж чадахгүй байгаа малчид бий эсэхийг нягтлах шаардлагатай байна. Малжуулах хөтөлбөрт залуу малчдын тун цөөхөн хувь нь хамрагдсан бөгөөд эмэгтэй малчдын хамрагдах боломж эрэгтэйчүүдээс давуу байна. Малчин залуусын дунд малжуулах хөтөлбөрийг зохих өөрчлөлт оруулж үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгцээ байна.
- Нийгмийн даатгалд даатгуулах байдал судалгаанд оролцогчдын дунд тааруу байна. Энэ нь бусад судалгааны баримтаар давхар баталгаажиж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Залуу малчдад нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдахын ач холбогдлыг таниулан, хамрагдалтын түвшинг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
2. Алслагдмал нутгийн залуу малчдыг жирэмсэн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэхэд хувилбарт үйлчилгээ (явуулын болон суурин)-г нэвтрүүлэх.
3. Эрүүл мэндийн боловсрол, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүй, бэлгийн боловсрол, ЖСАХ, ДОХ, ХДХВ, БЗДХӨ-өөс сэргийлэх сургалт, арга хэмжээг хүртээмжийг нэмж чадах оновчтой аргыг сонгон залуу малчдад хүргэх.
4. Малчдад эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх явуулын (багийн үзлэг, оношлогоо, bus үйлчилгээ) үйлчилгээг тогтмол хүргэх боломжоор хангахад анхаарах;
5. Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг кабинетыг бүх аймгуудад байгуулах, үйл ажиллагааг тогтвортойгоор дэмжих.
6. Малжуулах хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа, зээлийг буцаан төлөх хугацаа, хуваарь, хүртээмж, хэмжээнд зохих өөрчлөлт оруулан, зогсоосон байгааг сэргээн үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Бүлэг 12.

БОЛОВСРОЛ, НИЙГЭМ-СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМААРАХ АСУУДЛУУД

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогод (2009) малчдын өөрөө өөртөө туслах, өөрөө өөрийгөө удирдах иргэний нийгмийн бүтцийг бий болгон хөгжүүлэхийг дэмжих, боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах замаар амьдралын дадал, заншилд өөрчлөлт оруулахаар тусгасан. Энэ бодлогын хүрээнд малчдад зориулсан сургалтыг орон нутагт үйлдвэрлэлийн явцад хэрэгжүүлэх байгууллага, малчны байнгын болон түр сургуулийг бий болгон бэхжүүлэх, түүгээр дамжуулан шат дараалсан сургалт (анхан шатны танин мэдэхүйн сургалтаас эхлээд технологи дамжуулах, нутагшуулах, инноваци нэвтрүүлэх зэрэг)-ыг зохион байгуулах, мөн малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах оновчтой арга механизмыг бий болгох, ерөнхий боловсрол эзэмших болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцахад нь дотуур байраар хангахад төрөөс дэмжлэг үзүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлжээ²⁸.


ХХААХҮ-ийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2018-2025)-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2-р зорилтын 4 дэх үйл ажиллагааны чиглэлд малчин гэр бүлийн хөгжлийг дэмжих, залгамж халааг бэлтгэх нийгэм соёл, эдийн засгийн цогц арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд малчдын хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ хүргэх, эцэг эхтэй нь хамт зайнаас сургах гэх мэт оновчтой арга замыг өнөөгийн боловсролын тогтолцооны хүрээнд тодорхойлон турших, түүнчлэн малчдын хүүхдэд боловсролын үйлчилгээ хүргэхдээ эцэг эхийн боловсролыг хамт дээшлүүлэх тогтолцоог хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөжээ. Мөн “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-дуламжлалт зан заншил, түүх, соёлын онцлогийг шингээсэн ерөнхий боловсролыг иргэн бүр заавал эзэмших, малчин өрхийн хүүхдийн хэрэгцээ, шаардлагыг харгалзсан бодлого хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Судлагдсан залуу малчдын боловсролын түвшинг харвал эмэгтэйчүүдийн 61.3 хувь, эрэгтэйчүүдийн 57.3 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Харин дээд боловсролтой залуу малчдаас эмэгтэй нь, тусгай дунд, бүрэн бус дунд, бага боловсролтой болон боловсролгүй залуу малчдаас эрэгтэй нь арай илүү судалгаанд хамрагджээ. Үндэсний хэмжээнд 15-34 насны малчин залуучуудын 4.5 хувь нь боловсролгүй, 21.5 хувь нь бага, 32.9 хувь нь суурь, 27.6 хувь нь бүрэн дунд, 6.3 хувь нь тусгай дунд, 7.2 хувь нь боловсролтой байна²⁹.

28 УИХ. 2009. Төрөөс малчдын талаар баримтлах бодлого. Улаанбаатар


29 www.1212.mn. ҮСХ, 2020. Хөдөө аж ахуйн салбарын 2019 оны танилцуулга. Улаанбаатар

Зураг 12.1 Судалгаанд хамрагдсан залуу малчдын боловсрол, хүйсээр.



Залуу гэрлэсэн малчин хосуудын эхнэр, нөхрийн 1.8 хувь нь боловсролгүй, 8.3 хувь нь бага, 15.8 хувь нь бүрэн бус дунд, 56.4 хувь нь бүрэн дунд, 1.7 хувь нь тусгай дунд, боловсролын түвшинг 16.1 хувь нь дээд боловсролтой байна. Залуу малчин эхнэр, нөхрийн боловсролын түвшний зөрүү (63%:50.7%) байгаа нь бүрэн дунд боловсролтой эхнэрийн хувийн жин нөхрийнхөөс дээгүүр, харин дээд боловсролтой нөхрүүдийн эзлэх хувийн жин эхнэрүүдээс өндөр байна. Үүнээс харахад малчид охидынхоо боловсролыг дэмжиж, сургуульд бүрэн сургах, улмаар ахисан түвшний боловсрол эзэмшүүлэх нийтлэг хандлагатай болсон байна. Харин хөвгүүд сургуульд суухгүй ч ажил амьдралаа зохицуулаад явчихна, охиноо боловсролтой болговол гэсэн эцэг эхчүүдийн жендэрийн хэвшмэл ойлголт 1990 оноос хойш байсаар ирсэн. Өнөөдөр энэ хэвшмэл ойлголтын үр нөлөө илэрч байгаа нь залуу малчин эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн боловсрол эзэмшилт, ялангуяа охидын боловсролын түвшин дээшилж, хөвгүүдийн боловсролын түвшин буурах хандлагаас харж болох юм (Зураг 12.1). Гэхдээ 32-34 насны боловсролгүй эсвэл бага боловсролтой эрэгтэйчүүдийн дунд гэрлээгүй байдал (33.4 хувь) бусад боловсролтой эрэгтэйчүүдээс өндөр байна.

Зураг 12.2 Залуу малчдын эхнэр, нөхрийн боловсролын түвшин, хувиар.



Судалгаанд оролцсон залуу малчдын 54.2 хувь нь сургуулийн насны хүүхэдтэй бөгөөд хаанаас сургуульдаа явж байгааг тодруулсан. Залуу малчдын сургуулийн насны хүүхдүүдийн бараг 50 хувь нь гэрээсээ, 30.2 хувь нь байдаг айлаасаа, 19.5 хувь нь дотуур байрнаасаа сургуульдаа явж байна. Судалгаанд хамрагдсан Булган, Бат-Өлзийт, Уянга, Мандал-Овоо, Номгон, Хүрмэн, Зүүнбүрэн, Орхонтуул, Цагааннуур, Мөнххайрхан, Зүүнхангай, Тариалан сумдын сургуулийн хүүхдүүдийн 50-иас дээш хувь нь айлаас болон дотуур байрнаасаа сургуульдаа явж байна.

Хүснэгт 12.1 ЕБС-ийн сурагчид хаанаас сургуульдаа явж байна вэ,
сумдаар, хувиар

Аймаг	Сум	Гэрээсээ	Дотуур байрнаасаа	Байдаг айлаасаа
Дорнод	Баяндун	69.2	19.2	11.5
	Булган	47.1	17.6	35.3
	Матад	57.9	15.8	26.3
	Цагаан-Овоо	52.4	9.5	38.1
Өвөрхангай	Бат-Өлзийт	42.9	21.4	35.7
	Богд	66.7	19	14.3
	Сант	52.4	28.6	19
	Уянга	36.8	21.1	42.1
Өмнөговь	Гурвантэс	77.8	11.1	11.1
	Мандал-Овоо	29.4	17.6	52.9
	Номгон	46.7	13.3	40
	Хүрмэн	33.3	20	46.7
Сэлэнгэ	Зүүнбүрэн	37.5	25	37.5
	Мандал	72.2	11.1	16.7
	Орхонтуул	43.8	12.5	37.5
	Цагааннуур	22.2	27.8	50
Ховд	Булган	52.9	23.5	23.5
	Дөргөн	56.3	18.8	25
	Мөнххайрхан	35.3	47.1	11.8
	Мянгад	51.9	11.1	37
Увс	Зүүнхангай	35	10	55
	Наранбулаг	66.7	0	33.3
	Тариалан	16.7	55.6	27.8
	Тэс	61.1	22.2	16.7

Боловсролын үйлчилгээ авахад тулгарч байгаа бэрхшээлийг тодруулахад 46.2 хувь нь боловсролын үйлчилгээтэй холбоотой бэрхшээл байхгүй бол 23.9 хувь нь ковидын үед хүүхдээ цахим, теле хичээлд хамруулахад хүндрэлтэй, 10 хувь нь хоёр тусдаа амьдрахаас өөр аргагүй байна, 8.5 хувь нь байн байн хүүхдээ эргэж анхаарал халамж тавьж чаддаггүй, 6.8 хувь нь хүүхдээ цэцэрлэгт хамруулж чаддаггүй, 3.8 хувь нь мэдлэг боловсролоо дээшлүүлэх боломж байхгүй, 0.1 хувь нь тухайн орон нутгийнх биш учраас сургууль, цэцэрлэгт хамруулж чаддаггүй байна. Мөн орон нутгийн сургуульд багш их солигддог, хүүхэд сургах арга зүй тааруу багш нар олширсон, дотуур байрны үйлчилгээ тааруу, сүлжээгүй муу учраас ялангуяа ковид-19 цар тахлын үед хүүхдүүд цахимаар хичээл үзэж судлахад хүндрэлтэй зэрэг бэрхшээлүүдийг дурдсан байна.

ШИГТГЭЭ 12.1

Нэг хүүхэд маань тавдугаар анги, нөгөө нь энэ жил нэгдүгээр ангид орох юм. Манай эхнэр багш мэргэжилтэй, хүүхдүүдтэйгээ төв дээр байдаг. Би хоёр гэрийн хооронд л явж байна даа. Манай хөдөө бол эхнэрүүд төв суурин газар хүүхдээ хараад, эрчүүд малаа маллана гэсэн амьдралтай л байна даа. Ихэнх нь хоёр тусдаа л байна.

Өвөрхангай аймаг, гэрлэсэн малчин эрэгтэй, 34 настай.

Ковидын үед сургуулийн хүүхдийн хичээл хүндрэлтэй байна. Хөдөө орон нутагт сүлжээ муу байдаг учраас хичээлээ үзэж чадахгүй, их хоцрогдолд орж байгаа байх. Мөн утасны датагаар орохоор хурдан дуусчихдаг, тэгээд ч үнэтэй юм.


Ховд аймаг. Гэрлэсэн залуу малчин, эмэгтэй, 33 настай.

Сургууль, цэцэрлэгийн хүүхэдтэй гэр бүл хоёр тусдаа амьдардаг, ээж нь сум, аймгийн төвд, аав нь хөдөө малаа маллаад амьдардаг айлууд ихэссэн. Аав ээж нь малчин хүмүүсийн дийлэнх нь хүүгээ малчин болгодог.

Сэлэнгэ аймаг, ХХААГ-ын мэргэжилтэн, эмэгтэй.

Судалгаанд хамрагдсан гэрлэсэн залуу малчдын хувьд хүүхдүүдээ сургууль, цэцэрлэгт хамруулахтай холбоотой бэрхшээлүүд зонхилж байхад гэрлээгүй залуу малчдын хувьд 33.4 хувьд мэдлэг боловсролоо дээшлүүлэх боломжгүй гэж хариулсан байна.

Зураг 12.3 Залуу малчдын боловсролын үйлчилгээ авахад тулгардаг бэрхшээл, гэрлэлтээр.



Мөн ерөнхий боловсролын сургуульд 6 настай хүүхдийг элсүүлэн сургаж байгаатай холбоотой залуу малчин гэр бүл хоёр тусдаа амьдарч, хичээлийн жил есөн сар үргэлжлэх хугацаанд хүүхдийг зөвхөн эх нь халамжлан хүмүүжүүлж, эцэг нь зөвхөн тэжээгчийн үүрэг гүйцэтгэж байгаа өрөөсгөл үзэгдэл бий болсноор хүүхдийн сурлага, хүмүүжилд болон гэр бүлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байгааг ганцаарчилсан ярилцлагад оролцсон малчид, орон нутгийн мэргэжилтнүүд илэрхийлж байна.

Аймаг, сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаар аав ээж нар охиноо сургуульд сургах, эрэгтэй хүүхдийн боловсролыг дэмжихгүйгээс сурах дургүй болох, сургуулиас завсардуулж малчин болгодог. Эцсийн дүндээ боловсролтой эмэгтэйчүүд малчин эрэгтэйгээ тоож гэрлэхгүй байдалд хүрч байна.

ШИГТГЭЭ 12.2

Аав ээж нар эмэгтэй хүүхдийг сургуульд, эрэгтэй хүүхдийг малчин болгодог. Боловсролтой эмэгтэй малчин эрэгтэйгээ тоодоггүй, гэрлэдэггүй.

Увс аймаг, сумын МАА-н тасгийн мэргэжилтэн.

Ер нь эмэгтэй хүүхэд хөдөө гарна гэдэг ойлголт байхаа больсон гэж харж байна. Айл бүр л эмэгтэй хүүхдээ сургууль соёлд явуулаад, хөвгүүдээ цөөхөн дөө. Хөвгүүдээ бол яахав дээ л гэсэн байр суурьтай байна. Охидуудыг хөдөө гаргах тал дээр ямар нэгэн үйл ажиллагаа, сургалт судалгаа хийвэл зүгээр юм болов уу даа. Манай нутаг гэрлээгүй залуучууд зөндөө байна.

Өмнөговь аймаг, сумын МАА-н тасгийн мэргэжилтэн.

Залуу малчидтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаар сургуульд хүүхдээ сургахдаа гэр бүл хоёр тасарч тусдаа өрх үүсгэн амьдрахаас гадна аймаг, сумын төвд аав ээж, ах дүү, төрөл садныдаа эсвэл дотуур байранд суулгаж байна. Айлд суулгаж амьдруулж байгаа хүүхдэд тодорхой асуудал бэрхшээл үүсэх эрсдэлтэй байдгийг залуу малчин аав ээж нар санаа зовнин ярьж байна. Юуны өмнө эцэг эхийн анхаарал халамжийг гүйцэх төрөл садан гэж байхгүй учраас хичээл сурлага, хүмүүжил муудах, хичээлээс хоцрох, таслахаас гадна эцэг эхийн хайр халамжаар дутагдаж байгааг илэрхийлж байна. Түүнчлэн эцэг эхийн асран хамгааллаас хол хөндий айлд амьдарч байгаа хүүхдийн хувьд хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын асуудал хөндөгдөж, гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс гадна хүүхэд гадуур сэлгүүцэх, гэмт хэрэг зөрчилд холбогдох, орой үдэш явахад гарах эрсдэлүүд байдаг.

ШИГТГЭЭ 12.3

Сургууль эхлэхээр хүүгээ сургуульд оруулна даа. Сумын төв дээр хамаатан байгаа. Тэд нар дээрээ л байлгана. Ойрын хамаатнууд, эмээ, өвөөтэй нь байлгана гэж бодож байна.

Өвөрхангай аймаг, гэрлэсэн залуу малчин, эмэгтэй, 31 настай.

2014 онд НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхдийн төлөө Үндэсний газраас хийсэн судалгаанд эцэг эхийн асран хамгааллаас хол хөндий айлд амьдарч байгаа болон өрх толгойлж амьдарч байгаа хүүхдүүдэд тавих хараа хяналт сулаас тоглоом тоглох, бусдад уруу татагдах, гадуур сэлгүүцэх эрсдэл өндөр байна. Эцэг эхийн асран хамгааллаас хол хөндий айлд амьдарч байгаа хүүхдүүд сурлагаар хоцрогддог. Мөн хоол тэжээлийн дутагдал, ханиад томуу, амьсгалын замын өвчлөл, эцэг эхийн хайр халамжаар дутдаг, гадуур тэнэх, хараа хяналтгүй байх, бусдад уруу татагдах, хичээл таслах, хоцрох, сургууль завсардах, аав, ээжийгээ санах, ганцаардах зэрэг нийгэм сэтгэл зүйн асуудлууд учирдгийг дурджээ³⁰.

Судалгаанд хамрагдсан залуу малчин гэр бүл хоёр тусдаа өрх үүсгэн амьдрахгүйгээр хүүхдээ дотуур байранд суулгаж болох боловч бага насны хүүхэд биеэ дааж чадаагүй үедээ дотуур байранд амьдрахад аав ээжээ санах, гэрээ үгүйлэх, эцэг эхийн халамж дутагдах, хичээлээ ойлгохгүй байх зэрэг хүндрэлүүдээс гадна дотуур байрны эрүүл ахуй, хоол хүнсний аюулгүй байдлын баталгаа тааруу, хүчирхийлэл дарамт, дээрхлэлт зэрэг олон бэрхшээлүүдийг эцэг эхчүүд өгүүлж байна.

30 НҮБХС, ХТҮГ. 2014. Түр хугацаагаар айлд амьдарч буй хүүхдийн хамгаалагдах эрхийн хэрэгжилт. Улаанбаатар

Улсын хэмжээнд дотуур байранд амьдарч байгаа малчин өрхийн хүүхдүүдийн тоо 2010 онд 35.5 мянга (29.7хувь), 2015 онд 24.1 мянга (24.9хувь), 2019 онд 27.1 мянга (22.8 хувь) байгаа нь ерөнхийдөө буурах хандлагатай байгааг харуулж байна³¹. Дотуур байранд амьдарч буй хүүхдүүд хангалттай, эрүүл аюулгүй хоол хүнс авч чадахгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдаагүй хэвээр байсаар байна. Мөн дотуур байранд хүүхдүүд нэг нэгнийгээ дээрэлхэх, дарамтлах, багш хүүхдийг дарамтлах явдал гарч байгаагийн улмаас хүүхдүүд дотуур байранд бус айлд амьдрах явдал түгээмэл байна³².

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 5 дугаар сарын 1-ны өдрийн А/239 тоот тушаалаар “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”, 2019 оны 10 сарын 16-нд “ЕБС-д суралцагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ”-ний стандартыг батлагдан хэрэгжиж байна. Дотуур байрны орчинд тавих стандарт, шаардлага, дотуур байрны үйлчилгээ, хүний нөөцөд тавих шаардлага, цэвэрлэгээ, ариутгал, засвар үйлчилгээ, аюулгүй байдал ба тамхины эсрэг зохицуулалт, хориглох зүйл зэргийг нарийвчлан тусгасан³³.

Зарим залуу малчдын амьдралын боломж бололцоо, амьжиргаа дээшилсэнтэй холбоотой хүүхдээ дотуур байранд суулгах хүсэлгүй болсон бол зарим эцэг эхчүүд өөрсдөө дотуур байранд амьдарч байхдаа хүчирхийлэл, дарамттай тулгарч байсан учраас хүүхдээ дотуур байранд амьдруулах сонирхолгүй болсон байна.

ШИГТГЭЭ 12.4

Хүүхдүүдээ дотуур байранд суулгах нь багассан. Нэгдүгээрт, эцэг эхчүүдийн амьдралын боломж бололцоо сайжирсны шинж, хоёрдугаарт тэдгээр эцэг эхчүүд маань өөрсдөө дотуур байранд өссөн, таатай тухтай байгаагүй учраас ялангуяа эмэгтэй хүүхдүүд хүчирхийлэлд өртөх, хөвгүүд дарамтанд өртөх гээд асуудал байсан учраас өөрсдийнхөө хүүхдийг тийм байдалд оруулахгүйг л бодно шүү дээ.
Өмнөговь аймаг, ХХААГ-ын мэргэжилтэн, эмэгтэй.

Насан туршийн боловсролын амьдрах ухааны сургалтын хөтөлбөрт (2010) малчдад чиглэсэн мал маллах арга ухаан, түүний ашиг шимийг хүртэх сэтгэлгээ, аргуудыг хэрэглэн холбогдох мэдээллийг боловсруулах, мал болон малчин хүний өмнө тулгамдаж буй аливаа асуудалд идэвхтэй оролцож учир шалтгааныг үндэслэлтэй тайлбарлан үзэл бодлоо хамгаалах, зөвшилцөх чадвартай болгох зорилгоор дөрвөн улирлын мал маллагаанд анхаарах зүйлсийг нэрлэх, малыг эрүүл байлгах, малын өвчинг ялгах, дайвар бүтээгдэхүүнийг хэрэглэх, түүний эрүүл мэндийн ач холбогдол, сүү цагаан идээ хийх уламжлалт аргад суралцах, малын гаралтай түүхий эд боловсруулдаг уламжлалт аргуудыг судлах, оновчтой аргыг сонгож хэрэглэх зэрэг сэдвийн хүрээнд сургалт явуулдаг байна³⁴. Судалгаанд хамрагдсан залуу малчидтай хийсэн ярилцлагаар насан туршийн боловсролын дүйцүүлэх хөтөлбөрт хамрагдан боловсрол эзэмшсэн залуу малчид байгаагаа өгүүлж байна.

31 www.1212.mn. УСХ. 2020

32 НҮБХС, ХТҮГ. 2014. Түр хугацаагаар айлд амьдарч буй хүүхдийн хамгаалагдах эрхийн хэрэгжилт. Улаанбаатар

33 Стандарт, хэмжил зүйн газар, 2019. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага. Улаанбаатар

34 БСШУСЯ, 2010. Насан туршийн боловсролын амьдрах ухааны сургалтын хөтөлбөр. Улаанбаатар

ШИГТГЭЭ 12.5

Зарим нь малчин болж байна, гэхдээ харьцангуй цөөхөн байна. 2019 онд боловсролын байдлыг судалж байсан, мэдээллийн хувьд гол төлөв дүйцүүлэх хөтөлбөрт хамрагдаад бүрэн бус дунд боловсролтой хүмүүс дийлэнх, гэхдээ дээд боловсролтой ч хүмүүс бий. Огт бичиг үсэггүй хүмүүс ховор. Бид гол төлөв мал руугаа анхаараад энэ чиглэлд бага анхаардаг.

Өвөрхангай аймаг, ХХААГ-ын мэргэжилтэн.

2019-2020 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан нийт хүүхдийн 31,891 буюу 11.8 хувь нь малчдын хүүхэд байгаа нь өмнөх оноос 931 буюу 0.3 пунктээр өссөн байна.

Хүснэгт 12.2 ССургуулийн өмнөх боловсролд хамрагдсан малчдын хүүхдийн тоо, онуудаар

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Насны бүлгээр			
		2 хүртэлх	2 нас	3-5 нас	6 нас
2015-2016	31,977	414	5,482	25,136	945
2016-2017	31,254	387	4,814	25,233	820
2017-2018	29,493	365	4,791	23,549	788
2018-2019	30,960	402	5,139	25,353	66
2019-2020	31,891	522	5,172	26,134	63

2019-2020 оны хичээлийн жилд хувилбарт сургалтад 20,710 буюу 7.9 хувь нь малчдын хүүхэд хамрагдаж байгаа нь өмнөх оноос 0.4 пунктээр буурсан байна. Үүнээс 3,212 хүүхэд ээлжийн бүлэгт, 15,045 хүүхэд нүүдлийн бүлэгт, 2,453 хүүхэд явуулын багшийн үйлчилгээгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсролыг эзэмшсэн байна³⁵.

Судалгаанд хамрагдсан залуу малчдын 75 хувь нь 0-5 насны хүүхэдтэй бөгөөд 6.8 хувь нь хүүхдээ цэцэрлэгт хамруулж чадаагүй нь орон тооны хүрэлцээ хүртээмж, өрхийн алслагдмал байршилтай холбоотой. Мөн сүүлийн 2 жилд Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас болж хувилбарт сургалтууд үйл ажиллагаа явуулаагүйн улмаас малчдын хүүхдүүд СӨБ-ын гадна үлдэхэд хүргэсэн.

Судлагдсан зарим суманд хүүхдээ СӨБ-ын гэр цэцэрлэг, нүүдлийн цэцэрлэг, явуулын багшийн цэцэрлэг зэрэг хувилбарт сургалтад хамруулж байгаа бол зарим суманд энэ үйлчилгээг авч чаддаггүй эсвэл байхгүй байна. Хувилбарт сургалтын үйлчилгээг нүүдлийн гэр цэцэрлэгийн бүлэг богино хугацаатайгаар ихэвчлэн зундаа үзүүлж байгаа талаар ганцаарчилсан ярилцлагад оролцсон залуу малчид өгүүлж байна. Хүүхдээ цэцэрлэгт хамруулахын тулд эхнэр нь хүүхдүүдтэйгээ сумын төвд, нөхөр нь хөдөө малаа маллаж хоёр тусдаа амьдарч байгаа залуу малчин өрх нэлээдгүй байна. Үүнээс гадна хот айлаараа амьдарч нэг нэгнийхээ хүүхдийг харж ханддаг байсан уламжлал алдагдснаас бага насны хүүхдээ хараа хяналтгүй орхиж малд явах тохиолдолд хүүхдийн аюулгүй байдал алдагдаж байна.

35 https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2001_011V3. YCX, 2019

ШИГТГЭЭ 12.6

Багийн төв дээр зундаа гэр цэцэрлэг гэж явдаг байсан. Манай хүүхдүүд өмнө нь зуны цэцэрлэгтэй, тэгээд сургуульд орохын өмнө сумын төвийн цэцэрлэг дээр суусан.

Өвөрхангай аймаг, гэрлэсэн залуу малчин эмэгтэй, 31 настай.

Зуны цагт явж л байдаг. Хөдөөний хүүхдүүдэд хэрэгтэй л гэж санагдаад байдаг.


Өмнөговь аймаг, гэрлэсэн залуу малчин эмэгтэй, 30 настай.

Залуу малчин өрхүүд бага насны хүүхэдтэй, эхнэр нь хүүхдүүдээ сургууль, цэцэрлэгт хамруулж сумын төвд амьдарч байна. Нөхрүүд нь хөдөө мал дээр малаа маллаж ихэнх малчин залуу гэр бүл тусдаа амьдарч байна.

Дорнод аймаг, Багийн засаг дарга.

Залуу малчдын нийгэм-соёлын үйлчилгээнд хамрагдалтыг тодруулахад судлагдсан малчдын 50 гаруй хувь нь үйлчилгээг авахад хүндрэлтэй байдаг аж. Хамгийн хүндрэлтэй үйлчилгээнд халуун усанд орох (62.1 хувь) сонирхсон номоо худалдан авах (58.3 хувь), үзвэр үзэх (54.2 хувь) зэргийг дурджээ. Судлагдсан 10 залуу малчны нэг нь ч номын сангаар үйлчлүүлж үзээгүй, 4 хувь нь сонирхсон номоо худалдаж авч үзээгүй байна.

Зураг 12.4 Залуу малчдын нийгэм-соёлын үйлчилгээнд хамрагдалт, хувиар.



Эрэгтэй залуу малчдыг бодвол эмэгтэй залуу малчдын 65.2 хувь халуун усанд ороход, 60.8 хувь нь сонирхсон номоо худалдаж авахад хүндрэлтэй байдаг. Залуу малчдыг явуулын номын сангаар үйлчлэх, соёл урлагийн үзвэр үйлчилгээгээ хангах, уулзалт, зөвлөгөөн, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг малчдыг хөгжих, эвлэлдэн нэгдэх, мэдээллээр хангах цогц соён гэгээрлийн үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна. Үүнээс харахад залуу малчдад хамгийн хэрэгцээтэй байгаа үйлчилгээнүүдийн хүртээмж тааруу байгааг судалгаанд оролцогчид илэрхийлсэн. Сум орон нутгийн удирдлага сумын соёлын клубтэйгээ хамтран залуу малчдад хэрэгцээтэй байгаа үдэшлэг, нийтийн бүжиг, арга хэмжээг зохион байгуулах, явуулын номын сангаар үйлчлэх, үзвэр үйлчилгээгээр хангах, уулзалт, зөвлөгөөн, тэмцээн уралдаан зохион байгуулах зэргээр залуу малчдыг хөгжих, эвлэлдэн нэгдэх, мэдээллээр хангах цогц соён гэгээрлийн үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна.

Хүснэгт 12.3 Нийгэм-соёлын үйлчилгээнд хамрагдалт,
хувиар, хүйсээр.

Үйлчилгээ	Хүндрэлтэй		Хүндрэлгүй		Үйлчилгээ авч үзээгүй	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Үзвэр үзэх	53.9	54.7	44.6	44.6	1.6	0.6
Номын сангаар үйлчлүүлэх	53.3	53.6	37.4	35.1	9.3	11.3
Сонирхсон номоо худалдаж авах	56.6	60.8	39.8	34.5	3.6	4.8
Үдэшлэг, нийтийн бүжиг, арга хэмжээнд оролцох	53.4	52.9	45.5	45.2	1	1.8
Халуун усанд орох	59.9	65.2	39.9	34.5	0.2	0.3

Судлагдсан залуу малчдын 70.7 хувь нь утсыг байнга хэрэглэж байгаа бол 51.8 хувь нь интернетийг хааяа хэрэглэж байгаагаар илэрхийлсэн бөгөөд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн утас, интернетийн хэрэглээнд хүйсийн ялгаа ажиглагдсангүй.

ДҮГНЭЛТ

- Залуу малчин эмэгтэйчүүдийн бүрэн дунд (61.3 хувь) болон дээд (15.5 хувь) боловсролын түвшин дээшилж, хөвгүүдийн боловсролын түвшин буурах (57.3 хувь) хандлагатай байгаа нь хөвгүүд сургуульд суухгүй ч ажил амьдралаа зохицуулаад явчихна, охиноо боловсролтой болгоно гэсэн эцэг эхчүүдийн жендэрийн хэвшмэл ойлголттой шууд холбоотой байна.
- Судлагдсан залуу малчид ковид-19 цар тахлын үед хүүхдээ цахим, теле хичээлд хамруулахад хүндрэлтэй, хүүхдээ сургахын тулд залуу малчин гэр бүл хоёр тусдаа амьдрах, хүүхдээ байнга эргэж анхаарал халамж тавьж чадахгүй, хүүхдээ цэцэрлэгт хамруулж чаддаггүй зэрэг бэрхшээл боловсролын үйлчилгээг авахад тулгарч байна. Мөн орон нутгийн сургуульд багш их солигддог, хүүхэд сургах арга зүй тааруу багш нар олширсон, дотуур байрны үйлчилгээ тааруу, сүлжээгүй муу учраас хүүхдүүд цахимаар хичээл үзэж судлахад хүндрэлтэй байна.
- Аймаг, суманд айлд сууж байгаа хүүхдүүдийн хичээл сурлага, хүмүүжил муудах, хичээлээс хоцрох, таслахаас гадна эцэг эхийн хайр халамжаар дутагдаж, хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын асуудал хөндөгдсөөр байна.
- Дотуур байранд амьдарч буй хүүхдүүд хангалттай, эрүүл аюулгүй хоол хүнс авч чадахгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдаагүй хэвээрээ, хүүхдүүд нэг нэгнийгээ дээрэлхэх, дарамтлах, багш хүүхдийг дарамтлах явдал гарч байгаагийн улмаас эцэг эхчүүд хүүхдүүдээ дотуур байранд бус айлд байлгах эсвэл өөрсдөө 2 тусдаа амьдрахыг илүүд үзэж байна.
- Эрэгтэй залуу малчдыг бодвол эмэгтэй залуу малчдын 65.2 хувь халуун усанд ороход, 60.8 хувь нь сонирхсон номоо худалдаж авахад хүндрэлтэй байдаг. Залуу эмэгтэй малчдын 11.3 хувь нь номын сангаар үйлчлүүлж үзээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

1. Эцэг эхчүүдэд хөвгүүдийн боловсрол эзэмшилтэд ялгаварлан гадуурхалт үүсгэхгүй байх, хөвгүүдийг боловсрол эзэмшихэд анхаарах сургалт сурталчилгааг явуулах
2. Айлд амьдардаг хүүхдийн бүртгэл судалгаа гаргаж тэдний онцлог нөхцөл байдалд чиглэсэн бодлого шийдвэрийг гаргах
3. Дотуур байранд тавигдах стандарт шаардлагыг бий болгох, мөрдүүлэх, дотуур байранд дасан зохицох орчныг бүрдүүлэх (Увс аймгийн Бөхмөрөн сумын сайн туршлагыг бусад аймаг, сумдад нэвтрүүлэх, хөгжүүлэх)
4. Бага ангийн хүүхдүүдийн онцлог хэрэгцээнд тулгуурласан өрөө, танхимыг тохижуулах, хүүхэд хамгааллын орчин нөхцөлийг бий болгох
5. Насан туршийн боловсролын агуулгад малчдад чиглэсэн сургалтын хөтөлбөр орсон боловч эрэгтэй, эмэгтэй залуу малчдын хэрэгцээнд нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, багш нарыг бэлтгэх, насан туршийн боловсролын хөтөлбөрт хамрагдсан хүмүүсийн мэдээллийг хүйс, нас, ажил мэргэжлээр нь ангилан бүртгэл, нэгтгэлийг сайжруулах
6. Бага болон өсвөр насны охид, хөвгүүдийн эрүүл мэнд, боловсрол, эрүүл амьдралын зан үйлд суралцах талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах
7. Залуу малчдад чиглэсэн нийгэм-соёлын ялангуяа эрүүл ахуйн үйлчилгээг (халуун усанд орох) авах нөхцөл боломжийг бүрдүүлэх, сайжруулах

Бүлэг 13.

ЗАЛУУ МАЛЧДЫГ БЭЛТГЭХ АСУУДАЛД

Монгол малчин үндэсний хөтөлбөрөөр “Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх, залуу малчдын халааг бэлтгэх зорилтын хүрээнд “залуу малчид, гэрээт болон туслах малчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, туршлага судлуулах” арга хэмжээг төлөвлөжээ³⁶. ХХААХҮ-ийн салбарын жендэрийн талаар баримтлах бодлого (2018-2025)-ын зорилт 2-ын хүрээнд салбарын хүний нөөцийг жендэрийн мэдрэмжтэй бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх, малчин гэр бүлийн хөгжлийг дэмжих, залгамж халааг бэлтгэх, нийгэм, соёл, эдийн засгийн цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхийг төлөвлөжээ. Эдгээр арга хэмжээний хүрээнд залуу эрэгтэй, эмэгтэй, малчдыг бэлтгэх, чадавхжуулахад чиглэсэн дараах үйл ажиллагааг төлөвлөсөн байна. Үүнд:

1. Орон нутгийн сонгосон МСҮТ-үүдэд малчин эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн, аж ахуйгаа уур амьсгалын өөрчлөлт, даяаршлын эрин үед хөтлөн явуулах ур чадвар олгох сургалтын хөтөлбөрийг орон нутгийн онцлогт нийцсэн байдлаар туршин хэрэгжүүлэх;
2. Малчин эмэгтэйчүүдийн өрхийн, багийн түвшин дэх үйлдвэрлэлийг бага оврын тоног төхөөрөмжөөр дэмжих хамтын ажиллагааг хөгжүүлэх;
3. Малчин эмэгтэйчүүдэд сүү, цагаан идээ боловсруулах, арьс шир, ноос ноолуурын түүхий эдийг бэлтгэх ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтын тогтолцоог орон нутагт бий болгох төсөл хэрэгжүүлэх зэрэг болно³⁷

Хоёрдугаар бүлэгт улсын хэмжээнд болон судлагдсан аймгуудад залуу малчдын тоо буурч, малчдын залгамж халаа дутагдалтай болж байгаа тухай өгүүлсэн. Ганцаарчилсан ярилцлагад оролцсон залуусыг малчин болох сонголтод нөлөөлөгч хүчин зүйлсийг өөрсдийнх нь үзэл бодлоор тодруулсан. Тэдний үзсэнээр, МАА-н үр шим, ашиг орлого нэмэгдэж, дэд бүтэц, ахуй нөхцөл сайжирснаар малчин болох сонирхол нэмэгдэх бол бэлчээрийн хомсдол, ган зуднаар малаа алдах, цөөн мал нь амьжиргааны баталгаа болж чадахгүй байх, эдгээрт чиглэсэн дэмжлэг сул байгаа тохиолдолд малчин болох сонирхол буурдаг байна. Түүнчлэн, залуу малчдын бууралт нь малчдын дунд боловсрол эзэмших, өөр мэргэжилтэй болох, тэр дундаа охидынхоо боловсролыг дэмжих сонирхол нэмэгдэж байгаатай холбоотой.

Матриц 13.1 Малчин болоход нөлөөлж буй хүчин зүйлс, татах боломж, малчдын хариултаар.

Татагч хүчин зүйлс	Түлхэгч хүчин зүйлс
<ul style="list-style-type: none"> • МАА-аас орох ашиг орлогын өсөлт • Дэд бүтэц, ахуй нөхцөлийн өөрчлөлт (утас, гэрэл, гэр ахуйн хэрэгсэл г.м) • Тайван, амгалан амьдрал • Цэвэр агаар, байгаль орчин, эрүүл хүнс • Багаасаа малд татагдах, сонирхох • Малчны удмаа дагах 	<p>Хувийн:</p> <ul style="list-style-type: none"> • Суурин газар амьдрах сонирхол • Боловсрол, мэргэжил эзэмших сонирхол • Малчдын хүүхдүүдээ боловсролтой болгох сонирхол • Хүнд хүчир, “малын боол” болдог гэж үзэх хандлага <p>Хувийн бус:</p> <ul style="list-style-type: none"> • Бэлчээрийн хомсдол • Дараалсан ган, зуд • Цөөн малтай, амьжиргаа доогуур байдал • Залуу малчны дэмжлэг сул байдал

36 МУЗГ. 2020. Монгол малчин үндэсний хөтөлбөр. Улаанбаатар

37 ХХААХҮЯ. 2018. ХХААХҮ-ийн салбарын жендэрийн талаар баримтлах бодлого (2018-2025). Улаанбаатар

Залуусыг татах боломжууд:

- Малын үр шим, ашгийг сайтар таниулах
- Малжуулах хөтөлбөрийг өргөжүүлэх
- Мал маллангаа суралцах алсын зайн хөтөлбөр хэрэгжүүлэх
- Мал малласнаар өрхийн болон аж ахуйгаа сайжруулах, улмаар малын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, борлуулах үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх боломжтой болох зэрэг малчин мэргэжлийн ач холбогдол, хэрэгцээний талаар илүү сурталчлан таниулах
- Зуднаар мал алдсан хүмүүст малтай болоход нь дэмжлэг үзүүлэх
- ХААИС-ийн салбарыг аймаг бүрт байгуулах
- Малчнаар мэргэшүүлэх сургалт зохион байгуулах
- Залуу малчныг урамшуулах

Эх сурвалж: Залуу малчидтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс.

Нэг талаас мал маллахдаа тооны араас хөөцөлддөггүй уламжлалт арга ухаан, нөгөө талаас шинжлэх ухаан, технологид суурилсан чадамжийн хомсдол малчдын, тэр дундаа залуу малчдын дунд нийтлэг ажиглагдах болжээ. Наад захын жишээ дурдахад, Архангай, Баянхонгор, Говь-Алтай аймгийн зарим сумдыг сонгон судлахад хээлтүүлэгч мал (хуц, ухна)-ын хангамж 50-75 хувиар дутуу, байгаа хуц, ухны 75-87 хувь нь стандартын шаардлага хангахгүй байгааг тогтоожээ³⁸. Энэхүү мэдээлэл мал маллах арга ухаан, мал зүй, малын эрүүл мэндийн талаас залуу малчдыг тусгайлан бэлтгэх шаардлага буйг нотолж байна (Шигтгээ 13.1 харна уу).


ШИГТГЭЭ 13.1

Малын чанар, үр шимийг нэмэгдүүлэх, хадгалах зорилгоор шаардлага хангахуйц хээлтүүлэгч сонгож ирсэн уламжлалт мэдлэг алдагдсан. Шинжлэх ухааны мэдлэг ойлголт сул. Насанд хүрээгүй малаар хээлтүүлэгч тавих, хангайн малаар говьд хээлтүүлэгчээр сонгох, хээлтэгчийн тоонд тохирсон хээлтүүлэгчийг сонгох зэрэг алдаа их гаргах болсон. Мал хувийн өмч болохоор шууд оролцоод байж чаддаггүй. Бие биенээсээ сургаар, ажгаар өөрсдөө шийддэг.

Өвөрхангай аймаг, ХАА-н мэргэжилтэн, эмэгтэй.

Залуу малчдыг чадавхжуулах сургалт, уулзалт, хэлэлцүүлэг хэр зэрэг зохион байгуулдаг талаар тодруулахад судалгаанд оролцогчдын 57 хувь нь огт зохион байгуулдаггүй, 40 хувь нь хааяа зохион байгуулдаг, 4 хувь нь байнга зохион байгуулдаг гэж хариулжээ. Үүнд хүйсийн ялгаа бараг ажиглагдсангүй (Зураг 13.1). Ганцаарчилсан ярилцлагын мэдээлэл ч сум орон нутгаас зохион байгуулсан ажилд залуус тааруухан хамрагддаг болохыг давхар нотолж байна.

Зураг 13.1 Малчдыг чадавхжуулах арга хэмжээг зохион байгуулдаг байдал, залуу малчдын хариултаар, хүйсээр.



38 (<https://www.greenmongolia.mn/post/62895>) - Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо

Судалгаанд хамрагдсан залуу малчдын 68 хувь нь залуу малчдыг урамшуулах, 21 хувь нь мал маллах арга ухааны сургалтууд зохион байгуулах, 15 хувь нь малчдын туршлага судлах аялал, уулзалт, өдөрлөгийг тогтмол зохион байгуулах, 12 хувь нь зөвлөх малчны хөтөлбөр хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг илэрхийлжээ. Харин сургалтын байгууллагуудаар малчныг бэлтгэх, богино хугацааны сургалт, дамжаа хичээллүүлэх гэсэн хариултыг 9 хувь нь сонгон хариулсан байна. Үүнд хүйсийн ялгаа тун бага түвшинд ажиглагдав.

Зураг 13.2 Залуу малчин бэлтгэх чиглэлд хэрэгжүүлэх шаардлагатай зүйлс, малчдын хариултаар, хүйсээр.



Мал маллах арга ухаан, малын эрүүл мэндийг хамгаалах, бэлчээр ашиглах, ашиг орлогоо нэмэгдүүлэх мэдлэгийг хаанаас хэрхэн суралцдаг, ямар бэрхшээлүүд тулгардаг, холбогдох сургалтад хамрагдсан эсэхийг судалгаагаар тодруулав. Залуу малчид мал маллах арга ухаан, ур чадварт өвөө, эмээ, эцэг эх, ахмад үеэ харж, практик нөхцөлд суралцаж байна. Ганцаарчилсан ярилцлагад оролцсон эрэгтэй, эмэгтэй залуучуудын 1-2-оос бусад нь “бага наснаасаа сурсан зүйл тул чадахгүй, мэдэхгүйн бэрхшээл гардаггүй” хэмээн өөрийн чадамжийн түвшиндээ “сэтгэл хангалуун” байна. Энэхүү хандлага асуулгын судалгаанд оролцогчдын хувьд түгээмэл ажиглагдаж буйг сургалтын мэргэжлийн байгууллагаар малчин бэлтгэхийг 9-хэн хувь нь дэмжиж байгаагаас харж болно. Өөрөөр хэлбэл, “малчин”-ыг мэргэжил, зохих чадамжийг эзэмшихэд сургалт чухал гэж үзэх хандлага хомс байна. Өвөрхангай айм-гийн Политехникийн коллежид “Малчин” бэлтгэх хөтөлбөр 2013 оноос эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд жилд дунджаар 20-25 суралцагч суралцдаг аж. Хичээлийн таслалт, завсардалт малчин залуусын дунд элбэг байх тул сумдад нь очиж сургалтыг зохион байгуулж, 70 хувьд нь хамрагдсан тохиолдолд сургалтын тэтгэлэг олгодог байна.

Мөн МАА эрхлэхийг бизнес эрхлэхтэй дүйлгэн ойлгох хандлага Сэлэнгэ аймгаас бусад нутгийн малчдад сул илрэв (Матриц 13.1). Зарим эрэгтэй малчдын хувьд малаа эмчлэх уламжлалт болон орчин үеийн арга, мал төллүүлэх үеийн хүндрэлийг шийдэх, отор нүүдэл хийх, МАА-н ашиг орлогоо нэмэгдүүлэх аргуудыг, харин цөөн тооны эмэгтэй малчдын хувьд малын түүхий эд, цагаан идээ боловсруулах, бүтээгдэхүүнээ борлуулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх талаар “мэдэхгүйн” хүндрэл бэрхшээл учирч байгаагаа хуваалцсан (Матриц 13.1).

Матриц 13.2 Мал маллах арга ухаан, малын эрүүл мэндийг хамгаалах, бэлчээр ашиглах, ашиг орлогоо нэмэгдүүлэх мэдлэгт суралцаж буй байдал.

Сум	Мал маллах	Бэлчээр ашиглах, бэлчээрийн ургамлын мэдлэг	Малын эрүүл мэнд	Бизнес эрхлэх
А. Хэнээс суралцдаг вэ?				
Эрэгтэй	Өвөө, эмээ Аав ээж Нутгийн малчид Ах эгч дүүс	өвөө, эмээ аав ээж	Мал эмнэлэг Аав ээж Өөрөө	Ашиг шим хүртэх уламжлалт сэтгэлгээгээр явж байгаа
Эмэгтэй	Аав ээж Бусад хүмүүс	өвөө, эмээ аав ээж	Малын эмч	
Б. Мэдэхгүй, чадахгүйгээс үүдсэн бэрхшээл				
Эрэгтэй	Төллүүлэх үеийн хүндрэл	Отор нүүдэл хийх	Малаа эмчлэх уламжлалт арга Мал эмчлэх	Тааруухан, малын тоогоо өсгөхийг чухалчлах
Эмэгтэй	Малын түүхий эд, цагаа идээгээ хэрхэн боловсруулах	-	-	Хэрхэн борлуулж, ашиг орлогоо нэмэгдүүлэх
В. Сургалт зохион байгуулагддаг уу?				
Эрэгтэй	- тором хяргах сургалт зохион байгуулагдсан	-	-	-
Эмэгтэй	-	-	-	-

ШИГТГЭЭ 13.2

Ер нь малчин болохыг хүмүүс “малын боол” боллоо гэж яриад байдаг. Мал маллана гэдэг ажил мэргэжил гэдэг талаас нь, илүү ашиг орлого олдгийг таниулчихвал хүмүүс арай өөрөөр харах байх даа. Малаа маллангаа суралцах алсын зайн сургалт байвал болж байна. Заавал Улаанбаатар хот, аймгийн төв рүү яваад байхгүй.

Сэлэнгэ аймаг, малчин, эрэгтэй.

Ухаан орсноосоо хойш л мал маллахыг харж суралцаж өссөн учраас мал маллах арга ухаанд мэдэхгүй, чадахгүй бэрхшээл гардаггүй.

Өмнөговь аймаг, Номгон сум, эрэгтэй малчны ярианаас.

Багадаа өвөө, эмээ дээрээ байсан. Ер нь хар багаасаа мал дээр байсан. Мэдэхгүй чадахгүйн бэрхшээл бага. Яахав, тугал гарахгүй болох гэх мэт мал төллөх цагаар л гарна даа. Манай өвөө, эмээ маань малчин, мал маллах талаар тэднээсээ суралцаж ирсэн. Мөн аав, ээж маань ч насаараа мал маллаж байна.

Сэлэнгэ аймаг, малчин, эмэгтэй.

Ахмад хүмүүсээсээ мал яаж услах, худаг усаа яаж хамгаалах энэ тэрийгээ асууж мэддэг. Мэдэхгүй чадахгүй байх бэрхшээл гардаг. Тэр болгоныг ахмад настай хүмүүсээсээ л асууж лавлана даа. Мал яаж эмчлэх үү гээд асуух юм гарна. Мал өвдөхөөр сумын малын эмчээс зөвлөгөө авна. Мал маллах нарийн ухаан, мэдлэг бага байна. Малаа бэлчээрт гаргах, услах, сааль бэлтгэх гээд ойр зуурын мэдлэгтэй байгаа. Сум орон нутгаас мал маллах, бэлчээр сонгох, орлого нэмэгдүүлэх чиглэлээр огт ажил зохион байгуулдаггүй.

Увс аймаг, малчин, эмэгтэй.

Эрэгтэй, эмэгтэй залуу малчидтай ярилцахад чадавхжуулах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг орон нутгаас хэрэгжүүлдэг эсэх, ямар санал байгааг тодрууллаа. Малжуулах хөтөлбөрийг өөрчилж сайжруулах, залуучуудтай зөвлөлдөх, зохион байгуулалтад оруулах гэсэн саналуудыг хамгийн олон оролцогчид илэрхийлсэн. Залуу эрэгтэй, эмэгтэй малчдын яриагаар хувь хүний амьдрах ухааны болоод амьжиргаа, бизнесээ хөгжүүлэхэд туслах, мэдээллээр хангах сургалтууд тун ховор зохион байгуулагддаг бөгөөд ийм төрлийн сургалтад хамрагдах хэрэгцээ залуусын дунд байна (матриц 13.3).

Матриц 13.3 Чадавхжуулах арга хэмжээ, хэрэгжүүлдэг эсэх, санал.

Арга хэмжээнүүд	Хэрэгжүүлдэг эсэх	Санал
1. Малжуулах хөтөлбөр	+	Хамруулах хүрээг тэлэх, мөнгөн дүнг нэмэх, малгүй хүмүүст өгдөггүйг өөрчлөх, амьжиргааны түвшинг харгалзан заримд нь тусламж хэлбэрээр олгох
2. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох	-	Эрчимжсэн МАА-н талаар мэдээлэл өгөх, бизнес эрхлэх, мал эмчлэх сургалт зохион байгуулах
3. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	+ мэдэхгүй	Бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох, ноос, ноолуурын болон МАА-н түүхий эд боловсруулах цэг байгуулах нэмэгдүүлэх.
4. Малчдын бүлэг нөхөрлөл, хоршоог дэмжих	- сайн ажилладаггүй	Залуу малчдыг зохион байгуулалтад оруулах
5. Утсанд цаг уур, аюултай нөхцөл байдлын мэдээлэл ирүүлэх	+ зарим газар утсаар ярьж мэдээлэл өгдөг	
6. Насан туршийн боловсролын үйлчилгээнд хамруулах	-	Сургалтууд зохион байгуулах
7. Эрүүл мэндийн боловсролын сургалт, зөвлөгөөнд хамруулах	- Эмэгтэйчүүдийн эмчээсээ зөвлөгөө авдаг	- сургалт зохион байгуулдаггүй, ердөө сонсож байгаагүй тул зохион байгуулах
8. Сүүн бүтээгдэхүүн боловсруулах (өндөр үнэтэй бяслаг г.м)	- Зарим суманд зохион байгуулдаг	Сургалт зохион байгуулах
9. Эсгий бүтээгдэхүүн, оёдол, гар урлал хөгжүүлэх	-	
10. Хөдөлмөрийн, онцгой нөхцөлийн аюулгүй үйл ажиллагаа	-	Сургалт зохион байгуулах хэрэгтэй
11. Дээс, сур, эсгий, ногт, чөдөр г.м уламжлалт хэрэгсэл хийх	-	
12. Бусад	- Залуу малчдыг соёлжуулах - Залуу малчдын нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх - Нийгмийн халамжийн хөтөлбөрт хамруулан дэмжих - Малын хөлийн татвар авахгүй байх - Төсөл хөтөлбөрийг нэмэгдүүлэх, мэдээллээр хангах	

Аймаг, сумдын орон нутгийн байгууллагуудаас залуу малчныг бэлтгэх, залуу халаа үеийг бэлтгэхэд тодорхой хэмжээгээр анхаарч ажиллаж байна. Бүх аймагт малжуулах хөтөлбөр хэрэгжиж байгаа гэж хариулсан байна. Тун цөөхөн хүн санхүүжилтгүйн улмаас түр зогссон гэжээ. Бүх аймаг сумдад сургалт, чуулган, зөвлөгөөн, хөрш орнуудад туршлага судлуулах аялал зохион байгуулах, тодорхой зорилго бүхий сургалтыг зохион байгуулж байна. Тухайн орон нутгийн онцлог хэрэгцээнээс улбаалан, бэлчээр өнжөөх, хадлан тэжээл тарих газар олгох, орон нутгийн удирдлага хооронд гэрээ байгуулан отор нүүдэл хийх боломжийг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна. Залуу малчин дэд хөтөлбөрийг хоёр аймаг боловсруулан хэрэгжүүлээд байна. Аймгийн ХХААГ-ын мэргэжилтний ярианаас үзэхэд хөтөлбөр гаргалаа ч санхүүжилтын эх үүсвэр, хэмжээг тодорхой болгоогүйгээс хэрэгжилт тааруу байгааг анхаарах шаардлагатай байна.

Залуу малчдын дуу хоолойг сонсох, зөвлөлдөх, чадавхжуулах сургалт зохион байгуулдаг болох нь ХАА-н салбарын мэргэжилтнүүдийн ярианаас харагдаж байгаа ч судалгаанд оролцогчдын хувьд зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцсон нь тааруу байв. Иймд нэг талаас сургалтын хүртээмжийг сайжруулах, нөгөө талаас сургалтад хамрагдахын ач холбогдол, хэрэгцээг таниулах шаардлагатай байна. Мөн аймгуудад хэрэгжүүлж буй арга хэмжээнээс харахад “эмэгтэй малчин”-ыг бэлтгэх, тоог нэмэгдүүлэхэд тухайлан чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байна.

Матриц 13.4 Залуу малчдад зориулан хэрэгжүүлж буй арга хэмжээ

Аймгийн нэр	Хэрэгжүүлж буй арга хэмжээний товчоон
Дорнод	<p>Малжуулах төсөлд хамруулах. Энэ хүрээнд малчдын сургалт, туршлага солилцох уулзалт зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулдаг.</p> <p>Малчдын сургалтыг ТББ-р дамжуулан зохион байгуулах</p> <p>Орон нутгийн сангаас малын хашаа, хороо, худаг ус гаргахад нь дэмжлэг үзүүлэх.</p> <p>Залуу малчид, төлчин эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулах</p> <p>Залуу малчдыг бусад аймаг, сум, хил залгаа хөрш орны мал аж ахуйн салбараас туршлага судлуулах,</p> <p>Эрүүл мэнд, мал эмнэлэг, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх,</p> <p>Залуу малчин 2019 зөвлөгөөн зохион байгуулсан</p>
Өвөрхангай	<p>2016-2020 хооронд Залуу малчныг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлсэн.</p> <p>Залуу малчдын дуу хоолойг сонсох үүднээс чуулга уулзалтууд, өдөрлөгийг хүйсийн тэнцвэртэйгээр 2 жил тутам зохион байгуулсан.</p> <p>Залуус туршлага судлах аялалд явуулдаг байсан</p> <p>Малжуулах болон гэрээт малчин хөтөлбөр хэрэгжүүлдэг</p> <p>Политехникийн коллежид малчин бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлдэг.</p>
Өмнөговь	<p>“Чинээлэг малчин” хөтөлбөр хэрэгжүүлж байна.</p> <p>Малчны өдрийг жил бүрийн 9 сарын сүүлийн 7 хоногийн баасан, бямба гарагт тэмдэглэж өнгөрүүлдэг.</p> <p>Говь фестиваль зохион байгуулж, малчдын боловсруулсан цагаан идээ, ногоо, түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүн, үзэсгэлэн худалдаа, сургалт, зөвлөгөөнийг 2 өдрийн турш зохион байгуулдаг</p> <p>Бэлчээр сэргээх үүднээс мод тарьдаг болсон</p> <p>Янз бүрийн сургалтууд зохион байгуулдаг.</p> <p>Залуу малчдын эрүүл мэндийг дэмжих сургалт зохион байгуулдаг.</p> <p>Гадаад дотоод туршлага судлах аялал зохион байгуулдаг</p> <p>Аймгийн, сумын засаг дарга нар, бусад аймгийн засаг дарга нартай тохиролцож, отор нүүдлийн асуудлыг шийдвэрлэж байна.</p>

Сэлэнгэ	Нээлттэй хаалга, сургалт, ухуулга зохион байгуулдаг Цагдаа, хамтарсан баг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулдаг. Малжуулах хөтөлбөр хэрэгжүүлдэг Залуу малчдад эрчимжсэн МАА эрхлэх сургалт зохион байгуулах 2018 оноос сумын ИТХ-аас тогтоол гарч малчдын өвөлжөөний газар ногоон тэжээл тариулахаар 1-5 га 15 жилээр эзэмшүүлдэг.
Увс	2021 оноос Шинэ хөдөө төсөл хэрэгжүүлнэ. Малжуулах хөтөлбөрт хамруулдаг. Жил бүр СЗД-ын захирамжаар бэлчээр өнжөөдөг. Хадлан тэжээлийн нөхөрлөл, архидалт, малын хулгайгаас сэргийлэх зорилгоор залуу малчдын холбоо байгуулсан
Ховд	“Залуу малчин” аймгийн дэд хөтөлбөр боловсруулан батлуулан хэрэгжүүлж байна. Ногоон алт төсөлтэй хамтран залуучуудын боловсрол болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломжуудыг судлан дэмжиж байна. Малжуулах төсөлд хамруулж байна.

ДҮГНЭЛТ

- Нэг талаас залуу малчдын тоо, тэр дундаа эмэгтэй малчдын тоо буурч байгаа, нөгөө талаас мал аж ахуй эрхлэх уламжлалт мэдлэг болон шинжлэх ухаан, технологийг суурилсан чадамжийн хомсдол салбарын тулгамдсан асуудал болоод байна. “Малчин” мэргэжлийн зохих чадамжийг эзэмшихэд сургалт чухал гэж үзэх хандлага, МАА эрхлэхийг бизнес эрхлэхтэй дүйлгэн ойлгох хандлага залуу малчдын дунд дутмаг байна.
- Аймаг, сумдын орон нутгийн байгууллагуудаас залуу малчныг бэлтгэх, залуу халаа үеийг бэлтгэх чиглэлд ажиллаж байгаа ч санхүүжилтын эх үүсвэр, хэмжээг тодорхой болгоогүйгээс хэрэгжилт төдийлөн үр дүнтэй биш байна. Аймаг, сумдын зүгээс залуу малчдыг чадавхжуулах зорилго бүхий сургалт, аян, чуулган зохион байгуулдаг ч хүртээмж сул байгаа тул нэг талаас сургалтын хүртээмжийг сайжруулах үүднээс хувилбарт хэлбэрүүдээр хүргэх, нөгөө талаас сургалтад хамрагдахын ач холбогдол, хэрэгцээг таниулах шаардлагатай байна.
- Эмэгтэй малчинг бэлтгэх, чадавхжуулах, тоог нь нэмэгдүүлэхэд чиглэсэн тухайлсан арга хэмжээг бараг хэрэгжүүлэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

1. Орчин цагийн “Малчин” мал маллагааны уламжлалт болон орчин үеийн шинжлэх ухаан, технологийн чадамжтай бизнесменийг бэлтгэх, хөгжүүлэх зорилгоор богино хугацааны хөтөлбөрийг орон нутгийн МСҮТ, насан туршийн боловсролын төвд нэвтрүүлэн танхимын болон зайны хэлбэрээр суралцах боломжийг бүрдүүлэх. Өвөрхангай Политехникийн коллежийн малчин бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтийн сургамжаас суралцан, сайн туршлагыг бусад орон нутагт түгээх.
2. Залуу эмэгтэй малчинг бэлтгэх, чадавхжуулах, тоог нь нэмэгдүүлэхэд чиглэсэн тухайлсан арга хэмжээг тэдний боловсрол эзэмших хэрэгцээтэй нь уялдуулан дэмжих. Жишээ нь, ХААИС-д элсэн суралцахад нь дэмжлэг үзүүлэх г.м хэлбэрээр.

3. Залуу малчдад “малч ухаан, мал маллах уламжлалт соёлыг төлөвшүүлэх”-д ахмад малчин зөвлөх үйлчилгээг бий болгох.
4. Аймаг, нийслэл, сумын хөдөлмөр эрхлээгүй охид, залуусыг МСҮТ, сургалтын төвд малчнаар бэлтгэн, ажилтай болоход нь дэмжлэг үзүүлж, энэ хүрээнд хэрэгжиж буй “Гэрээт малчин” хөтөлбөрийг ажил олгогч, ажилтан хоёуланд ашигтай байхаар зарим өөрчлөлт оруулан хэрэгжүүлэх, мэдээллийг түгээх зэрэг болно.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт	Зөвлөмж
<p>Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал, үйл ажиллагаанд хийсэн жендерийн дүн шинжилгээний үр дүнд бодлого, арга хэмжээний талаас анхаарвал зохих дараах асуудлууд тулгамдаж байгааг илрүүлээ.</p>	<p>Залуу эрэгтэй, эмэгтэй малчдын тоог нэмэгдүүлж, тэдэнд тулгамдсан асуудлыг шийдэхэд салбар хоорондын хамтын ажиллагаа, зохицуулалт үгүйлэгдэж байгаа тул малчдын асуудлаарх зөвлөлийг байгуулан ажиллах. Тус зөвлөлийг ХХААХҮЯ-аас санаачлан, салбар бүрийн болоод ИНБ-ын төлөөлөл байхаар байгуулах нь зүйтэй байна</p>
<p>Нэг. Малчдын залуу халаа үеийг бэлтгэх, хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх, чадваржуулах хүрээнд:</p> <p>- Бүх баримт 15-34 насны залуу малчдын, тэр дундаа эмэгтэй малчдын тоо буурч байгааг нотолж байна.</p> <p>- Малчдын залуу халаа үеийг бэлтгэх талаар ХАА-н салбарын холбогдох бодлогын баримт бичгүүдэд тусгагдсаны зэрэгцээ малжуулах хөтөлбөр, гэрээт малчин хөтөлбөр, МСҮТ-д мэргэжлийн хөтөлбөр зэргийг хэрэгжүүлж байна. Мөн аймгийн түвшинд залуу малчдыг урамшуулах, дэмжихэд чиглэсэн дэд хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлж байгаа ч санхүүжилтын эх үүсвэр, хэмжээг тодорхойлоогүйн улмаас хүртээмж болон чанарыг ахиулах шаардлага дэвшигдэж байна.</p>	<p>- Салбарын яам, орон нутгийн удирдлагын түвшинд залуу малчин эрэгтэй, эмэгтэйчүүдийн хэрэгцээнд тулгуурлан бэлтгэх, урамшуулах, дэмжихэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний зардлын эх үүсвэр, хэмжээг тодорхой болгож, нийгэм-эдийн засгийн байр сууриар ялгаатай залуус бүрийг тэгш хамруулахад чиглэх. Үүнд ямар бүлгийн оролцоо хангагдаж байгаа, ямар бүлгийн орхигдож байгаа мэдээллийг нягтлан цуглуулж, шинжилгээ хийсний үндсэн дээр тэгш хамруулах стратегийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүний тулд салбар, орон нутгийн түвшинд малчдад хамаарах мэдээллийг хүйс, нийгмийн байдлаар ангилан цуглуулдаг, шинжилгээ хийдэг, үр дүнг бодлого төлөвлөлт, арга хэмжээнд тусган хэрэгжүүлдэг чадавх бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.</p> <p>- Залуу эмэгтэй малчинг бэлтгэх, чадавхжуулах, тоог нь нэмэгдүүлэхэд чиглэсэн тухайлсан арга хэмжээг тэдний боловсрол эзэмших хэрэгцээтэй нь уялдуулан дэмжих. Жишээ нь, ХААИС, ХАА-н коллеж, МСҮТ-д элсэн суралцахад нь дэмжлэг үзүүлэх г.м хэлбэрээр.</p>
<p>- Малчдын охид хот суурин газарт сургуульд сурах зорилгоор шилжиж, дийлэнх нь буцаж ирэлгүйгээр суурьшсанаар хөдөөд гэрлэх насны залуу эмэгтэйчүүдийн тоо буурч залуу малчин эрэгтэйчүүдийн гэрлэх боломж хумигдаж, аажимдаа малчин залуучуудын гэрлэх нас хойшилж, улмаар малчин хүн ам буурахад хүргэдэг төлөв харагдаж байна. Гэвч залуу эмэгтэй малчдын тоог нэмэгдүүлэхэд тусгайлан анхаарсан арга хэмжээг бараг хэрэгжүүлэхгүй байна.</p>	<p>- Малчин мэргэжлийг сурталчлах, өндөр ашиг шимтэй мал маллаж, амжилтад хүрч байгаа эрэгтэй, эмэгтэй залуу малчдыг нийгэмд таниулах зорилго бүхий олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулахын зэрэгцээ залуус, тэр дундаа эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, байр суурийг ахиулах, ахуй, нийгэм-соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зэрэг алслагдмал амьдралаас үүдэлтэй зөрүүг (дэд бүтэц, цэвэр ус, халуун ус, цахилгаан, интернет сүлжээ, нийгэм-соёлын үйлчилгээ авах боломж г.м) багасгахаар салбар бүр зохих арга хэмжээг хэрэгжүүлэх.</p>

<p>- Залуу малчдын тэн хагас нь цаашид уламжлалт бэлчээрийн МАА эрхлэхээр байгаа ч нөгөө хагас нь эрчимжсэн МАА-г эрхлэх сонирхол байна. Гэхдээ судалгаанд хамрагдсан эрэгтэй залуу малчдын дунд малаа өсгөх замаар амьжиргаагаа дээшлүүлэх, улмаар мянгат буюу сайн малчин болохыг, эмэгтэй малчдын хувьд малын тоо толгойгоо цөөлөх, чанаржуулах, хүүхдүүддээ өндөр боловсрол эзэмшүүлэхийг хүсэж мөрөөдөх хандлага түлхүү илэрлээ.</p> <p>- Мөн аль алинд нь малынхаа тоо толгойг өсгөлгүйгээр ашиг, үр шимийг нэмэгдүүлэх арга замуудын талаар мэдлэг, үр чадвараа ахиулах хүсэл сонирхол дутмаг, энэ чиглэлийн арга хэмжээ хангалтгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.</p> <p>- Тэд "Малчин" мэргэжлийн зохих чадамжийг эзэмшихэд сургалт чухал гэж үздэггүй бөгөөд МАА эрхлэхийг бизнес эрхлэхтэй дүйлгэн ойлгох хандлага залуу малчдын дунд дутмаг байгаа тул мал аж ахуй эрхлэх уламжлалт мэдлэг болон шинжлэх ухаан, технологид суурилсан мал маллагаа хийгээд бизнес эрхлэх чадамжийн хомсдол салбарын тулгамдсан асуудал болоод байна.</p>	<p>- "Гэрээт малчин" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, ажил олгогч, ажилтан хоёуланд ашигтай байхаар зарим өөрчлөлт оруулан хэрэгжүүлэх, мэдээллийг түгээх зэрэг болно.</p> <p>- Орчин цагийн "Малчин" малмаллагааны уламжлалт (Монгол уламжлалт соёлын тээгч) болон орчин үеийн шинжлэх ухаан, технологийн чадамжтай бизнесменийг бэлтгэх, хөгжүүлэх зорилгоор ХХААХҮЯ-аас боловсруулаад байгаа богино хугацааны хөтөлбөрийг орон нутгийн МСҮТ, насан туршийн боловсролын төвд нэвтрүүлэн танхимын болон зайны хэлбэрээр суралцах боломжийг бүрдүүлэх.</p> <p>- Мал аж ахуйн бизнес эрхлэхэд шаардлагатай чадамжийг эзэмшихэд "сургалт" чухал гэх хандлагыг төлөвшүүлэхэд сум, багийн удирдлага тухайлан анхаарч, мэргэжлийн зөвлөх үйлчилгээг хүргэх чиглэлд хувийн хэвшил, ИНБ-тай хамтран ажиллах.</p> <p>- ИНБ-аас (Хил хязгааргүй алхам ТББ г.м) нэвтрүүлэн ашиглаж буй "Мэргэн бөөдий" апп-ыг малчдыг чадавхжуулах, мэдээллээр хангахад ашиглах.</p>
<p>Хоёр. Залуу эрэгтэй, эмэгтэй малчдын амьжиргааг дээшлүүлэх чиглэлд:</p> <p>- Судалгаанд хамрагдсан залуу малчин өрх жилд дунджаар 11,299,118 төгрөгийн орлого олж байгаа бөгөөд үүний 57 хувийг МАА-аас, 43 хувийг МАА-н бус үйл ажиллагаанаас олж байна. Судалгаанд хамрагдсан залуу малчид дунджаар 2 эх үүсвэрээс орлого олж байгаа бөгөөд орлогын эх үүсвэрт мал аж ахуй, хүүхдийн мөнгө, нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмж, шилжүүлэг, цалингийн орлого голлох хэсгийг бүрдүүлж байна.</p> <p>- Өрхийн орлогын эх үүсвэрийн тоо болон хэмжээний хувьд эрэгтэй малчид эмэгтэйчүүдээс илүү байна. Мөн МАА-н зэрэгцээ газар тариалан, хүнсний ногоо, жимсгэнэ зэргийг нэмж эрхэлснээр эмэгтэйчүүдийн орлого нэмэгдэх хандлага ажиглагдав.</p> <p>- Залуу малчдын орлогын бүтцэд ноолуур, мах, мал, төл зарах нь тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг учраас ямааны тоо толгойг өсгөхийг илүүд үзэж байна.</p> <p>- Судалгаанд хамрагдсан залуу малчдын хариултаас үзвэл өрхийн орлогыг бүрдүүлэхэд гэр бүлийн гишүүдийн бүгдийнх нь оролцоо өндөр гэх хариулт хамгийн их хувийг эзэлж байгаа ч, эмэгтэйтэй харьцуулахад эрэгтэй гишүүнийг орлогын бүрдүүлэлтэд түлхүү үүрэг гүйцэтгэдэг гэж үзэх хандлага илэрлээ.</p>	<p>- МАА-аас авах үр шимийг нэмэгдүүлэх, тухайлбал сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, арьс шир, ноос ашиглан бүтээх бүтээгдэхүүний үйлдвэрлэх үр чадварт суралцуулах замаар орлогын бүтцэд өөрчлөлт оруулах, борлуулалтын хүрээнд бүлэг, хоршоонд нэгдэхийг тууштай дэмжиж ажиллах замаар орлогын эх үүсвэр, хэмжээг нэмэгдүүлэхэд бүх түвшинд бүхий л оролцогчид анхаарч ажиллах. Үүнд шаардагдах техник хэрэгсэлд хөрөнгө оруулахад нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p> <p>- Түүнчлэн, МАА-н зэрэгцээгээр газар тариалан, хүнсний ногоо, жимсгэнэ зэргийг нэмж эрхлэх боломжийг бүрдүүлэх, энэ бүгд нь малын тоо толгойг хязгаарлан, уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ болохын хамт эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд чадавхжих нөхцөл бүрдүүлэх юм. Үүнд хөнгөлөлттэй зээлийн болон техник арга зүйн дэмжлэг ихээхэн ач холбогдолтой.</p> <p>- Хоршоо, борлуулалтын сүлжээг бий болгож, хөгжүүлэх ажлыг салбар, орон нутгийн удирдлагын зүгээс эрэгтэй, эмэгтэй залуу малчдын оролцоо, санаачилгад үндэслэн, мэдлэг ойлголтыг бий болгож хөгжүүлэхээс эхлүүлэн системтэйгээр, удаан хугацаанд тогтвортой анхаарч ажиллах</p>

<p>- Малаа маллангаа айлын мал давхар харах замаар орлогоо нэмэгдүүлэх боломж эрэгтэйчүүдэд илүү байна.</p>	<p>- Залуу малчдын мөнгөн орлогын мэдээллээр, МАА-гаас олж буй орлого амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур, харин МАА-н бус орлогыг нэмснээр амьжиргааны баталгаажих түвшнээс бага зэрэг илүү гарч байгаа тул ноолуур, бусад ашиг шимийг бүрэн ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн судалгааны ажлыг эхлүүлэх, энэ талаарх сайн туршлагыг судлах</p>
<p>Гурав. Өрх, гэр бүл дэх жендэрийн уламжлалт бүтэц, соёлыг өөрчлөх чиглэлд:</p>	
<p>- Залуу малчдын хувьд мал хөрөнгөний бүртгэл болон өрхийн орлого, мал хөрөнгө хуваарилах мал, бүтээгдэхүүн, эд зүйлээ захиран зарцуулах шийдвэрт эрэгтэйчүүд, өрхийн орлогыг зарцуулахад эмэгтэйчүүд түлхүү эрх мэдэлтэй байна.</p> <p>- Хөдөлмөрийн хуваарьтуламжлалт хандлага илэрч байгаа ч эмэгтэй малчид сургууль, цэцэрлэгийн хүүхдээ дагаад төв суурин газар тусдаа амьдрах болсноор МАА-н хөдөлмөрийн үйл ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн оролцоо хумигдаж, өрхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байгаагийн хамт нийгмийн олон талт асуудлыг дагуулж байна гэж оролцогчид дүгнэв.</p> <p>- Залуу малчин өрх тусдаа амьдарч, отор нүүдлийн давтамж ойртсоноор эрэгтэйчүүдийн хөдөлмөрийн ачаалал нэмэгдэх төлөвтэйг чанарын судалгааны дүн харуулж байна.</p> <p>- Өрхийн зориулалттай эд хөрөнгийн ихэнхийг залуу эрэгтэй малчдын хэрэгцээнд ашиглаж байгаа бөгөөд гэрийн хөдөлмөрийг хөнгөвчлөх техник хэрэгслийн ашиглалт өсөж байгаа ч МАА-н үйлдвэрлэл дэх хөдөлмөрийг хөнгөвчлөх техник хэрэгслийн хувьд Сэлэнгээс бусад нутагт дэвшил гараагүй байна.</p> <p>- МАА-н хөдөлмөрийн цаг наргүй үргэлжилсэн, биеийн хөдөлмөрт суурилсан байдал болон ахуйн нөхцөл байдал нь залуус, тэр дундаа эмэгтэйчүүдийг МАА-д татах бус түлхэх хүчин зүйлс болох юм.</p>	<p>- Өрхийн тэргүүний нэр дээр мал, эд хөрөнгө бүртгэгдэж байгааг нягтлан, А данс бүртгэл, бусад хөрөнгийг өрхийн гишүүдийн хамтран өмчлөгчийн нэрээр бүртгэхээр холбогдох хэм хэмжээгээр зохицуулах, маягт, удирдамжаар хангах.</p> <p>- Малчин эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих бага оврын тоног төхөөрөмж (айраг бүлэгч, хийн зуух, цагаан идээ хатаах хүлэмж, шар сүү шахагч, худгийн гар мотор, сүүний машин, сүү ариутгагч, масло, цөцгий цохих машин, хөргүүр, сүүн бүтээгдэхүүн савлагч г.м)-ийг нэвтрүүлэх, хөнгөлттэй үнэ, хүүгүй зээлээр худалдан авах боломжийг бүрдүүлэх, техник хэрэгслийн талаар мэдлэгжүүлэх,</p> <p>- МАА-н хөдөлмөрийг хөнгөвчлөх тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх нь зөвхөн хөдөлмөр хөнгөвчлөөд зогсохгүй органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх давхар ач холбогдолтой байна.</p> <p>- Малчин өрх, гэр бүл дэх шийдвэр гаргах эрх мэдэл нөхөр, эрэгтэйчүүдэд хэт давамгайл байгаа нь эмэгтэйчүүдийг малчин болохоос татгалзахад хүргэх нэгэн хүчин зүйл болох тул гэр бүл дэх жендэрийн эрх тэгш байдал хангахын ач холбогдол, арга замын талаарх мэдлэг, хандлагыг малчдад хөгжүүлэх шаардлагатай байна.</p>
<p>Дөрөв. Газар эзэмших, өмчлөх, бэлчээрийн хомсдлыг бууруулах чиглэлд:</p>	
<p>- Эрэгтэй, эмэгтэй залуу малчдад тулгамдсан асуудлын нэг бол байршил сайтай (бэлчээр, худаг, ус сайтай г.м) өвөлжөө хаваржааны газар, хадлангийн газар олж авах, эзэмших, өмчлөх асуудал юм.</p>	<p>- Мал тооллогын анхан шатны бүртгэлийн маягт дахь өрхийн үндсэн мэдээлэл хэсэгт өрхийн тэргүүлэгчийн овог, нэр, регистрийн дугаарыг оруулахын зэрэгцээ эхнэр\эмэгтэйчүүдийн овог, нэр, регистрийг хамтад нь бүртгэх нь мал хөрөнгөө өмчлөх адил тэгш боломжоор хангах юм. Иймд УСХ-ны даргын 2019 оны А/152 тушаалаар баталсан "Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын М1 маягтад дээрх өөрчлөлтийг оруулах асуудлыг ЖҮХ, ХХААХҮЯ-тай хамтран шийдвэрлэх шаардлагатай юм.</p>

<p>- Цөөн малтай эмзэг бүлгийн малчдын цөөн хэсэг өвөлжөөний газраа хувьчилж аваагүй байхад чинээлэг малчид бусдын өвөлжөө, хаваржаа бууц, хондыг худалдан авах эсвэл түрээслэх замаар бэлчээрээ өргөтгөж байна. Иймээс малчдын эдийн засгийн чадамж бэлчээр ашиглалтад нөлөөлж, тэгш бус байдал гүнзгийрэх төлөв ажиглагдаж байгаа бөгөөд цөөн малтай малчид, өрх толгойлсон цөөн малтай эмэгтэйчүүдийн амьжиргаанд цаг уурын хүндрэл, бэлчээрийн хомсдол илүү хүнд тусах хандлагатай байна.</p> <p>- Бэлчээрийн доройтол, хомсдол залуу малчдын дунд удаан хугацаагаар эрэгтэйчүүд дангаар буюу гэр бүлээсээ тусдаа амьдрахад хөтөлж, энэ нь нийгмийн харилцаанд оролцох, гэрлэхэд нь сөргөөр нөлөөлж, улмаар БЗДХӨ-өөр халдварлах эрсдэлийг өсгөж болзошгүй юм.</p> <p>- Залуу малчид бэлчээрийн даацын талаар харьцангуй мэдээлэлтэй ч бэлчээрийн доройтлыг хэрхэн бууруулах талаар харилцан адилгүй мэдлэгтэй, дасан зохицох, хариу арга хэмжээ авах чадамжаар дутмаг байна.</p> <p>- Мөн бэлчээрийн доройтлолтой худаг усны хангамж холбогдож байгаа бөгөөд энэ нь жендэрийн үр нөлөөтэйг харгалзан нэмэгдүүлэх шаардлага дэвшигдэж байна.</p>	<p>- Өвөлжөөний газраа хувьчилж аваагүй эмзэг бүлгийн малчдын судалгааг явуулж, тэдгээрийн газар өмчлөх эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх чиглэлд сумдын газрын даамлууд анхаарч ажиллах шаардлагатай байна. Цаашлаад бэлчээрийг нийтийн эзэмшлийн хэлбэрээр ашиглаж байгаа ч өвөлжөө, хаваржаа нь ямар айлын мэдэлд бүртгэгдсэнээс хамаарсан тэгш бус байдал бий болсон тул аймаг, сумдын түвшинд бэлчээр ашиглалтыг малчдын адил тэгш оролцоотойгоор шийдвэрлэх зохицуулалтыг бий болгох.</p> <p>- Уур амьсгалын өөрчлөлтөд зохицон аж ахуй, амьдрал үйл ажиллагааг өөрчлөх, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадамжийг залуу малчдад хөгжүүлэхийн тулд янз бүрийн бүлгийн малчдыг адил тэгшээр идэвхтэйгээр оролцуулсан чадавхжуулах арга хэмжээг системтэйгээр хүргэх. Тухайлбал, малын тоо толгойг тогтвортой хэмжээнд барих, сүргийн зохистой бүтцийг хадгалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах зэргээр эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг түшиглэсэн оролцоог нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой тул нутгийн онцлогийг харгалзсан органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах чадамжийг хөгжүүлэх шаардлагатай байна.</p> <p>- Тал, говь хээрийн бүсэд бэлчээрийн талбайг нэмэгдүүлэх талаас худаг усны хангамжийг сайжруулах, ингэхдээ чинээлэг малчдад гэхээсээ амьжиргааны ялгаатай бүлгүүд адил тэгшээр ашиглах, хүртэх боломжийг бүрдүүлэх. Цаг их зарцуулдгийн улмаас үйлдвэрлэлийн бусад үйл ажиллагааг хязгаарлаж, нутгийн бусад малчидтай зөрчилдөх үндэстэй байгаа тул худгийн моторгүй малчдад мотор худалдан авахад зээлийн хэлбэрээр тусалцаа үзүүлэх. Нийтийн эзэмшлийн худгийг хувийн мэтээр хэрэглэхээр санаархаж буй малчдад хариуцлага тооцох зохицуулалтыг нэвтрүүлэх.</p> <p>- Цаг уурын хүндрэл эмзэг бүлэг, өрх толгойлсон эмэгтэйчүүд, цөөн малтай залуусын амьжиргаанд ихээхэн хүнд тусаж байгаа тул малын тэжээл, малын эм тариаг хөнгөлөлттэй үнээр худалдан авах гэрээ хэлцлийг ААНБ-тай байгуулах.</p> <p>- Цаашлаад байгалийн хадлангаас хамаарсан байдлыг өөрчилж, малын тэжээлийг бүлэг, хоршоогоор тариалж ашигладаг болгон хөгжүүлэх. Үүнд газар, техник хэрэгслийн хөрөнгө оруулалт, арга зүйн дэмжлэг чухал ач холбогдолтой.</p>
--	--

<p>Тав. Банк, санхүүгийн үйлчилгээ авах, санхүүгийн боловсролыг ахиулах чиглэлд:</p>	<p>Тав. Банк, санхүүгийн боловсролыг ахиулах чиглэлд:</p>
<p>- Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүтэй зээл авдаг хандлага илэрсэн ч судалгаанд оролцсон бэлэвсэн, өрх толгойлсон залуу эмэгтэйчүүд “зээл”-ийн үйлчилгээнд хамрагдах боломжоор тааруу байна.</p> <p>- Судалгаанд хамрагдсан залуу малчдын дунд “зээл” авсан нь нийтлэг байгаагийн эсрэгээр цөөхөн малчид хадгаламжтай байна. Эрэгтэйчүүдийн хувьд зээл авах нь эмэгтэйчүүдээсээ цөөн атлаа хадгаламжтай байдлаараа давамгайл байгаа тул нэг талаас эрэгтэй залуу малчид санхүүгийн хувьд илүү давуу боломжтой, нөгөө талаас орлогыг зарцуулах эрх мэдэл бүхий эмэгтэйчүүдэд санхүүгийн боловсрол олгосноор орлогоо хуримтлуулах, зээл тавилгүйгээр хэрэглээний зардлаа бүрэн даах, цаашлаад аж ахуйдаа хөрөнгө оруулах боломж нэмэгдэхээр харагдаж байна.</p> <p>- Эрсдэлийн даатгалд залуусын цөөн хэсэг тодруулбал чинээлэг хэсэг нь түлхүү хамрагдах хандлагатай байгаа бөгөөд цөөн малтай малчдын хувьд эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжоор хомс болох нь илэрлээ.</p>	<p>Зургаа. Малчдын бүлэг, нөхөрлөл дэх гишүүнчлэл, нийгэм-хамт олны үйл ажиллагаан дахь оролцооны хувьд</p> <p>- Аймаг, сумдын түвшинд малчдын оролцоот байгууллага, хамтын бүлэг, нөхөрлөл, малчны хоршооны үйл ажиллагаа (ноосны урамшуулал авахаар хязгаарладаг) сул, гишүүнчлэлтэй малчдын хувьд идэвхгүй оролцоо давамгайлж байна.</p> <p>- Малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоо ихэнхдээ олон улсын байгууллагын дэмжлэг, санаачилгаар хэрэгждэг, төсөл хөтөлбөр дуусахад үйл ажиллагаа суларч, зогсдог чиг хандлага зонхилж байна.</p> <p>- Эрэгтэй, эмэгтэй малчдын хэрэгцээ, ашиг сонирхлын асуудлаар шийдвэр гаргахдаа тэдний оролцоог заавал хангах арга зам, хувилбарыг эрэлхийлэх.</p> <p>- Малчдын хоршоог жинхэнэ утгаар нь хөгжүүлснээр малчид, МАА-н бүтээгдэхүүнээр органик бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ хөрөнгө оруулж, ченжээр дамжуулахгүйгээр хэрэглэгчдэд хүргэж эдийн засгийн хувьд илүү үр өгөөжтэй байх боломж болох тул төрөөс энэ чиглэлд хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийг сайжруулах шаардлага дэвшигдэж байна.</p>
<p>- Банк, даатгалын үйлчилгээ авах боломж хүйсээр ялгаа багатай ч цөөн малтай малчид, тэр дундаа өрх толгойлсон залуу эмэгтэйчүүдийг дэмжсэн зээлийн болон даатгалын үйлчилгээг нэвтрүүлэх.</p> <p>- Малчдын санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх тэр дундаа эмэгтэй малчдын хуримтлал бий болгох чиглэлд чадавхжуулах</p>	<p>- Малчдын бүлэг, нөхөрлөл, хоршооны тухай мэдлэг ойлголт, хандлагыг сайжруулахад дорвитой анхаарч, хоршооны харилцан ашигтай, хөдөлмөрөө хуваарилсан, хяналттай, итгэлцэл бүхий болгохуйц хууль, дүрэм журмын өөрчлөлтийг зайлшгүй хийх шаардлага бий болоод байна. Мөн бүлэг, хоршоог доороос санаачилгатай, гишүүдийн оролцоог жинхэнэ утгаар хангасан байхаар, нэг сум, аймгаар хязгаарлалгүй байгуулж, дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.</p> <p>- Малчдын бүлэг, нөхөрлөл байгуулагдсан ч тогтвортой үйл ажиллагаа явуулж ирээгүй шалтгааныг нарийвчлан судалж, хууль, дүрэм журмын өөрчлөлтийг зайлшгүй хийж, нотолгоонд тулгуурласан бодлого хэрэгжүүлэх шаардлагатай юм. Сум хөгжүүлэх санг хоршоог дэмжих санг болгож байгаа нь сайшаалтай ч ил тод, нээлттэй байдал гишүүдийн адил тэгш оролцоог хангахгүйгээр үр дүнтэй байж чадахгүй.</p> <p>- 2021 онд АХБ, ЖҮХ-ноос “Хүндлэлд хүйс хамааралгүй” аяныг зорилтот хүн ам түүний дотор малчдад хүргэхэд подкаст, стори, шторк зэргийг ашигласан нь малчиндаа хүрсэн үйл ажиллагаа болсон сайн туршлага байгаа тул малчдын бүлэг, хоршооны ач холбогдлын талаар ойлгуулахад ашиглах.</p>

<p>Долоо. Эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын үйлчилгээний хүрээнд</p>	
<p>- Залуу эрэгтэй малчдын эмнэлгийн үйлчилгээ авах байдал эмэгтэйчүүдээс доогуур байна.</p> <p>- Судалгаанд хамрагдсан залуусын дунд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хамрагдалт тааруу, тэр дундаа эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бага зэрэг доогуур байна.</p> <p>- Хэдийгээр дийлэнх залуу эмэгтэйчүүд жирэмсэн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээг авч чадаж байгаа ч алслагдмал нутгийн, эмзэг бүлгийн эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх хүртээмжийг сайжруулах хэрэгцээ байсаар байна.</p> <p>- Хөдөөгийн малчин эмэгтэйчүүдийн дунд бэлгийн харилцаанд орох, ЖСАХ хэрэглэх шийдвэр гаргах эрх мэдлийн хувьд бусад байршлын эмэгтэйчүүдээс дутмаг байгаа тул хөдөөгийн залуусын дунд жендэр, бэлгийн боловсрол олгох ажлыг сайжруулах хэрэгцээ байна.</p> <p>- Татвар төлдөг залуу эрэгтэй, эмэгтэй малчид тун цөөн хувийг эзэлж байна. Гэхдээ нийгмийн халамжийн үйлчилгээ, дэмжлэгт хамрагдах хүсэл сонирхол бага бус байна.</p> <p>- Малжуулах хөтөлбөрт судалгаанд хамрагдсан залуу малчдын тун цөөхөн хувь нь хамрагдсан бөгөөд 2 ба түүнээс дээш гишүүнтэй өрхөд олгодог тул эмэгтэй малчид эрэгтэйчүүдээс илүү хамрагджээ. Малчин залуусын дунд малжуулах хөтөлбөрийг зохих өөрчлөлт оруулж үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгцээ байна.</p>	<p>- Залуу малчдад нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдахын ач холбогдлыг таниулан, хамрагдалтын түвшинг нэмэгдүүлэхэд дорвитой анхаарах.</p> <p>- Алслагдмал нутгийн залуу малчдад жирэмсэн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэхэд хувилбарт үйлчилгээ (явуулын болон суурин)-г нэвтрүүлэх.</p> <p>- Эрүүл мэндийн боловсрол, эрүүл зохистой хооллолт, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүй, бэлгийн боловсрол, ЖСАХ, ДОХ, ХДХВ, БЗДХӨ-өөс сэргийлэх сургалт, арга хэмжээг хүртээмжийг нэмж чадах оновчтой арга (насан туршийн боловсролын төвийн сургалтын хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэх)-ыг сонгон залуу малчдад хүргэх. Насан туршийн боловсролын төвийн багш нарыг энэ чиглэлд чадавхжуулахад дорвитой анхаарах. ХХААХҮЯ-ны зүгээс байгаа бүтцээ ашиглан малчин залууст хүргэхэд анхаарч ажиллах.</p> <p>- Малчдад эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх явуулын (багийн үзлэг, оношлогоо, bus үйлчилгээ) үйлчилгээг тогтмол хүргэх боломжоор хангахад анхаарах.</p> <p>- Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг кабинетыг бүх аймгуудад байгуулах, үйл ажиллагааг тогтвортойгоор дэмжих.</p> <p>- Сумдад шүд, эрүү нүүрний эмнэлгийн үйлчилгээг хүргэхийн тулд хүний нөөц, техник хэрэгслээр хангах.</p> <p>- Малжуулах хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа, зээлийг буцаан төлөх хугацаа, хуваарь, хүртээмж, хэмжээнд зохих өөрчлөлт оруулан, зогсоосон байгааг сэргээн үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.</p> <p>- Зорилтот бүлгийн шаардлагыг хангаж байгаа атлаа нийгмийн халамжийн тусламж дэмжлэгийн гадна үлдэж буй малчдыг судлан тодорхойлж, зохих хөтөлбөрт хамруулах</p>
<p>Найм. Боловсролын үйлчилгээний хүрээнд:</p> <p>- Судлагдсан залуу малчид хүүхдээ сургахын тулд хоёр тусдаа амьдрах, хүүхдэдээ байнгын анхаарал халамж тавьж чадахгүй, хүүхдээ СӨБ-д хамруулж чаддаггүй, ковид-19 цар тахлын үед интернет сүлжээгүй, сүлжээ муу учраас хүүхдээ цахим, теле хичээлд хамруулахад хүндрэлтэй зэрэг бэрхшээл боловсролын үйлчилгээ авахад нь тулгарч байна.</p> <p>- Эцэг эхчүүдэд гэр бүлийн хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ялангуяа хөвгүүдийн боловсрол эзэмшилтэд ялгаварлан гадуурхалт үүсгэхгүй байж, хөвгүүдийн боловсролыг орхигдуулахгүй байлгахад анхаарах сургалт сурталчилгааг явуулах</p> <p>- Айлд амьдарч байгаа хүүхдийн бүртгэл судалгаа гаргаж тэдний онцлог нөхцөл байдалд чиглэсэн бодлого шийдвэрийг гаргах</p>	

<p>- Сумдын сургуульд багш байнга солигддог, чадамж сул багш нар олширсон, дотуур байрны үйлчилгээ тааруу зэрэг хүндрэлтэй асуудал байна.</p> <p>- Дотуур байранд амьдарч буй хүүхдүүд хангалттай, эрүүл аюулгүй хоол хүнс болон ариун цэврийн байгууламжаар хангагдаагүй хэвээрээ, хүүхэд хамгааллын зөрчил гарч байгаагийн улмаас эцэг эхчүүд хүүхдээ айлд байлгах эсвэл өөрсдөө хоёр тусдаа амьдрахыг илүүд үзэж байна. Гэвч аймаг, сумын төвд айлд сууж байгаа хүүхдүүдэд хүүхдийн хөгжил, хамгаалал, аюулгүй байдлын асуудал хөндөгдсөөр байна.</p> <p>- Эмэгтэй залуу малчдын олонх халуун усанд орох, ном худалдан авах, номын сангаар үйлчлүүлэхэд хүндрэлтэй байгаагаас харахад нийгэм-соёлын үйлчилгээний гадна малчид орхигдож байгаа бөгөөд энэ нь залуусыг, тэр дундаа эмэгтэйчүүдийг МАА-аас татгалзахад нэрмээс болох юм.</p>	<p>- Дотуур байранд дасан зохицох нөхцөлийг бүрдүүлэх (Увс аймгийн Бөхмөрөн сумын ЕБС-ийн сайн туршлагыг нэвтрүүлэх)</p> <p>- Дээд боловсролтой малчдын дунд МАА, ХАА-н чиглэлийн мэргэжил эзэмшээгүй залуус зонхилж байгаа тул ЕБС-ийн сурагчдад мэргэжлээ зөв сонгоход нь туслах ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг чанаржуулах, жендэрийн мэдрэмжтэйгээр хүргэх.</p> <p>- Сум, аймаг хооронд оторлон нүүдэллэн амьдрах болсон тул тухайн орон нутагт бүртгэлгүй малчдын хүүхдийг сургууль, цэцэрлэгт хамруулах</p> <p>- Насан туршийн боловсролын агуулгад малчдад чиглэсэн сургалтын хөтөлбөр багтдаг ч чанар, хүртээмж сул байгаа тул эрэгтэй, эмэгтэй залуу малчдын хэрэгцээ, онцлогт тохирсон арга зүйд тулгуурласан сургалтыг хүргэх зардлыг санхүүжүүлэх. Насан туршийн боловсролын хөтөлбөрт хамрагдсан хүмүүсийн мэдээллийг нас, хүйс, ажил мэргэжлээр нь ангилан бүртгэл, нэгтгэлийг сайжруулах.</p>
<p>Ес. Гэр бүл, гэрлэлтийн хүрээнд:</p>	
<p>- Судалгаанд хамрагдсан залуу малчин эмэгтэйчүүдэд бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, эрэгтэй малчдын хувьд бүрэн дунд ба түүнээс доош боловсрол эзэмшсэн нь зонхилсон нь охиноо илүү өндөр боловсролтой болгох гэсэн эцэг эхчүүдийн жендэрийн хэвшмэл үзэлтэй холбогдож байна.</p> <p>- Гэхдээ 32-34 насны боловсролгүй эсвэл бага боловсролтой эрэгтэйчүүдийн дунд гэрлээгүй байдал бусад боловсролтой эрэгтэйчүүдээс өндөр байна.</p>	<p>- Залуу малчдын гэр бүл, гэрлэлт, нийгмийн асуудалд холбогдох статистикийн тоон мэдээллийг нас, хүйс, нийгмийн байдлаар нарийвчлан цуглуулж, бодлого, төлөвлөлтөд ашиглах.</p> <p>- Залууст танилцах, нөхөрлөх, хамтын сүлжээг бий болгох үүднээс залуучуудын чуулга уулзалт, аяныг давтамжтайгаар зохион байгуулах, залуучуудын бүлэг, клуб байгуулах санаачилгыг дэмжих, бусад орон нутгуудтай хамтран ажиллах боломжийг орон нутгийн удирдлагаас бүрдүүлэх.</p> <p>- Жендэрийн хэвшмэл үзэл бүхий соёл нь залуусын мэргэжил сонголт улмаар гэрлэлтийн харилцаанд нөлөөлж байгаа тул эцэг эх, залуу эрэгтэй, эмэгтэйчүүд болон талуудад жендэрийн боловсрол олгох үйл ажиллагааг тусгайлсан сургалтын хөтөлбөрөөр ИНБ-уудын оролцоотойгоор хэрэгжүүлэх.</p> <p>- Гэр бүлийн хүчирхийллийн илрүүлийг сайжруулах, хохирогчийг хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх, хөдөө, орон нутагт амьдарч байгаа залуу малчдад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн хуулийг сурталчлан таниулах</p>

<p align="center">Арав. Хүйсээр ангилсан мэдээллийн тогтолцоог сайжруулах чиглэлд</p>	
<p>- Залуу малчдад хамаарах хүйсээр ангилсан мэдээллийг бүрдүүлэх, нэгтгэх, ашиглах тогтолцоо хангалттай түвшинд төлөвшиж хөгжөөгүй байна.</p>	<p>Сум, аймаг, үндэсний хэмжээнд дараах мэдээллийг ҮСХ хүйсээр ангилан бүрдүүлж, нэгтгэх шаардлагатай байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Малчин, мал бүхий иргэдийн мэдээллийг нас, хүйс, боловсролын түвшин 2. Малчин өрх, малын тоо толгойн хэмжээ, өрхийн тэргүүний хэв шинжээр (эрэгтэй, эмэгтэй тэргүүтэй өрх) 3. Малчин, гэрлэлтийн байдал (гэрлэлт, цуцлалт, бэлэвсрэлт г.м) 4. Малчин, шилжих хөдөлгөөн 5. Тусдаа амьдарч буй өрх 6. Малчин, айлд мал маллаж буй хүүхэд, тавиул хүүхдийн тоо 7. Өөр орон нутагт отроор явсан малчин, хүйсээр 8. Малчдын дундах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, осол гэмтлийн төрөл, тоо, захиргааны арга хэмжээгээр шийтгүүлсэн малчдын тоо, хүйсээр 9. Байгалийн гамшгаар нас барсан малчдын тоо, хүйсээр 10. Байгалийн гамшгийн эдийн засгийн хохирол, өрхийн хэв шинжээр, малын тоо толгойн бүлгээр Г.м

НОМ ЗҮЙ

- ОУХБ. 2016. *Баянхонгор, Өвөрхангай аймгийн залуучуудын орлогын баталгааг сайжруулах туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан*. Улаанбаатар
- МУЗГ. 2018. *Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын талаар баримтлах бодлого (2018-2025)*. Улаанбаатар
- МУЗГ. 2018. *Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр*. Улаанбаатар
- МУЗГ. 2010. *Монгол мал үндэсний хөтөлбөр*. Улаанбаатар
- МУЗГ. 2020. *Монгол малчин үндэсний хөтөлбөр (2021-2024)*. Улаанбаатар
- ХЭҮК. 2021. *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл*. Улаанбаатар
- ХЭҮК. 2019. *Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн хэрэгжилт: Хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, эрүүл мэнд” судалгаа*. Улаанбаатар
- ҮСХ. 2017. *Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга*. Улаанбаатар
- ҮСХ. 2018. *Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга*. Улаанбаатар
- ҮСХ. 2019. *Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга*. Улаанбаатар
- MONFEMNET, ARROW, SRHR for all, SIDA. 2013. *Нөхцөл байдлын үнэлгээ: Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх түгээмэл эрхийн хэрэгжилт*. Монгол улс. Улаанбаатар
- ҮСХ, НҮБХАС, НҮБХС. 2018. *Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа -2018*. Улаанбаатар. https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=SISS2018_report_mn.pdf&ln=Mn (2021 оны 5 сарын 15-нд)
- ЭМХТ, ДЭМБ. 2016. *Эрүүл мэндийн үзүүлэлт-2016*. Улаанбаатар
- ҮСХ. 2017. *Нийгмийн халамж, даатгал-2017*. Улаанбаатар (https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Social_insurance_and_welfare_2017.pdf&ln=Mn) 2021 оны 5 сарын 15-нд
- ХНХЯ, ХНХСХ. 2018. *Малчдын аж байдлын судалгаа*. Улаанбаатар.
- www.1212.mn
- <https://www.greenmongolia.mn/post/62895>
- Өвөрхангай аймгийн ИТХ. 2016. *Өвөрхангай аймгийн залуу малчин” дэд хөтөлбөр (2016-2020 он)*
- БСШУСЯ, 2010. *Насан туршийн боловсролын амьдрах ухааны сургалтын хөтөлбөр*. Улаанбаатар
- НҮБХС, ХТҮГ. 2014. *Түр хугацаагаар айлд амьдарч буй хүүхдийн хамгаалагдах эрхийн хэрэгжилт*. Улаанбаатар
- Стандарт, хэмжил зүйн газар. 2019. *Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээний ерөнхий шаардлага*. Улаанбаатар



Хаяг / Байршил: Монгол Улс,
Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг,
6-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-20
Жендэрийн үндэсний хорооны байр

Утас: 70071115

Шуудангийн хаяг: Улаанбаатар 14200-0063

Цахим хуудас: www.ncge.gov.mn